

“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны А/105 дугаар тушаалаар батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д заасан арга зүйг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан. Энэхүү үндэсний хөтөлбөрт Засгийн газрын 2011 оны 113 дугаар тогтоолоор зарим нэмэлт, өөрчлөлт орсон.

Хөтөлбөрийн зорилго

Иргэн, төр, олон нийт, хувийн хэвшлийн зохистой оролцоог хангах замаар хүн амыг тэжээллэг, эрүүл ахуйн баталгаатай хүнсээр жигд, хүртээмжтэй, тогтвортой хангаж, эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, Монгол брэндийн органик хүнсийг бий болгож гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөхүйц эдийн засгийн шинэ чадавхийг бүрдүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 13 зорилтыг хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр тэргүүлэх чиглэл. Хүнсний аюулгүй байдлыг хангах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын таатай орчин бүрдүүлэх.

Зорилт 1. Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг ойрын болон хэтийн хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсронгуй болгох;

Зорилт 2. Эдийн засаг, санхүү, бизнесийн таатай орчин бүрдүүлж дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

Зорилт 3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын бүтэц, салбар дундын зохицуулалт болон боловсон хүчний чадавхийг сайжруулах;

Хоёрдугаар тэргүүлэх чиглэл. Хүн амыг тэжээллэг, эрүүл ахуйн баталгаатай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах, хэрэглээн дэх үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний хувийн жинг нэмэгдүүлэх.

Зорилт 4. Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах;

- Зорилт 5.** Хот, хөдөөгийн болон улирлаас хамаарах хүнсний хүртээмжийн ялгааг багасгах;
- Зорилт 6.** Байгалийн гамшиг, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнсний хомсдлын үед хүн ам, ялангуяа эмзэг бүлгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах;
- Зорилт 7.** Хүнсний үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулж Монгол брэндийн хүнс экспортлох нөхцөлийг бүрдүүлэх;
- Гуравдугаар тэргүүлэх чиглэл. Хүнсний бүтээгдэхүүн, ундны усны эрүүл ахуйн баталгааг хангах хяналт, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох.**
- Зорилт 8.** Хүнсний түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүх дамжлагад хөдөө аж ахуй, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлуудыг нэвтрүүлж бүтээгдэхүүний эрүүл ахуйн баталгааг хангах;
- Зорилт 9.** Хүнсний аюулгүй байдлын хяналт, мэдээллийн сүлжээ, үйл ажиллагааг сайжруулах;
- Зорилт 10.** Ундны усны хүртээмж, чанар, эрүүл ахуйг сайжруулах;
- Дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл. Хүнсний тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хооллолтыг дэмжих, хоол, тэжээлийн дутлыг бууруулах, зонхилох халдварт бус өвчнөөс сэргийлэх.**
- Зорилт 11.** Монгол хүний зохистой хооллолтын зөвлөмжийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, хоол тэжээлийн талаархи хүн амын боловсролыг дээшлүүлэх;
- Зорилт 12.** Хоол тэжээлтэй холбоотой өвчин, эмгэгээс сэргийлэх, хяналт тавих;
- Зорилт 13.** Зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Энэхүү хөтөлбөр нь 2009-2016 онд 2 үе шаттайгаар хэрэгжинэ.

- Эхний үе шат: 2009-2012 он.
- Хоёр дахь үе шат: 2013-2016 он.

Хүлээгдэж байгаа үр дүн, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт /2013-2016/

Хөтөлбөрийн эхний үе шат /2009-2012 он/-нд хүрэхээр төлөвлөсөн 21 үр дүн, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 78.0 хувьтай дүгнэгдсэн. Хөтөлбөрийн 2 дахь үе шат /2013-2016 он/-нд 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараах 17 үр дүн гарахаар төлөвлөсөн.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

Нэгдүгээр тэргүүлэх чиглэл.	
1.	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, ариун цэврийн хяналт олон улсын нийтлэг жишигт хүрсэн байна.
2.	Хүнсний аюулгүй байдлын үнэлгээг олон улсад хэрэглэдэг нийтлэг арга, үндэсний стандартад нийцүүлэн хийж, үр дүнг нийтэд мэдээлдэг болсон байна.
Хоёрдугаар тэргүүлэх чиглэл.	
3.	Хот орчмын сүүний чиглэлийн фермерийн аж ахуйнуудаас жилд 40.0 мянган тонн сүү нийлүүлдэг болж, үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээг 2012 оноос 2 дахин нэмэгдүүлнэ.
4.	Махны экспортыг 38.0 мянган тоннд хүргэж, хот суурингийн хүн амын хэрэгцээт махны 60-аас доошгүй хувийг үйлдвэрийн аргаар боловсруулдаг болсон байна.

5.	Хүнсний ногоо, өндөгний хэрэгцээг бүрэн, цөцгийн тосны 20, загасны 25, жимсний 15, будааны 5, ургамлын тосны 40-өөс доошгүй хувийг дотооддоо үйлдвэрлэдэг болсон байна. (Энэ заалтад 2011-04-13-ны 114-р тогтоолоор нэмэлт орсон)
6.	Гамшгийн үеийн нөөцийн гурилыг 20 хоногийн, цагаан будаа, элсэнчихрийг 15 хоногийн хэрэгцээтэй тэнцэх, стратегийн нөөцийн улаан буудайг нийт хэрэгцээний 50 хувьд хүргэсэн байна.
7.	Газар тариаланд хэрэглэх бордооны 30 хувийг, ургамал хамгааллын бодисын 20 хувийг дотооддоо үйлдвэрлэж, газар тариалангийн чиргүүл, дүүжин машины 50 хувь, өөрөө явагч техникийн 70 хувийг шинэчилсэн байна
8.	Бүх сумын 60-70 хувь нь бөөний худалдааны сүлжээ, салбартай болсон байна.
9.	Хот суурингийн орчимд хөдөө аж ахуйн болон боловсруулах үйлдвэрийн 25-аас доошгүй цогцолбор бий болно.
10	Тариаланд шаардагдах нийт үрийн 60-80 хувийг I-III зэргийн үрээр тариалдаг болж, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 54.0 мянган га-д хүргэж, нийт ургацын 15-аас доошгүй хувийг усалгаатай талбайгаас авдаг болно. (Энэ заалтыг 2011-04-13-ны 114-р тогтоолоор нэмсэн)
Гуравдугаар тэргүүлэх чиглэл.	
11	Хүнсний үйлдвэрүүдэд дотоод хяналтын тогтолцоо бүрэн нэвтэрч, чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг зах зээлээс буцаан татах журам бий болж мөрдөгдөнө.
12	Хүнсний үйлдвэрүүдийн 60 хувьд аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР), үйлдвэрийн эрүүл ахуйн зохистой дадал (GHP), үйлдвэрийн зохистой дадал (GMP) нэвтэрсэн байна.
13	Хөдөө аж ахуйн фермерүүдийн 55-аас доошгүй хувьд нь хөдөө аж ахуйн зохистой дадал (GAP) нэвтэрсэн байна.
14	Хоол хүнсээр дамжих өвчлөл буурсан байна
Дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл.	
15	Тав хүртэл насны хүүхдийн дундах тураал 3.8 хувь, өсөлт хоцролт 9.8 хувь, туранхай 0.2 хувь, Д аминдэмийн дутал 25 хувь, А аминдэмийн дутал 6 хувь, цус багадалт 10.7 хувь, 7-12 насны хүүхдийн бахлуур өвчний тархалт 3 хувь, хөхүүл эхчүүдийн дундах А аминдэмийн дутал 11.5 хувь, жирэмсэн эмэгтэйчүүдийн цус багадалт 10 хувь хүртэл буурч, Монгол Улсын Мянганы Хөгжлийн зорилт хангагдсан байна.
16	Хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэж байгаа хүн амын хувь 2012 оныхоос 50 хувь буурсан байна.
17	Хүн амд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үндэсний тогтолцоог бүрдүүлсэн байна.

Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөр хэрэгжих 8 жилийн хугацаанд Засгийн газар, Донор байгууллага болон ТББ, хувийн хэвшилээс нийт 1290.2 сая ам.доллар шаардлагатай гэсэн тооцоог хөтөлбөр боловсруулсан багаас хийсэн. Монгол банкны ханшаар 1ам.доллар=1435.41₮ /2009 оны III улирлын байдлаар/ тул нийт санхүүжилт 1850566.5 сая төгрөг буюу 1850.6 тэрбум төгрөг болно. Хөтөлбөрийн хэрэгжилтэд 2014 онд 607.0 сая төгрөг төлөвлөж 414.03 сая төгрөг зарцуулсан байна. Улсын төсөв болон бусад эх үүсвэрээс нийт 132.65 тэрбум төгрөгийг хүнсний үйлдвэрүүдэд эргэлтийн хөрөнгийн болон төсөл хэрэгжүүлэх зээл, урамшуулал хэлбэрээр олгожээ. НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх” техник туслалцааны төслийн хүрээнд 69634 ам долларыг чадавхи бэхжүүлэх, зөвлөх үйлчилгээний чиглэлээр зарцуулсан байна. Харин орон нутаг, төрийн бус байгууллага болон хувийн хэвшилээс хөтөлбөрийн хүрээнд оруулсан хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл дутмаг байсан тул тайлант оны санхүүжилтийн дүнд оруулаагүй болно.

ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, сая төгрөгөөр

Зардлын нэр		2014 он	
		Төсөв	Гүйцэтгэл
Улсын төсөв	“Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	607.0	414.03
	ШУТ-ийн сан		47.82
	Буудайн урамшуулал	25000.0	25000.0
	Махны урамшуулал	14000.0	9500.0
	Чингис бонд /2013.08/	/сүү/	33100.0
		/хүлэмж	22170.0
	ЖДҮХС		383.0
Гадаадын зээл тусламжийн хөрөнгө	“Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх” /НҮБ-ын ХХААБ/ төсөл /2014-2016/		69634 ам доллар
Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр /2012.10/	Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, Эрчимжсэн АА-г хөгжүүлэх		74900.0
			38100.0
	Махны нөөц бүрдүүлж, үнэ тогтворжуулах	77000.0	77000.0
	Гурилын үнийг тогтворжуулах	59000.0	49000.0
Нийт дүн		175607.0	329200.8

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОЙМ

Зорилт 1. Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг ойрын болон хэтийн хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсронгуй болгох хүрээнд:

Үйл ажиллагаа 1.1. Хүнсний түүхий эд, малыг хүнсний зориулалтаар бэлтгэх, борлуулах, хүнсний бүтээгдэхүүний импорт, экспортын үйл ажиллагааны зохицуулалт, хяналтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

“Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийг 2011 онд, “Хүнсний тухай”, “Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай”, “Усны тухай” хуулиудыг 2012 онд шинээр болон шинэчлэн батлуулж, хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар боловсруулж буй “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, “Архидан согтуурахаас сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр”-ийн төсөлд санал өгсөн.

“Хүнс баяжуулах тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/37 дугаар тушаалаар байгуулж, ажлын хэсэг хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулсан. ҮХААЯ-ны ТНБД-ын 2014 оны А/170 дугаар тушаалаар “Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж, хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулав. “Органик хүнсний тухай” хуулийн төслийг үзэл баримтлалын хамт боловсруулж, Засгийн газрын 2014.11.21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, уг хуулийн төсөлд санал авахаар ХЗЯ-нд 2014.12.04-ний өдрийн 1/4470 тоотоор хүргүүлж үзэл баримтлалыг батлуулсан.

“Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын гурван удаагийн хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулсан боловч, зарим гишүүдийн саналаар түр хойшлуулсан болно.

ХШИҮ-70%

Үйл ажиллагаа 1.2. Стратегийн болон гамшгийн нөхцөл дэх хүнсний нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг шинэчлэн тогтоох, байршлыг оновчтой болгох.

УИХ-ын 2008 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрөл”-д УИХ-ын 2011 оны 42 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан. “Хүнсний тухай” хуулийн (шинэчилсэн найруулга) 3.1.6-д монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг “стратегийн хүнс” гэж томъёолсон.

Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолоор “Нөөцийн бараа, материалыг хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам”, “Гамшгийн нөөцөөс бараа материалыг захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журам”-ыг тус тус баталсан. Засгийн газрын 2012 оны 248 дугаар нууцын зэрэглэлтэй тогтоолоор стратегийн болон гамшгийн нөхцөл дэх хүнсний нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, байршлыг баталсан.

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Гамшиг онцгой байдлын үед хүүхэд, эмэгтэйчүүдэд үзүүлэх хоол тэжээлийн тусламж үйлчилгээ”-ний удирдамжийг боловсруулсан.

ХШҮ-100%

Үйл ажиллагаа 1.3. Органик, зохицуулах үйлчилгээтэй, биологийн идэвхитэй, тусгай зориулалтын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл импорт, худалдаа хэрэглээтэй холбоотой харилцааг олон улсын жишигт хүргэх.

“Хүнсний тухай” хуулийн (шинэчилсэн найруулга) 3.1.5-д мал аж ахуй, газар тариалангийн органик үйлдвэрлэлийн болон цэвэр байгалийн гаралтай Монгол Улсын болон олон улсын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүнийг “органик хүнс” гэж томъёолон органик хүнсний үйлдвэрлэлд дэмжлэг, урамшуулал үзүүлэхээр заасан. “Органик хүнсний тухай” хуулийн төслийг үзэл баримтлалын хамт боловсруулж, Засгийн газрын 2014.11.21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, уг хуулийн төсөлд санал авахаар ХЗЯ-нд 2014.12.04-ний өдрийн 1/4470 тоотоор хүргүүлж үзэл баримтлалыг батлуулсан. Европын Холбооны зөвлөлийн тогтоолоор баталсан “Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон хаяг шошгоны тухай хууль”-ийг орчуулж судалсан.

Хүнсний хууль эрх зүйн хорооны Органик хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, шошголох, худалдаалах удирдамж MNS CAS 32:2007-ийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд 4 багц стандартыг орчуулж, Стандартчилал, хэмжил зүйн газарт баталгаажуулахаар хүргүүлсэн.

1. Органик хөдөө аж ахуйн үндсэн зарчмууд /The Principles of Organic Agriculture/
2. Органик үйлдвэрлэл ба боловсруулалтад тавих үндсэн шаардлага /IFOAM Basic Standards for Organic Production and Processing/
3. Органик үйлдвэрлэл, боловсруулалтыг баталгаажуулах байгууллагын итгэмжлэлийн шалгуур /IFOAM Accreditation Criteria for Bodies Certifying Organic Production and Processing/
4. Европын холбооны Органик үйлдвэрлэл ба органик бүтээгдэхүүний шошгололт (EC) No 834/2007 тоот журам, зохицуулалт / Council Regulation (EC) No 834/2007 of 28 June 2007 on “Organic production and labelling of organic products”/

“Органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх журам”, “Байгаль орчинд халгүй, дэвшилтэт технологиор бүтээгдсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагад эко-тэмдэг олгох тухай журам” болон “Ногоон эдийн засгийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн төслийг тус тус боловсруулсан.

Органик хүнсний болон мал, амьтны тэжээлийн бүтээгдэхүүнийг гэрчлэх, хэрэглэгчид таниулах зорилгоор бүтээгдэхүүний шошго, сав баглаа боодол, зар сурталчилгаанд хэрэглэх “органик тэмдэг”-ийн загвар зохиох уралдааныг дүгнэж, шалгаруулсан. “Органик Монгол хүнс” тэмдэг, тэмдэглэгээ, “Шилжилтийн үеийн органик монгол хүнс” тэмдэглэгээний англи, монгол хэл дээрх загварыг “Патентийн тухай” хуулийн 5 дугаар зүйлд нийцүүлэн улсын бүртгэлд бүртгүүлэхээр бэлтгэж байна.

“Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай” хуулийн төслийг боловсруулсан.

“Баяжуулагч бэлдмэл, нэмэлт, цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах тухай журам”-ын төсөл боловсруулсан.

“Тусгай хоолны дэглэмтэй хүмүүс, нярай, бага насны хүүхэд, цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлд тавигдах шаардлагыг тогтоох тухай журам”-ыг ЭМ-ийн сайдын 2013.06.04-ний 207 дугаар тушаалаар баталсан. Энэ тушаалаар “Сургуулийн өмнөх болон сургуулийн дотуур байранд хамрагдаж буй хүүхдэд хоногт хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн, үндсэн шимт бодис илчлэгийн хэмжээ”, “Тусгай дэглэмтэй хүмүүс, цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан хоол үйлчилгээнд хориглох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалт”-ыг тус тус баталсан.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 1.4 болон 1.8. “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, Монгол хүний хоол тэжээлийн физиологийн нормыг мөрдүүлэх”, “Мал амьтан, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний тэжээллэг чанар, хүн амын хүнсний хэрэгцээ, хэрэглээг тодорхойлох нэгдсэн аргачлал боловсруулж мөрдүүлэх.

Эрүүл мэндийн сайдын 2008.12.04-ний өдрийн 257 дугаар тушаалаар баталсан “Хүн амын хоол тэжээлийн физиологийн норм”, ҮСХ-ны даргын 2009.01.26-ны өдрийн 01/177 тоот тушаалаар “Хүнсний аюулгүй байдал, хангамжийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг тус тус баталсан. Уг норм, аргачлалыг орон нутагт хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүнсний аюулгүй байдлын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог сайжруулах зорилгоор тооцох аргачлалд нэмэлт өөрчлөлтийг тусгаж, ҮСХ-ны арга зүйн байнгын зөвлөлийн хурлаар 2014 оны 12 сард хэлэлцүүлэн дараагийн шатны хурал болох ҮСХ-ны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.

ЭМ-ийн сайдын 2013 оны 108 тоот тушаалаар “Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг тогтоох тухай журам”-ыг баталсан.

ҮХАА-н сайдын 2013 оны А/162 дугаар тушаалаар “Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент”-ыг баталсан. Аймгуудын ХХААГ-ын хүнсний асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 2014 онд “Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний тэнцэл тооцох” сургалтыг зохион байгуулж, аймгийн түвшинд хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, нөөц, хангамжийг тооцож гаргах чадавхи бүрдүүлсэн.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 1.5. ДЭМБ, ХҮБ-ын ХХААБ-ын Хүнсний эрх зүйн хорооноос баталсан хоол, хүнсний аюулгүй байдлын лавлагаа, зөвлөмж, шинжилгээний аргачлал, стандартыг нутагшуулан мөрдөх.

2012 оны байдлаар ХХЭЗХ (Хүнсний Хууль Эрх Зүйн Хороо)-ноос баталсан 333 стандартаас Монгол улсад орчуулагдан, үндэсний стандартаар батлагдсан нийт 68 стандарт (MNS CAC) байна. Кодексын үндэсний зөвлөлийн (КҮЗ) анхдугаар хуралдааныг 2013.04.03-ны өдөр зохион байгуулж, “Монгол улс дахь Кодексын үндэсний зохицуулагч”-ийг томилон, Ром хот дахь Хүнсний хууль эрх зүйн хорооны нарийн бичгийн дарга нарын газарт мэдээллийг хүргүүлэв. Мөн КҮЗ-ийн орон тооны бус нарийн бичгийн дарга нарыг томилж, НЭМХ-ийн Хоол судлалын төвд байсан Кодексийн нарийн бичгийн даргын ажлыг хүлээлцэж, КҮЗ-ийн дэргэд орон тооны нарийн бичгийн даргыг ажиллуулахаар бүтэц, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэв.

КҮЗ-ийн ээлжит Хоёрдугаар хурлыг 2013.04.26-ны өдөр зохион байгуулж “Нэн даруй хянах, шинээр орчуулах шаардлагатай стандартын жагсаалт”-ыг хэлэлцэж, КҮЗ-ийн 2013 оны ажлын төлөвлөгөө, КҮЗ-ийн үйл ажиллагааны хамрах хүрээ, бүтцийн схемийг боловсруулж, батлуулав. Мөн 2014-2019 онуудад Кодексийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний төслийг хэлэлцэн тэргүүлэх чиглэл, зорилтыг тодорхойлов.

Дээрх батлагдсан 68 стандартад (MNS CAC) дүн шинжилгээ хийж үзэхэд орчуулгын алдаатай, эсвэл ХХЭЗХ-ноос шинэчлэгдэн батлагдсан учир дахин хянах шаардлагатай болсон. КҮЗ-өөс “Нэн даруй хянах, шинээр орчуулах шаардлагатай стандартын жагсаалт”-ыг /52 стандарт/ боловсруулан баталсан. Жагсаалтанд орсон стандартаас 47 стандартыг орчуулж дууссан ба Орчуулсан стандартаа хянах техникийн ажлын хэсгийг байгуулан, ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлэв. Эдгээрээс 2014 онд 7 стандарт батлагдсан байна. КҮЗ-ийн ээлжит хурлыг 2014 онд 3 удаа зохион байгуулсан.

ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БАТАЛСАН САС-ЫН СТАНДАРТ

Стандартын төрөл	Стандартын нэр	Стандартын ангилалт	Мөрдөлгөө	Мөрдөж эхэлсэн огноо
2013 он				
MNS CAC RCP 58:2013	Махны эрүүл ахуйн дадлын дүрэм /шинэчлэн/	67.120.01	Заавал мөрдөх	1/24/2014
2014 он				
MNS CAC 178:2014	Хатуу буудайн хүүхдийн будаа, хатуу буудайн гурил.	67.060.	Заавал мөрдөх	11/25/2014
MNS CAC 249:2014	Түргэн болдог гоймон	67.060.	Заавал мөрдөх	11/25/2014
MNS CAC RCP 2:2014	Нөөшилсөн жимс, хүнсний ногооны эрүүл ахуйн дадлын дүрэм	67.080.01	Заавал мөрдөх	11/25/2014
MNS CAC 299:2014	Алим. Ерөнхий шаардлага	67.080.10	Заавал мөрдөх	11/25/2014
MNS CAC RCP 57:2014	Сүү, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуйн дадлын зөвлөмж	67.100.10	Заавал мөрдөх	1/8/2015
MNS CAC GL 24:2014	“Халал” нэр томъёог хэрэглэх ерөнхий заавар	67.120.10	Заавал мөрдөх	1/8/2015
MNS CAC 212:2014	Элсэн чихэр	67.180.10	Заавал мөрдөх	11/25/2014

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 1.6. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх хадгалах, тээвэрлэх, борлуулах, журам, техникийн зохицуулалтыг боловсруулж мөрдүүлэх.

ХХААХҮ-ийн сайдын 2010.08.27-ны өдрийн А/206 дугаар тушаалаар “Хоолны газрын нийтлэг журам”-ыг баталсан.

Засгийн газрын 2011 оны 304, 305 тоот тогтоолоор “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”, “Бялууны үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг тус тус баталсан. “Мах, махан

бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулсан.

ОБЕГ-ын даргын тушаалаар “Улсын нөөцийн бараа материалыг ачих буулгахад гар ажиллагаатай ажлын үнэлгээ шинэчлэн батлах тухай” журам, “Улсын нөөцийн бараа материалыг ачих буулгахад гар ажиллагаатай ажлын үнэлгээ шинэчлэн батлах тухай” журам, ЭМ-ийн сайдын 2011 оны 185 дугаар тушаалаар “Гамшгийн үед хүн амын хүнсний хэрэглээний хоногийн жишиг хэмжээ”-г тус тус баталсан.

УИХ-ын 2012 оны “Хүнсний тухай” болон “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын дагуу ҮХААЯ-ны ТНБД-ын 2012 оны А/104 тоот тушаалаар эдгээр хуулиудад заасан дүрэм, журам, аргачлал, зөвлөмжийг боловсруулах төлөвлөгөө, ажлын хэсгийг баталсан. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин 2014 оны жилийн эцсийн байдлаар дараах дүнтэй байна.

ДҮРЭМ, ЖУРАМ, АРГАЧЛАЛ, ЗӨВЛӨМЖИЙН ТОВЧОО

№	Боловсруулалтын түвшин	Тоо хэмжээ	Үнэлгээ, хувь
1	Эрх бүхий газраас батлагдсан	19	100
2	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн	2	70
3	Эцэслэн боловсруулж, холбогдох газруудаас санал авах шатанд байгаа	4	50
4	Боловсруулалт, хэлэлцүүлгийн шатанд байгаа	5	30
5	Судалгаа хийгдэж, ажлын хэсгийн уулзалт зохион байгуулсан	2	10
	Дүн	32	75.3

ДҮРЭМ, ЖУРАМ, АРГАЧЛАЛ, ЗӨВЛӨМЖИЙН ЖАГСААЛТ

№	Боловсруулах эрх зүйн актын нэр	Үндэслэл	Батлах субъект	Хэрэгжилт
1	Стратегийн хүнсийг экспортлох, импортлох нэр төрөл, тоо хэмжээг тогтоох, зөвшөөрөл олгох тухай журам	Хүнсний тухай хуулийн 6.8	ЗГ-ын тогтоол	Засгийн газрын 2013.03.02-ны өдрийн 77 дугаар тогтоолоор “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журмыг” баталсан.
2	Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн дүрэм	Хүнсний тухай хууль, 18	ЗГ-ын тогтоол	Засгийн газрын 2013.03.02-ны 78 дугаар тогтоолоор “Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүн батлах тухай” журмыг баталсан.
3	Хүнсний туухий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам	ХБАБХ тухай хуулийн 8.10	ЗГ-ын тогтоол	Засгийн газрын 2013 оны 172 дугаар тогтоолоор “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах тухай журам”-ыг батлуулан мөрдөж эхлээд байна.
4	Өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлоход ачилтын өмнөх хяналт, шалгалт хийх журам	ХБАБХ тухай хуулийн 13.8	ЗГ-ын тогтоол	Засгийн газрын 2013.10.12-ны өдрийн 341 дүгээр тогтоолоор “Зээл тусламжаар авах болон өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлоход ачилтын өмнөх хяналт, шалгалт хийх журам”-ыг баталсан.
5	Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих тухай журам	Тамхины хяналтын тухай 6.9	ЗГ-ын тогтоол	Засгийн газрын 2013.05.25-ны өдрийн 191 тоот тогтоолоор батлагдан мөрдөн ажиллаж байна.
6	Эрсдлийн үнэлгээ хийх багийн ажиллах журам	ХБАБХ тухай хуулийн 15.5	ЗГ-ын тогтоол	Засгийн газрын 2013.10.05-ны өдрийн 330 дугаар тогтоолоор баталсан.
7	Үндэсний лавлагаа лабораторийн ажиллах журам			

8	Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн тухай журам	ХБАБХ тухай хуулийн 9.5	ҮХАА-н сайдын тушаал	Үйлдвэр Хөдөө аж ахуйн сайдын 2013.08.06-ны өдрийн № А/98 дугаар тушаалаар баталсан.
9	Өргөн хэрэглээний хүнсний жагсаалт батлах тухай журам	Хүнсний тухай хууль 8.4	ҮХАА-н сайдын тушаал	ҮХАА-н сайдын 2013.02.28-ны өдрийн “Жагсаалт, аргачлал батлах тухай” журмыг А/33 дугаар тушаалаар баталсан.
10	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, биобэлдмэлийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох	ХБАБХ тухай хуулийн 17.1.2	ҮХАА-н сайдын тушаал	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013.02.26-ны өдрийн А/31 дугаар тушаалаар баталсан.
11	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдлээс шалтгаалан зайлшгүй сав баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголохтой холбогдсон журам	ХБАБХ тухай хуулийн 12.2	ҮХАА-ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал	Үйлдвэр, хөдөө аж ахуй, Эрүүл мэндийн сайдын 2013.04.08-ны өдрийн А/46/115 дугаар тушаалаар баталсан.
12	Анхааруулах тэмдгийн загвар	Тамхины хяналтын тухай 9.4	ЭМ-ийн сайдын тушаал	ЭМ-ийн сайдын 2013.02.04-ний өдрийн 36 дугаар тушаалаар баталсан.
13	Хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээ	Хүнсний тухай хууль, 5.1	ЭМ-ийн сайдын тушаал	ЭМ-ийн сайдын 2013 оны 108 дугаар тушаалаар баталсан.
14	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтанд тавих, эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журам	ХБАБХ тухай хуулийн 13.4	ЭМ-ийн сайдын тушаал	ЭМ-ийн сайдын 2013.06.10-ны өдрийн 212 тоот тушаалаар батлуулан мөрдөж эхлээд байна.
15	“Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох”	ХБАБХ тухай хуулийн 15.2.3.	ЭМ-ийн сайдын тушаал	ЭМ-ийн сайдын 2014 оны 384 дүгээр тушаалаар “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн жагсаалт”-ыг баталсан.
16	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх маягтын загвар, нөхөн бичих заавар, бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах заавар	ХБАБХ тухай хуулийн 6.2	МХЕГ-ын даргын тушаал	МХЕГ-ын даргын 2013.02.28-ны өдрийн 37 дугаар тушаалаар батлан, нийт аймаг, орон нутагт хүргүүлэн мөрдөж байна.
17	Импортын барааны эрсдлийн ангилал		МХЕГ-ын даргын тушаал	МХЕГ-ын даргын 2014 оны 60 дугаар тушаалаар баталсан.
18	Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх аргачлал	ХБАБХ тухай хуулийн 7.4	МХЕГ-ын даргын тушаал	МХЕГ-ын 2014.02.20-ны өдрийн 79 дүгээр тушаалаар баталсан.
19	Хилийн мэргэжлийн хяналтад хамрагдах импортын бараанд хийх хяналт шалгалтын заавар, ашиглах хяналтын хуудас, бараа шалгах код		МХЕГ-ын даргын тушаал	МХЕГ-ын даргын 2014 оны 309 дүгээр тушаалаар баталсан.
20	Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд урамшуулал олгох тухай журам (мал, сүүний	Хүнсний тухай хуулийн 8.3	ЗГ-ын тогтоол	“Боловсруулах үйлдвэр, цехэд бэлтгэн нийлүүлсэн мал, сүүнд урамшуулал олгох тухай” журмын

	урамшуулал)			төслийг 2013 оны 03 сард ЗГ-т хүргүүлсэн, Засгийн газрын гишүүдийн саналаар түр хойшлуулсан.
21	Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах тухай журам	Хүнсний тухай хууль, 6.2	ЗГ-ын тогтоол	“Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах тухай” журмын төслийг 2013 оны 03 сард ЗГ-т хүргүүлсэн, Засгийн газрын гишүүдийн саналаар түр хойшлуулсан. Яамд, аймаг, нийслэлийн Засаг дарга нараас санал авч, нэгтгэн Засгийн газарт хүргүүлэхээр бэлдэж байна.
22	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам;	Хүнсний тухай хууль, 12.2	ЗГ-ын тогтоол	Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д өөрчлөлт оруулах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн хүнсний дотоод хяналтын үлгэрчилсэн журам боловсруулах ажлын хэсгийг МХЕГ-ын даргын 2013.05.07-ны 107 дугаар тушаалаар байгуулан журмын төслийг боловсруулж, Шадар сайдын ажлын албанд 2013.07.29-ний өдрийн 2/2330 тоотойр хүргүүлсэн ба яамдаас ирүүлсэн саналыг нэгтгэж байна.
23	Баяжуулагч бэлдмэл, нэмэлт, цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах тухай журам	Хүнсний тухай хууль, 16.2	ҮХАА-н сайдын тушаал	Журмын төслийг боловсруулан холбогдох яамдаас санал авахаар хүргүүлээд байна.
24	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх аргачлал, зөвлөмж	ХБАБХ тухай хуулийн 7.2	МХЕГ-ын даргын тушаал	ХАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэл, үйлчилгээнд ХАА-н зохистой дадлыг, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээнд үйлдвэрлэлийн зохистой дадлыг, хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадлыг тус тус нэвтрүүлэх аргачлал, зөвлөмжийн төслийг боловсруулж, аймаг, орон нутгаас санал авч байна.
25	Хөдөө аж ахуйн зохистой дадал, Эрүүл ахуйн зохистой дадал, Үйлдвэрийн зохистой дадал нэвтрүүлэх хялбаршуулсан заавар	ХБАБХ тухай хуулийн 7.2.	ҮХАА-ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал	Зааврын төслийг боловсруулан мэргэжлийн холбоод болон фермер, хүнс үйлдвэрлэгч нарыг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулж, төсөлд санал авч байна.
26	Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдлийг үнэлэх журам	Хүнсний тухай хууль, 9.1.3.	ЭМ-ийн сайдын тушаал	Ажлын хэсгээс журмын төсөл боловсруулан, эхний хэлэлцүүлгийг хийсэн.
27	Мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээлийн аюулгүй байдалд тавих шаардлага	ХБАБХ тухай хуулийн 17.1.3	ҮХАА-н сайдын тушаал	Ажлын хэсэг журмын төсөл боловсруулж байна.
28	Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд,	ХБАБХ тухай	ЭМ, ҮХАА	3 яамны хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, журмын төслийг

	бүтээгдэхүүнд эрсдлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журам	хуулийн 14.1	БОНХ-ийн сайдын хамтарсан тушаал	боловсруулж байна.
29	Хүнсний үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, урамшуулал олгох тухай журам	Хүнсний тухай хуулийн 8.5	ЗГ-ын тогтоол	Ажлын хэсэг журмын төсөл боловсруулж байна.
30	Тусгай хоолны дэглэмтэй хүнд зориулсан хүнсний бүтээгдэхүүн, мөн хуулийн 6.5.3-т заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэлд тавих шаардлагыг тогтоох	ХБАБХ тухай хуулийн 17.2.1.	ЭМ-ийн сайдын тушаал	Ажлын хэсэг сайдын тушаалын төслийг боловсруулж байна.
31	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтэд агуулагдах бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтоох	ХБАБХ тухай хуулийн 17.2.2.	ЭМ-ийн сайдын тушаал	Ажлын хэсгийн уулзалт хэлэлцүүлгүүд хийгдсэн
32	Хүнсний нэмэлтийн аюулгүй хэрэглээний түвшинг тогтоож, хэрэглэх нөхцлийг тодорхойлох	ХБАБХ тухай хуулийн 17.2.3.		

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 1.7. Зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний бүтээгдэхүүн, органик хүнс, бага насны хүүхдийн нэмэлт хоолны үйлдвэрлэлийг дэмжих.

“Баяжуулсан хүнс” дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан холбогдох газруудаас санал авч 2011 онд Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн. “Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулсан.

НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр хэрэгжих “Органик хөдөө аж ахуйг дэмжих” техник туслалцааны төслийн нээлтийн семинарыг 2014 оны 11 сард зохион байгуулж, сургалт, хэлэлцүүлэг хийсэн. Төслийн хүрээнд суурь судалгаа хийх, сургалт сурталчилгаа явуулах, органик ферм байгуулахад дэмжлэг үзүүлэх, баталгаажуулалтын эрх бүхий байгууллагыг байгуулах, улмаар органик Монгол хүнсийг баталгаажуулах ажлуудыг хийхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Зохицуулах үйлчилгээтэй хүнсний талаар баримтлах бодлого, чиглэлийг олон улсын туршлага болон өөрийн орны нөхцөл байдалд тулгуурлан салбарын мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдаас санал авч боловсруулж байна. “Хүнсний тухай” хуулийн 16.2-т заасны дагуу “Баяжуулагч бэлдмэл, нэмэлт, цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах тухай журам”-ын төсөл боловсруулсан.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалаар “Монгол хүүхдийн хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ”-г баталсан. “Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх, хүнсний нэмэлт, баяжуулагч бэлдмэлийн бохирдуулагчийг тогтоох журам”-ын төслийг боловсруулан хэлэлцүүлгийн шатанд байна.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 1.9. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослон эрхлэх бүс нутгийн хилийн зааг, тухайн аймаг, сумын хөдөө аж ахуйн эдэлбэр газарт эзлэх хувийг тогтоох, тариалангийн газрыг ашиглуулах, эзэмшүүлэх, өмчлүүлэх нөхцөл, тариалангийн талбай, ургацыг малаас хамгаалах талаар холбогдох хуульд нэмэлт оруулах төсөл боловсруулах.

“Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослон эрхлэх бүс нутгийн хилийн зааг, түүний эзлэх хувийг тогтоох тухай” хууль болон тариалангийн газрыг өмчлүүлэх чиглэлээр “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулсан. “Газрын тухай” багц хуулинд эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослон эрхлэх бүс нутгийн хилийн зааг тогтоох талаар санал хүргүүлсэн бөгөөд тусгайлсан хуулийн төсөл боловсруулах эсэх талаар эцэслэн шийдээгүй байна.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 11.10. Тариалангийн даатгалын хэлбэр, тогтолцоог бий болгох, уул уурхайн салбараас олж байгаа орлогын тодорхой хувийг хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх асуудлыг судалж санал боловсруулах.

“Тариалангийн даатгалын тухай” хуулийн төслийг боловсруулсан. Уг ажлын хүрээнд актуар тооцоолол хийхэд зориулсан мэдээлийн сан бэлтгэх зөвлөх үйлчилгээний тендер зарлаж тайланг хүлээн авсан.

Уул уурхайн салбараас олж байгаа ашгийн тодорхой хувийг газар тариалангийн салбарт хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулан хууль санаачлагчид хүргүүлсэн.

2014 онд уул уурхайн салбараас орсон орлого /1112.8 тэрбум/ –оос хүнс, хөдөө аж ахуйн салбарт 42.3 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээс газар тариалангийн чиглэлээр 12.5 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнд:

- “Төрийн болон орон нутгийн өмчийн тариалангийн талбайн услалтын системийг сэргээн засварлах, шинээр барих, ус хуримтлуулах сан бүхий боомтын барилга /тариалангийн бүс нутагт/” төсөл, арга хэмжээнд 3.0 тэрбум төгрөг,
- “Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах /Дархан-Уул/” төсөлд 8.0 тэрбум төгрөг, “Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах байгуулах /Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Булган, Улаанбаатар, Увс, Хөвсгөл, Дорнод/” төсөл, арга хэмжээнд 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 1.11. Хүнсний үйлдвэрлэлд мөрдөж байгаа стандартуудыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх, шинээр боловсруулж батлуулах.

Монгол Улсын Шадар сайдын 2012.11.26-ны өдрийн 42 дугаар тушаалаар Үндэсний стандартын шинжлэх ухаан техникийн түвшинд улсын үзлэгийг удирдан зохион байгуулах төв комиссын бүрэлдэхүүнийг баталж, эхний хуралдааныг 2012.12.14-ний өдөр зохион байгуулсан.

Үндэсний стандартын улсын үзлэгт /2013 он/ хүнсний салбарын 753 стандарт хамрагдсан. Үзлэгийн дүнгээр шаардлага хангахгүй байгаа 45 нэрийн стандартыг хүчингүй болгож, 14 нэрийн стандартын дугаар тэмдэглэгээг олон улсын стандарттай ижилтгэн сольсон. Мөн шинээр болон шинэчлэн боловсруулах стандартын жагсаалтыг гарган үе шаттайгаар боловсруулах ажил хийгдэж байна.

ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛСАН СТАНДАРТ

Стандартын төрөл	Стандартын нэр	Стандартын ангилалт	Мөрдөлгөө	Мөрдөж эхэлсэн огноо
2009 он				
MNS 6052:2009	Үр тариа, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд нян, хөгц мөөгөнцөр тодорхойлох “Rida count”-ийн арга	07.100.30	Сонгон хэрэглэх	1/15/2010

MNS 6051:2009	Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ самарт нян судлалын шинжилгээ хийх арга	07.100.30	Сонгон хэрэглэх	1/15/2010
MNS CAC MRL 2:2009	Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	67.040.	Сонгон хэрэглэх	2/2/2010
MNS 6047:2009	Зеараленоны агууламжийг тодорхойлох иммуноферментийн арга (ELISA)	67.050.	Сонгон хэрэглэх	1/1/2010
MNS 6048:2009	Фумонизиний агууламжийг тодорхойлох иммуноферментийн арга (ELISA)	67.050.	Сонгон хэрэглэх	1/1/2010
MNS 6050:2009	T2 токсин агууламжийг тодорхойлох иммуноферментийн арга (ELISA)	67.050.	Сонгон хэрэглэх	1/15/2010
MNS 6044:2009	Нийлбэр афлатоксину агууламжийг тодорхойлох иммуноферментийн арга (ELISA)	67.050.	Сонгон хэрэглэх	1/10/2010
MNS 6045:2009	Афлатоксин В1-ийн агууламжийг тодорхойлох иммуноферментийн арга (ELISA)	67.050.	Сонгон хэрэглэх	1/17/2010
MNS 6046:2009	Деоксиниваленолын агууламжийг тодорхойлох иммуноферментийн арга (ELISA)	67.050.	Сонгон хэрэглэх	8/1/2010
MNS 6049:2009	Охратоксин А-ийн агууламжийг тодорхойлох иммуноферментийн арга (ELISA)	67.050.	Сонгон хэрэглэх	1/15/2010
MNS GB T 5009-34:2009	Хүнсэнд агуулагдах хүхрийн хоёрч ислийн хэмжээг тодорхойлох	67.050.	Сонгон хэрэглэх	2/2/2010
MNS 0244:2009	Буудайн гурил. Техникийн ерөнхий шаардлага Wheat flour. General technical requirements	67.060.	Заавал мөрдөх	12/15/2009
MNS 4661:2009	Талх, талхан бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага	67.060.	Заавал мөрдөх	1/15/2010
MNS GB T 5009-199:2009	Хүнсний ногоон дахь органик фосфат болон карбамат пестицидийн үлдэгдлийг тодорхойлох хурдавчилсан арга	67.080.01	Сонгон хэрэглэх	1/15/2010
MNS 0264:2009	Лооль. Техникийн ерөнхий шаардлага Tomatoes. General technical requirements	67.080.20	Заавал мөрдөх	12/15/2009
MNS 5998:2009	Мал нядлах үйлдвэр. Аюулын дүн шинжилгээ ба эгзгийг хянах цэгийн (HACCP) тогтолцооны загвар	67.120.10	Сонгон хэрэглэх	2/3/2010
MNS 2456:2009	Мах, махан бүтээгдэхүүн. Үхрийн хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага Meat and meat products. Cuts and classifications of beef. General requirements	67.120.10	Заавал мөрдөх	2/3/2010
MNS 2457:2009	Мах махан бүтээгдэхүүн. Хонь ямааны хэсэглэж ангилсан мах. Ерөнхий шаардлага	67.120.10	Заавал мөрдөх	2/3/2010
MNS 0179:2009	Согтууруулах ундаа. Цагаан болон өвөрмөц архи. Техникийн ерөнхий шаардлага Alcohol drink. Vodkas and special vodkas. Technical general requirements	67.160.10	Заавал мөрдөх	1/1/2010
MNS 5984:2009	Согтууруулах ундаа. Ликёр болон ликёрийн төрлийн архи. Техникийн ерөнхий шаардлага	67.160.10	Заавал мөрдөх	1/1/2010
2010 он				
MNS 6361:2010	Хүнс, малын тэжээл дэх микотоксину үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	67.040.	Заавал мөрдөх	1/4/2013
MNS 0097:2010	Хүнсний буудай. Техникийн ерөнхий шаардлага Wheat. General technical requirements СҮЗ-ийн 2012/45	67.060.	Заавал мөрдөх	1/27/2011
MNS 0254.8:2010	Үр тариа. Тарианы болон гадны хольц тодорхойлох арга Gereals. Methods for determination of grain dockage	67.060.	Сонгон хэрэглэх	1/27/2011
MNS 0464:2010	Бялууны төрлийн бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага Cake products. General technical requirements	67.060.	Заавал мөрдөх	9/15/2010
MNS 6187:2010	Хүнсний таримал мөөг (Agaricus spp. буюу синоним Psalliota spp) Техникийн ерөнхий шаардлага	67.080.20	Заавал мөрдөх	12/13/2010
MNS 6181:2010	Монгол тарагнаас ялгасан сүүнхүчлийн нянгийн нутгийн омгийн цэвэр өсгөвөр Lactobacillus Acidophilus LB 3	67.100.01	Сонгон хэрэглэх	12/15/2010
MNS GOST R 51331:2010	Йогурт. Ерөнхий шаардлага	67.100.10	Сонгон хэрэглэх	6/18/2010
MNS CAC RCP 66:2010	Нялхас, бага насны хүүхдийн нунтаг сүүн тэжээлийн эрүүл ахуйн дадал	67.230.	Сонгон хэрэглэх	12/20/2010
MNS GOST 52522:2010	Хүнсний зориулалттай түүхий эдээс гарган авсан этилийн спирт, архи, ликёрын төрлийн бүтээгдэхүүнд мэдрэхүйн шинжилгээ хийх арга	67.240.	Сонгон хэрэглэх	1/27/2011
MNS ISO 3142:2010	Лиш [Syzygium aromaticum (L) Merr. et Perry, syn. Eugenia caryophyllus (Sprengel) Bullock et	71.100.60	Сонгон хэрэглэх	5/31/2010

	S.Harrison]-ийн цэцгийн бундууны эфирийн тос			
MNS ISO 3215:2010	Индонез хэвшлийн зад (<i>Myristica fragrans</i> Houtt) – ийн эфирийн тос	71.100.60	Сонгон хэрэглэх	5/31/2010
MNS ISO 3475:2010	Цийр (<i>Pimpinella anisum</i> L)-ийн үрийн эфирийн тос.	71.100.60	Сонгон хэрэглэх	5/31/2010
MNS ISO 14715:2010	Тимол агуулсан Испани хэвшлийн ганга [<i>Thymus zygis</i> (Loefl) L]-ны эфирийн тос	71.100.60	Сонгон хэрэглэх	5/31/2010
MNS ISO 14717:2010	Испани хэвшлийн хахуун [<i>Thymbra capitata</i> (L) Cav]-ы эфирийн тос.	71.100.60	Сонгон хэрэглэх	5/31/2010
MNS ISO 8897:2010	Эгэл арц (<i>Juniperus communis</i> L)-ны жимсгэний эфирийн тос	71.100.60	Сонгон хэрэглэх	5/31/2010
MNS ISO 3518:2010	Цагаан зандан (<i>Santalum album</i> L) модны эфирийн тос	71.100.60	Сонгон хэрэглэх	5/31/2010
MNS ISO 3524:2010	Шриланк хэвшлийн Цейлон шинц (<i>Cinnamomum zeylanicum</i> Blute) модны навчны эфирийн тос	71.100.60	Сонгон хэрэглэх	5/31/2010
MNS ISO 4733:2010	Сүгмэлийн [<i>Elettaria cardamomum</i> (L) Maton]-ийн эфирийн тос.	71.100.60	Сонгон хэрэглэх	5/31/2010
2011 он				
MNS ISO 6888-2:2011	Хүнс ба малын тэжээлийн микробиологи. Сийвэн бүлэгнүүлэгч стафилококкын тоог тогтоох (<i>Staphylococcus aureus</i> болон бусад зүйл) 2-р хэсэг: Туулайны цусны сийвэнтэй агар хэрэглэх заавар	07.100.30	Сонгон хэрэглэх	7/1/2011
MNS ISO 6888-1:2011	Хүнс ба малын тэжээлийн микробиологи. Сийвэн бүлэгнүүлэгч стафилококкын тоог тогтоох (<i>Staphylococcus aureus</i> болон бусад зүйл) 1-р хэсэг: Байрд Паркер агар хэрэглэх заавар	07.100.30	Сонгон хэрэглэх	7/1/2011
MNS ISO 21567:2011	Хүнс, малын хоол тэжээлийн микробиологи. <i>Shigella</i> spp-г илрүүлэх арга	07.100.30	Сонгон хэрэглэх	7/1/2011
MNS 6292:2011	Жимс, хүнсний ногоонд антиоксидант идэвхийг тодорхойлох спектрофотометрийн арга	67.050	Сонгон хэрэглэх	11/1/2011
MNS ISO 21569:2011	Хүнсний бүтээгдэхүүн. Хувиргасан амьд организм, түүний гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний аргууд. Нуклейн хүчлийн чанарт суурилсан аргууд	67.050.	Сонгон хэрэглэх	1/13/2012
MNS 0916:2011	Чацаргана жимс. Техникийн ерөнхий шаардлага <i>Seabuckthorn</i> fruits. Technical general requirments	67.080.10	Заавал мөрдөх	12/22/2011
MNS 0219:2011	Ундны сүү. Техникийн ерөнхий шаардлага <i>Drinking milk</i> . General technical requirements. 2013/30	67.100.10	Сонгон хэрэглэх	1/2/2012
MNS 4228:2011	Малын түүхий сүү. Техникийн шаардлага	67.100.10	Сонгон хэрэглэх	1/2/2012
MNS 4229:2011	Эсэг цагаан идээ. Техникийн шаардлага	67.100.10	Заавал мөрдөх	1/2/2012
MNS 2842:2011	Хатаамал сүү. Техникийн шаардлага <i>Dried milk</i> . Technical requirements 2013/30	67.100.10	Сонгон хэрэглэх	2/2/2012
MNS 4528:2011	Тослог цагаан идээ. Техникийн шаардлага	67.100.10	Сонгон хэрэглэх	1/2/2012
MNS 0226:2011	Зайрмаг. Техникийн ерөнхий шаардлага <i>Ice cream</i> . General technical requirements.	67.100.40	Сонгон хэрэглэх	1/2/2012
MNS 6268:2011	Уламжлалт махан бүтээгдэхүүн. “Шууз”. Ерөнхий шаардлага	67.120.10	Заавал мөрдөх	7/18/2011
MNS CAC RCP 52:2011	Загас, загасан бүтээгдэхүүнтэй ажиллах дүрэм	67.120.30	Сонгон хэрэглэх	7/1/2011
MNS 5074:2011	Төрөл бүрийн дарс, дарсны төрлийн бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага	67.160.10	Заавал мөрдөх	12/16/2011
MNS 6294:2011	Зөгийн цэвэр бал. Техникийн ерөнхий шаардлага	67.180.10	Заавал мөрдөх	12/1/2011
MNS 6293:2011	Зөгийн бал шинжлэх арга	67.180.10	Сонгон хэрэглэх	12/1/2011
2012 он				
MNS 6369:2012	Буудайн болон арвайн гурил, талх, талхан бүтээгдэхүүнд <i>B.mesentericus</i> илрүүлэх шинжилгээний арга	07.100.30	Сонгон хэрэглэх	4/21/2013
MNS ISO 21807:2012	Хүнс, малын тэжээлийн микробиологи. Усны идэвх тодорхойлох	07.100.30	Сонгон хэрэглэх	1/4/2013
MNS 6360:2012	Хүнсний бүтээгдэхүүнд бензапирений агууламжийг тодорхойлох арга	67.040.	Сонгон хэрэглэх	1/4/2013
MNS 6308:2012	Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн	67.040.	Сонгон хэрэглэх	10/1/2012

	зөвшөөрөгдөх хэмжээ			
MNS 6359:2012	Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах бензапирений зөвшөөрөгдөх дээд хэмжээ	67.040.	Заавал мөрдөх	2/22/2013
MNS 0687-1:2012	Төрөл бүрийн жимс жимсгэнэ, ногооны шүүс. Техникийн ерөнхий шаардлага.	67.060.	Заавал мөрдөх	7/16/2012
MNS 0167:2012	Гахайны хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага	67.120.10	Заавал мөрдөх	1/4/2013
MNS 6362:2012	Мах махан бүтээгдэхүүн. Хлоридын агууламж тодорхойлох арга	67.120.20	Сонгон хэрэглэх	1/4/2013
MNS GOST 51786:2012	Архи ба хүнсний спирт. Гарал үүслийг тодорхойлох хийн хроматографын арга	67.160.10	Сонгон хэрэглэх	4/21/2013
MNS ISO 13884:2012	Амьтан, ургамлын гаралтай тос. Тусгаарлагдсан хоёрчийн холбоо бүхий транс изомерийг нил улаан туяаны спектрометрээр тодорхойлох	67.200.10	Сонгон хэрэглэх	1/4/2013
MNS 6368:2012	Зохицуулах үйлчилгээтэй хүнс. Артишокийн ундаа. Техникийн ерөнхий шаардлага	67.270.	Заавал мөрдөх	4/21/2013
2013 он				
MNS 5076:2013	Малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд цацраг идэвхт элемент тодорхойлох Гамма спектрометрийн арга	67.020.	Сонгон хэрэглэх	1/24/2014
MNS 6420:2013	Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, мал, амьтны тэжээлд агуулагдах нитратын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	67.040.	Заавал мөрдөх	4/9/2014
MNS ISO 24276:2013	Хүнсний бүтээгдэхүүн – Хувиргасан амьд организм, түүний гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний арга – Ерөнхий шаардлага ба тодорхойлолт	67.040.	Сонгон хэрэглэх	4/9/2014
MNS ISO 21572:2013	Хүнсний бүтээгдэхүүн – Хувиргасан амьд организм, түүнээс гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний арга – Уурагт суурилсан арга	67.040.	Сонгон хэрэглэх	4/9/2014
MNS ISO 21570:2013	Хүнсний бүтээгдэхүүн – Хувиргасан амьд организм -Нуклейн хүчилд суурилсан тоон тодорхойлолтын арга	67.050.	Сонгон хэрэглэх	4/30/2014
MNS 1989:2013	Үхэр нүдний жимс. Ерөнхий шаардлага	67.080.20	Заавал мөрдөх	4/9/2014
MNS 6421:2013	Кимчи. Ерөнхий шаардлага	67.080.20	Заавал мөрдөх	4/9/2014
MNS CAC RCP 58:2013	Махны эрүүл ахуйн дадлын дүрэм	67.120.01	Заавал мөрдөх	1/24/2014
MNS 6391:2013	Адууны махан уламжлалт бүтээгдэхүүн. Каз, карта, чужук, жал, жая. Техникийн ерөнхий шаардлага	67.120.10	Заавал мөрдөх	7/5/2013
MNS 6427:2013	Махны төрөл, мал, амьтны хүйс тодорхойлох - ДНХ оношлогооны арга	67.120.10	Сонгон хэрэглэх	1/24/2014
2014 он				
MNS CAC 178:2014	Хатуу буудайн хүүхдийн будаа, хатуу буудайн гурил.	67.060.	Заавал мөрдөх	11/25/2014
MNS CAC 249:2014	Түргэн болдог гоймон	67.060.	Заавал мөрдөх	11/25/2014
MNS CAC RCP 2:2014	Нөөшилсөн жимс, хүнсний ногооны эрүүл ахуйн дадлын дүрэм	67.080.01	Заавал мөрдөх	11/25/2014
MNS CAC 299:2014	Алим. Ерөнхий шаардлага	67.080.10	Заавал мөрдөх	11/25/2014
MNS CAC RCP 57:2014	Сүү, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуйн дадлын зөвлөмж	67.100.10	Заавал мөрдөх	1/8/2015
MNS 6477:2014	Мах махан бүтээгдэхүүн. Чийглэг тодорхойлох арга.	67.120.10	Сонгон хэрэглэх	12/8/2014
MNS 0703:2014	Тахианы хэсэглэж ангилсан мах. Техникийн ерөнхий шаардлага	67.120.10	Заавал мөрдөх	12/8/2014
MNS CAC GL 24:2014	“Халал” нэр томьёог хэрэглэх ерөнхий заавар	67.120.10	Заавал мөрдөх	1/8/2015
MNS 0178:2014	Хүнсний спирт. Техникийн ерөнхий шаардлага	67.160.10	Заавал мөрдөх	1/26/2015
MNS 0687-2:2014	Үл согтууруулах ундаа. Цайны болон кофены төрлийн ундаа. Техникийн ерөнхий шаардлага	67.160.20	Заавал мөрдөх	1/26/2015
MNS CAC 212:2014	Элсэн чихэр	67.180.10	Заавал мөрдөх	11/25/2014

MNS 6482:2014	Хонины сүүлний тос. Техникийн ерөнхий шаардлага	67.200.10	Заавал мөрдөх	1/8/2015
MNS 1837:2014	Хүнсний сод. Шинжилгээний арга	67.220.10	Сонгон хэрэглэх	1/26/2015
MNS ISO 7700-1:2014	Чийг хэмжигч шалгах арга, хэрэгсэл. 1-р хэсэг: Залаат үр тарианы чийг хэмжигч	67.260.	Сонгон хэрэглэх	10/13/2014
MNS ISO 7700-2:2014	Чийг хэмжигч шалгах арга хэрэгсэл. 2-р хэсэг: Буурцагт болон тосны ургамлын үрийн чийг хэмжигч	67.260.	Сонгон хэрэглэх	10/13/2014

- Органик хөдөө аж ахуйн үүсгэл санаачлагын олон улсын холбоо” /IFOAM - International Federation of Organic Agriculture Movements/-ноос гаргасан Органик үйлдвэрлэл, боловсруулалтын стандартыг орчуулж стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлсэн.

XIIIY-90%

Зорилт 2. Эдийн засаг, санхүү, бизнесийн таатай орчин бүрдүүлж дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд:

Үйл ажиллагаа 2.1. Импорттоор хангаж байгаа хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн, түүхий эд болон хүнсний боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгааны болон зоорийн тоног төхөөрөмж, хүлэмж, элеватор, бордоо, ургамал хамгааллын болон хөрсний чийг хадгалагч бодисийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг судалж, санал боловсруулах.

УИХ-аас 2009 онд баталсан “Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулиар жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импорттоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. /Энэ зүйлд 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./ Засгийн газрын 2011 оны 100 дугаар тогтоолоор “Гаалийн албан татвар болон НӨАТ-аас чөлөөлөгдөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, зарим сэлбэг хэрэгслийн жагсаалт”-ыг шинэчлэн батлуулж хэрэгжүүлж байна.

УИХ-ын 2011 оны 19 дугаар тогтоолоор хүнсний зарим төрлийн ногооны гаалийн импортын албан татварын хувь, хэмжээг жилийн турш 15 хувь байхаар тус тус шийдвэрлэсэн.

Нэмэгдсэн өртгийн албан татвар, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд Монгол Улсын Их Хурлын 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулснаар хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгааны тоног төхөөрөмж, хүлэмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг импортын албан татвар болон дотоодод худалдан борлуулсан орлогын нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж, хуулийн үйлчлэх хугацааг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан болно. Дээрх хуулиудад зааснаар гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх трактор, комбайн, машин механизм, бусад техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг Засгийн газрын 2012 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан.

XIIIY-100%

Үйл ажиллагаа 2.2. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтад төрөөс татаас, урамшуулал олгох, энэ салбарт санхүүгийн түрээс, даатгал, бичил санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчдэд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн төрөл, арга хэлбэрийг хуулийн зохицуулалттай болгох асуудлыг судалж, санал боловсруулах.

“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуульд 2011 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, газар тариалан эрхлэгчдийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурил, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрийн аргаар төхөөрч бэлтгэн дотооддоо борлуулсан тураг болон шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн, дотоодын түүхий эдээр үйлдвэрийн аргаар боловсруулан дотооддоо борлуулсан сүү, сүүн бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлсөн.

Түүнчлэн 50 хүртэл сая төгрөгийн борлуулалтын орлого бүхий жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг 1 хувь хүртэл бууруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн.

“Зээлийн батлан даалтын тухай” хуулийг УИХ-ын чуулганы 2012.02.10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдсан. “Хүнсний тухай” хуулиар сүүг стратегийн хүнсний ангилалд оруулсны зэрэгцээ мал төхөөрөх болон сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн.

Зээлийн батлан даалтын сангаас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 2014 онд 8 банктай хамтран ажиллаж, 2014 онд нийт 325 иргэн, аж ахуйн нэгжийн 52.0 тэрбум төгрөгийн зээлд 21.6 тэрбум төгрөгийн батлан даалтыг хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга, бөөний болон жижиглэн худалдаа, тээвэр, мэдээлэл холбоо, зочид буудал, нийтийн хоол, эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний бусад салбарт гаргасан.

Мах, сүүний үйлдвэрт мал болон сүү нийлүүлсэн малчдад урамшуулал олгох журмын төслийг боловсруулан 2013 оны 3 дугаар сард Засгийн газрын хуралдаанд оруулсан боловч гишүүдийн саналаар түр хойшлуулсан.

“Нөөцийн махны менежер”-т урамшуулал олгох ажлын хүрээнд нөөцийн махны тонн тутамд 1000 төгрөг /2011 оноос/, Улаанбуудайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор буудай үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас дотоодын гурилын үйлдвэр, ТЭДС-д нийлүүлсэн буудайн тонн тутамд 2007 онд 60.0, 2008 онд 80.0, 2009 онд 50.0, 2010 онд 50.0, 2011 онд 50.0, 2012 онд 100.0, 2013 онд 100.0 /баруун бүсэд 150.0/, 2014 онд 70.0 /баруун бүсэд 105.0/ мянган төгрөг олгосон нь үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд түлхэц болсон байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 2.3. Хүн амын хоол, хүнсний хүртээмж, хангамж, бэлэн байдал, нөөц, тэжээллэг чанар, хүнсний бохирдол болон хоол тэжээлийн байдлыг үнэлэх судалгаа, эрдэм шинжилгээний ажлын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг судалж, санал боловсруулах.

Хүнсний салбарт ХХААЯ-ны захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төсөлд ШҮТ-ийн сангаас 2010 онд 1 төсөлд 145.0 сая, 2011 онд 1 төсөлд 81.0 сая, 2012 онд 3 төсөлд 174.2 сая, 2014 онд 1 төсөлд 47.8 сая төгрөг, нийт 448 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Сангийн яамнаас Эрүүл мэндийн сайдын багцад “Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн шим тэжээл, хор судлал, биотехнологийн үндэсний үйлдвэрлэл төслийг хэрэгжүүлэхэд 960.5 сая төгрөг олгосон.

1. “Бэлчээрийн монгол ямааны махны таваарлаг шинж чанарын онцлог, мах боловсруулах дэвшилтэт технологи” /Само институт 2010-2012 он/
2. “Малын дайвар бүтээгдэхүүнд суурилсан биологийн идэвхт нэмэлт хүнс үйлдвэрлэх технологийн судалгаа” /Само институт 2011-2014 он/
3. “Ургамлын гаралтай түүхий эд ашиглан биологийн идэвхит хүнсний нэмэлт гарган авах технологи” /ХААИС, ШУТИС-ХБТС 2012-2014 он/
4. “Мах, сүү, үр тариа, төмс хүнсний ногоонд хүнсний аюулгүй байдлын судалгаа, эрсдэлийн үнэлгээ” /УМЭАЦТЛаборатори 2012-2013 он/
5. “Монголын хүн амын хүнсний бодит хэрэглээний судалгаа” /ШУТИС-ХБТС 2012-2014 он/ тус тус гүйцэтгэсэн байна.
6. “Хүнсний бүтээгдэхүүн гарган авах, боловсруулах, савлах, орчин үеийн технологи, түүний аюулгүй байдлын үнэлгээ” /Само институт 2014-2016 он/

Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 2013-2014 онд хүнсний салбарт дараах тендерийг зарлан шалгаруулж улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

1. “Мах, махан бүтээгдэхүүний гарц, хадгалалтын үеийн хорогдол тооцож, норм, нормативыг шинэчлэн тогтоох, гулууз махыг хэсэглэн ангилж, хэсэг тус бүрийг худалдаалах жишиг үнэ тогтоох судалгаа” хийх зөвлөх үйлчилгээний тендер
2. “Монгол улсын хүнсний түүхий эдийн судалгааг бүсчлэн хийж, импорт орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх тойм судалгаа” хийх зөвлөх үйлчилгээний тендер
3. “Загасны үйлдвэр байгуулах ТЭЗҮ боловсруулах” зөвлөх үйлчилгээний тендер
4. “Сав баглаа боодлын материалын эрсдлийг тодорхойлох аргачлал, схемийг материалын үндсэн төрөл, бүтээгдэхүүний эрсдлийн үнэлгээтэй нийцүүлэн боловсруулах” зөвлөх үйлчилгээний тендер
5. “Мөөг сармисны зах зээлийн судалгаа явуулах” зөвлөх үйлчилгээний тендер
6. “Хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх аргачлалыг боловсруулах” зөвлөх үйлчилгээний тендер
7. Хүнстэй харьцах гадаргуу, хүнсний зориулалтын сав баглаа боодлын материалын аюулгүй байдлын стандарт, зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер
8. “Хүнсний боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох үед баримтлах ижилтгэлийн суурь баримт бичгийг орчуулах, экспортлох, импортлох, схемийг тодорхой болгох (ДХБ-ын SPS, TBT хэлэлцээ, OIE болон САС-ийн зөвлөмж, стандарт боловсруулах)
9. “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын нэмүү өртгийн сүлжээг тодорхойлох” судалгаа боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер
10. “Хүнсний нэмэлтийн талаарх гарын авлага” хэвлүүлэх, ажил
11. “Хоногт 500 литр сүү боловсруулах цехийн технологийн гарын авлага” боловсруулах, хэвлэх ажил гүйцэтгэх

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 2.4. Хүнсний органик бүтээгдэхүүний шинэ нэр төрлийг бий болгосон, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрийг урамшуулах арга хэлбэрийн талаар судалж, санал боловсруулах.

“Органик Монгол” хөтөлбөрөөс 2014 онд органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, түүхий эд бэлтгэгч 90 гаруй аж ахуйн нэгжид 500 гаруй сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгосноор Сэлэнгэ аймгийн Шаамар, Сайхан, Зүүнбүрэн, Сүхбаатар сумын иргэдийн органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.5 хувиар нэмэгдсэн байна.

Органик хөдөө аж ахуйн хөдөлгөөнүүдийн олон улсын холбоо(IFOAM)-ны Ерөнхийлөгч Андрей Луйны 2014 онд хийсэн Монгол улс дах айлчлалын хүрээнд органик хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрлэлийн салбарын оролцогч талууд, төрийн, төрийн бус, шинжлэх ухааны байгууллагууд, холбоодын 55 гаруй байгууллагуудын төлөөлөл оролцуулсан сургалт семинарыг зохион байгуулж, “Их тайга” ХХК, “Эко эрдэнэ” ХХК-уудын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээ, үйлдвэрлэлийн шугамтай танилцсан.

АФАСИ ОУБ-аас хэрэгжүүлж буй “Органик хөдөө аж ахуйн Азийн орнуудын сүлжээ байгуулах” төслийн хүрээнд Органик Монгол хөтөлбөртэй хамтран ажиллах гэрээ байгуулан “Органик чацаргана ургуулах технологи нэвтрүүлэх” төсөл хэрэгжүүлж Багануур дүүрэгт чацаргана ургуулах технологийг УХЭШХ-ийн эрдэмтэдтэй хамтран боловсруулсан.

“Газар тариалангийн тогтвортой хөгжил” хөтөлбөр, Органик хүнсний үйлдвэрлэлийн талаар Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2014-2030 оны төлөвлөгөө, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах салбар дундын стратеги 2015-2020 оны төлөвлөгөөний төслүүдэд тусгуулах санал өгөөд байна.

Органик хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэр байгуулах, органик хүнсийг баталгаажуулах ТЭЗҮ боловсруулж байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 2.5. Бордоо, бага оврын техник, тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэх, угсрахыг дэмжих.

Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн Чингис бондын санхүүжилтээр хэрэгжүүлэх “Импортыг орлох, экспортыг дэмжих 888 төсөл”-ийн бордоо үйлдвэрлэх чиглэлийн төслүүдэд үнэлгээ хийсэн. Жилдээ нийт 50.6 мянган тонн эрдэс бордоо үйлдвэрлэх 8 үйлдвэр, 20.0 мянган тонн эрдэс бордоо үйлдвэрлэх хүчин чадалтай 1 үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхийг дэмжсэн саналыг 2014 оны 05 дугаар сарын 30-ны 01/2202 дугаар албан бичгээр уламжлан ЗГХЭГ-т, хувийг Хөгжлийн банкинд хүргүүлсэн. Мөн хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэх чиглэлийн төслүүдэд үнэлгээ хийсэн. Жилд нийтдээ 1610 техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэх хүчин чадалтай 3 үйлдвэрийн төслийг дэмжиж, саналыг Хөдөлмөрийн яаманд 2014.06.03-ны 01/2244 тоот албан бичгээр, ЗГХЭГ болон Хөгжлийн банкинд 2014.05.30-ны 01/2202 тоот албан бичгээр хүргүүлэв. Хувийн хэвшлийн хөдөө аж ахуйн техник үйлдвэрлэгч 3 компани нийт 6 төрлийн 56 ширхэг тоног төхөөрөмж үйлдвэрлэж худалдсан байна.

ХШҮ-70%

Зорилт 3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын бүтэц, салбар дундын зохицуулалт болон боловсон хүчний чадавхийг сайжруулах

ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/262 дугаар тушаалаар хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг /2009-2016 он/ шинэчлэн баталсан.

Үйл ажиллагаа 3.1. Монгол хүний бодисын солилцоо, илч зарцуулалт, хоол хүнсний шимт найрлагыг тодорхойлох лаборатори, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн дэргэдэх Шим тэжээл, хоол судлалын лабораторит 2011 онд улсын төсвийн санхүүжилтээр 100 сая төгрөгийн өртөг бүхий зарим тоног төхөөрөмж худалдан нийлүүлэв.

БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар МХЕГ-ын “Нэгдсэн төв лабораторийн барилга барих, техникийн чадавхи бэхжүүлэх” төслийн хүрээнд “Үндэсний лавлагаа лаборатори”-ийг байгуулж, 2013 онд ашиглалтад оруулсан.

Хүнсний инженер, биотехнологийн сургуулийн дэргэд улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн өртгөөр “Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв” байгуулагдсан.

Монгол улсын Үйлдвэр, Хөдөө аж ахуйн яам, БНСУ-ын Олон улсын Хамтын Ажиллагааны байгууллага /KOICA/ хоорондын хамтын ажиллагааны хүрээнд “Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтын лабораторийн чадавхийг бэхжүүлэх” төслийг /нийт санхүүжилт 1 сая ам.доллар/ Хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн “Само” институтэд 2013 оноос хэрэгжүүлж хүнсний нэгдсэн лабораторид өргөтгөл хийн 2014 оны 6 сард ашиглалтад оруулсан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас аймгуудын лабораторийн лаборантуудыг оролцуулан “Клиник лабораторийн чанарын гадаад үнэлгээ, стандартчилалын тогтолцоо” болон “Нян судлалын шинжилгээний арга” сэдэвт сургалтууд явуулсан. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори аймгуудын малын эмч нарыг оролцуулан магадлан шинжлэгч эмч нарын 3 хоногийн сургалт зохион байгуулсан. Украин Улсын Хөдөө аж ахуйн академитэй хамтарч “Тариалангийн талбайгаас хэрэглэгчдийн ширээ хүртэлх шинжилгээний хурдавчилсан арга” сэдэвт сургалтад МХЕГ-ын болон хүнсний худалдааны захууд, бусад холбогдох байгууллагын мэргэжилтэн, лаборантуудыг хамруулсан.

ҮХААЯ, “Хүнсний зах, төвүүдийн эздийн холбоо” ТББ-тай хамтран лабораторийн ажиллагсдын ур чадварыг сайжруулах сургалтыг зохион байгуулсан.

Салбар лабораторийн шинжээч нарын шинжилгээний ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2013.06.12-14-ны өдрүүдэд 3 дахь удаагаа “Гаалийн лабораторийн шинжээч-улсын байцаагчийн мэргэшүүлэх сургалт”-ыг зохион байгуулж, уг сургалтад гаалийн төв болон салбар лабораторийн 25 шинжээчийг хамруулсан.

Лабораторийн ажилтнуудад зориулан “Лаборатори итгэмжлэлд тавигдах шаардлага, MNS ISO/IEC 17025:2007” сэдэвт 3 өдрийн сургалтыг 2 удаа, “MNS ISO/IEC 17025:2007 стандартын дагуу аудит явуулах арга зүй” сэдэвт 2 өдрийн сургалтыг 2 удаа явуулж, сорилтын лабораторийн 150 гаруй ажилтныг хамруулсан.

Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран “Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд лабораторийн чанарын тогтолцоог сайжруулах болон био аюулгүй байдлыг сайжруулах асуудлаар лабораторийн чанарын менежментийн сургалтыг 2013 оны 9 дүгээр сард зохион байгуулж, 9 аймгийн 25 ажилтныг хамруулсан.

Мал эмнэлгийн холбоо, МХЕГ хамтран Нийслэл, Дундговь, Дорноговь, Завхан аймгуудын малын эмч нарт “МЭ-ийн эм бэлдмэлийн хяналт” сэдвээр 1 удаа, аймгуудын малын эмч нарт “Мал эмнэлгийн эм болон шинээр гарч буй өвчний хяналт” сэдвээр 2 удаагийн сургалт зохион байгуулав. 7 аймаг, хилийн боомтын 35 шинжээчийг хамруулан 7-14 хоногийн дадлагажих сургалт зохион байгуулагдсан.

Лабораторийн микробиологич нарт зориулан шинжилгээний хурдавчилсан арга, хувиргасан амьд организмыг илрүүлэн тодорхойлох, нян судлалын лабораторийн

биоаюулгүй ажиллагааг мөрдөх сургалтыг 10 дугаар сарын 8-наас 9-ний өдрүүдэд зохион байгуулж, 36 шинжээч, мэргэжилтэн хамрагдсан.

БНСУ-ын эрүүл ахуй, орчны судалгааны хүрээлэнгийн мэргэжилтнүүдийг урьж, НМХГ, Хүчит шонхор худалдааны төв, Мах маркет ХХК-ийн дотоод хяналт, сорилтын лабораторийг бэхжүүлэх, чадавхийг сайжруулах, туршлага солилцох ажил зохион байгууллаа.

ХШҮ-90 %

Үйл ажиллагаа 3.2. *Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд чанар, эрүүл ахуйн шинжилгээ хийх зориулалтаар улсын лавлагаа лаборатори байгуулж олон улсын итгэмжлэлд хамруулах.*

Олон улсын жишигт нийцсэн Хүнсний лавлагаа лаборатори байгуулахаар 2012-2013 оны улсын төсөвт 4.3 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 2012 онд 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр тоног төхөөрөмж нийлүүлэх ажил хийгдсэн. 2013 оны улсын төсөвт хүнсний лаборатори байгуулах, тоног төхөөрөмжийг нийлүүлэх 3.1 тэрбум төгрөг тусгагдсан.

ҮХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тендерээр нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмж, багажийг суурилуулах лабораторийн байрыг сонгон шалгаруулж, ҮХАА-н Сайдын 2013 оны А/91 дугаар тушаалаар ШУТИС-ийн ХИБС-ийн “Инкубатор төв”-ийн байранд суурилуулж, лабораторийн тоног төхөөрөмжийг ҮХААЯ-ны балансад бүртгэх ажлыг зохион байгуулан, төрийн өмчийн эд хөрөнгийг ашиглуулах гэрээ байгуулан ажиллав. Ажлын хэсэг лабораторийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, тохиргоо хийлгэх ажил дууссаны дараа хүлээн авч, гэрээ дүгнэсэн актыг үйлдсэн. Үүний дүнд ШУТИС-ийн Хүнсний инженер, биотехнологийн сургуулийн дэргэд 4.3 тэрбум төгрөгийн өртгөөр “Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв” байгуулагдан орчин үеийн өндөр үзүүлэлттэй лабораторийн тоног төхөөрөмжөөр, өндөр ур чадвартай боловсон хүчнээр хангагдан 2015 онд итгэмжлэлд хамрагдахаар ажиллаж байна.

БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар МХЕГ-ын “Нэгдсэн төв лабораторийн барилга барих, техникийн чадавхи бэхжүүлэх” төслийн хүрээнд “Үндэсний лавлагаа лаборатори”-ийг байгуулж, 2013 онд ашиглалтад оруулсан. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, итгэмжлэгдсэн төрийн болон орон нутгийн, хувийн өмчит лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй энэ лавлагаа лабораторийн ажиллах дүрэм, журам Засгийн газрын 2013 оны 330 дугаар тогтоолоор батлагдан, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

ХАБ-ын Үндэсний Лавлагаа лабораториос 2014 онд лабораторийн итгэмжлэлийн хүрээг хувиргасан амьд организмыг илрүүлэн тодорхойлох 13 үзүүлэлт, хөрсний шинжилгээний 4, хүнсний бүтээгдэхүүнд бенз-а-перин 1 үзүүлэлт, GC-MS аргаар 14 пестицид, эм биобэлдмэл дэх GC аргаар үлдэгдэл уусгагч тодорхойлох 1, биологийн идэвхит нэгдэл тодорхойлох 4, ургамлын эрүүл ахуйн 7, нийт 42 үзүүлэлтээр өргөтгөсөн.

“Эм биобэлдмэлийн хяналтын лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, мэргэжилтэнг сургах, MNS/ISO IEC 17025:2005 стандартын дагуу олон улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлэх” төслөөр тус лабораторийг үнэлэх олон улсын итгэмжлэлийн байгууллагын сонгон шалгаруулалт төгсгөлийн шатанд явагдаж байна. Сонгон шалгаруулалтын дүнгээр АНУ-ын итгэмжлэлийн байгууллага /ACCLASS2/-аас үнэлгээний баг томилогдон ажиллахаар болж байна. Тус лаборатори 2014 онд 46150 сорьцонд 146919 үзүүлэлтээр шинжилгээ хийж, 601.582.348 төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Үйл ажиллагаа 3.3. Үйлдвэрүүдийг дотоод хяналтын лабораторитай болгож, орон нутаг дахь хяналтын лабораториудыг бэхжүүлэн уялдаа, холбоог сайжруулах.

Хүнсний үйлдвэрийн дотоодын чанарын хяналтын лабораторийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр 2010 онд 10 үйлдвэрт 250.0 сая төгрөгийн дэмжлэгийг төсөл сонгон шалгаруулалтын журмаар олгосон.

МХЕГ-ын Нийслэлийн Лабораторид 2011 онд өндөр идэвхит шингэний хроматографийн багажийг тохиргоонд оруулж, шинжээчийг сургалтад хамруулж, багажийг ашиглаж эхлэв. Булган, Сэлэнгэ аймаг болон Хөтөл дэх ТЭДС-ийн салбаруудад 2011 онд буудайн чанар, чийг, хог, хольц, цавуулгийг хэмжигч 9 төрлийн тоног төхөөрөмжийг худалдан авч, явуулын лабораторийг байгуулан лаборантуудыг сургалтад хамруулж, мэргэжлийн үнэмлэх олгов.

Хүнсний жижиг, дунд үйлдвэрүүдэд хөндлөнгийн болон дотоодын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сайжруулах зорилгоор МХЕГ-ын даргын 2011 оны 94 дүгээр тушаалаар хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 20, хоол үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр тус бүр 1 хяналтын хуудсыг батлан мөрдөж байна. Хяналт шалгалт хийх объектыг эрсдлийн түвшингөөр нь үнэлж, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, эрсдлийн мэдээллийн сангийн суурийг тавьсан. ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/237 дугаар тушаалаар “Хүнсний үйлдвэрүүдэд дотоодын чанарын хяналтын бүртгэл хөтлөлтийн загвар журнал”-ыг батлуулж, хүнс үйлдвэрлэлийн эрсдэлд суурилсан хяналтын талаар 4 гарын авлага бэлтгэн үйлдвэрлэгчид мөрдөн ажиллаж байна.

“Хүнсний тухай” хуулийн 12 дугаар зүйл болон “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулиар /2012/ хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг хуульчилж өгсөн. Эдгээр хуулиудтай холбогдуулан Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам”-ын төслийг боловсруулан Засгийн газрын 2014 оны 157 дугаар тогтоолоор батлуулав.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд хүнсний үйлдвэрийн дийлэнх нь дотоодын хяналтын лабораторитой болж бүтээгдэхүүний яанар, аюулгүй байдлыг баталгаажуулж байна.

“Талх чихэр”, “Атар өргөө”, “Тесто”, “Сүү”, “Сtimo” зэрэг хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг томоохон компаниуд лабораторийнхаа чадавхийг ISO/IEC 17025 стандартын дагуу тогтоолгон итгэмжлэгдсэн. Мах боловсруулах 35 үйлдвэр болон сүү боловсруулах 4 үйлдвэр түүхий эд, бэлэн бүтээгдэхүүндээ дотоод хяналт явуулах лабораториудтай болж, СХЗГ-аар итгэмжлэгдэн ажиллаж байна.

Аймгуудын Мэргэжлийн хяналтын байгууллагын харьяа лабораторийн хүчин чадлыг сайжруулах, багаж, тоног төхөөрөмжөөр хангахад Хөвсгөл аймаг 217,5 сая, Дорноговь 33 сая / 20 сая төгрөгийн лабораторийн засварын ажил/, Говьсүмбэр 30 сая, Баян-Өлгий 45 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, Ховд аймаг 2 үйлдвэрт 20.4 сая төгрөгийн зээлийг ЖДҮ хөгжүүлэх сангаас олгосон байна. Өвөрхангай аймагт шинээр 4 үйлдвэр, цех дотоодын хяналтын лабораторитой болж, 6 хүнсний үйлдвэр урвалж, багаж тоног төхөөрөмжөө сайжруулсан байна.

Европийн Холбооны “Мал эмнэлэг, мал аж ахуйн зах зээл” төслөөс 330.7 сая төгрөг, Мерси-Кор олон улсын байгууллагаас 31.7 сая төгрөгийн дэмжлэг авч төсөл хэрэгжиж буй аймгуудын лабораторийн чадавхийг сайжруулсан.

2010-2012 онд Европын Холбооны “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төслөөс

1. Төсөл хэрэгжсэн бүс нутаг дахь 190 гаруй хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид нийт 291,000 еврогийн лабораторийн болон мал эмнэлгийн багаж хэрэгсэл олгосон.
2. Төрийн захиргааны болон сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газарт дор дурдсан тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нийлүүлсэн байна.

ТӨСЛӨӨС НИЙЛҮҮЛСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЭЛ

Хүлээн авагч	Үнийн дүн(евро)	Нэр төрөл
Биокомбинат ТӨААТҮГ	52000	Хөргүүр, компьютер, авто машин
ШУТИС-ХИБТС	29000	Мах шинжлэгч
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	31000	Мах шинжлэгч
МАЗЭШХ	4020	Хөргүүр
ХААИС	91000	Лабораторийн багаж, компьютер
Малын удмын сангийн үндэсний төв	2200	Сүү шинжлэгч
Булган аймгийн мал эмнэлгийн алба	86000	Лаборатори, мал эмнэлгийн багаж, компьютер, хөргүүр
Дархан-Уул аймгийн мал эмнэлгийн алба	69000	Лаборатори, мал эмнэлгийн багаж, компьютер, хөргүүр
Орхон аймгийн мал эмнэлгийн алба	62500	Лаборатори, мал эмнэлгийн багаж, компьютер, хөргүүр
Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн алба	95000	Лаборатори, мал эмнэлгийн багаж, компьютер, хөргүүр
Төв аймгийн мал эмнэлгийн алба	124000	Лаборатори, мал эмнэлгийн багаж, компьютер, хөргүүр
Улаанбаатар хотын мал эмнэлгийн алба	58000	Лаборатори, мал эмнэлгийн багаж, компьютер, хөргүүр
МЭЭШХ	13800	Хөргүүр
УМЭАЦТЛ	96000	Лабораторийн багаж, компьютер, хөргүүр, хийн хроматограф, масс спектрометр
МЭЭСБУЛ	45000	

Хөвсгөл аймгийн “Алтан жолоо” ХХК шинээр микробиологийн орчин үеийн лабораторитой болж, “Хөвсгөл Хүнс” ХХК нь 20 сая төгрөгийн багаж төхөөрөмжийг өөрийн лабораторит суурилсан. Мөн тус аймгийн гурилын үйлдвэрүүд өндөр хүчин чадлын лабораторитой болсон.

“Хүнсний тухай” болон “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулиудын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 330 дугаар тогтоолоор МХЕГ-ын “Үндэсний лавлагаа лаборатори”-ийг баталгаажуулж аймаг, орон нутагт байгаа лабораториудыг нэгдсэн сүлжээтэй болгох, бэхжүүлэх, чадавхийг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үнэлгээний явцад дотоод хяналтын лабораторитой байх шаардлагыг үнэлгээний гол шалгуур үзүүлэлт болгосноор дунд болон томоохон аж ахуйн нэгжүүд өөрийн лабораторитой болсон.

2014 онд Баянхонгор аймгийн МХГ-ын хими, нян судлалын лабораторид SAS SUPER ISO100, LUMEX –RA 915 мөнгөн ус тодорхойлох багаж, Кельдалын аппарат, бусад тоног төхөөрөмж, Дундговь аймгийн МХГ-ын лабораторид аймгийн хөгжлийн сангаас 53 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдүүлж, тоног төхөөрөмж, урвалж, бодис, Сэлэнгэ аймгийн МХГ-ын лаборатори 50 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 16 ширхэг тоног төхөөрөмж, шил сав, багаж хэрэгслийг нийлүүлсэн. Нийслэлийн мал эмнэлгийн хүнсний лаборатори АПС, гаммаспектрометр, трихинеллскоп, цус ба шээсний анализатор, биохимийн анализатор багажаар тоноглогдсон. НМХГ-ын Төв

лаборатори Нийслэлийн хөрөнгөөр, 74.6 сая төгрөгийн өртөгтэй лабораторийн шинэ барилгын зургийг “Арчис” компани гүйцэтгэж байна.

Завхан-Хүнс трейд ХХК-нь лабораторио стандартын шаардлагад нийцүүлэн 24.5 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар тохижуулж, баталгаажуулалтанд хамруулахаар ажиллаж байна.

ХШҮ-70 %

Үйл ажиллагаа 3.4. Хилийн боомтуудад үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллагыг хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдэд анхан шатны үнэлгээ хийх хурдавчилсан шинжилгээний багаж төхөөрөмжөөр хангаж, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх.

2012 онд хилийн боомтууд дахь 6 салбар лабораториуд үйл ажиллагаагаа явуулж ажилласнаар 370 нэр төрлийн 1119 дээжинд шинжилгээ хийж, 620 дүгнэлт гаргаж, ангиллын код зөрсөн 63 зөрчлийг илрүүлж, шинжилгээний хураамжаар 34.1 сая төгрөгийг улсын төсөв оруулсан байна.

Дорнод, Замын-Үүд дэх гаалийн газрын салбар лабораториудыг итгэмжлэгдсэн лабораторийн эрх авах үйл ажиллагааны хүрээнд салбар лабораториудад хэрэглэх Чанарын гарын авлага, холбогдох 27 журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.

Хилийн боомт дахь лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хурдавчилсан шинжилгээний аргыг нэвтрүүлэх, итгэмжлэлд хамруулах чиглэлээр:

Стандартчилал, хэмжил зүйн газрын итгэмжлэлийн үнэлгээний ажлын хэсэг 2012.06.14-17-ны өдрүүдэд Замын-Үүдийн гаалийн боомт дахь салбар лабораторит ажиллаж, MNS ISO 17025 "Сорилтын болон калибровкийн лабораторит тавих техникийн шаардлага" стандартын хүрээнд үнэлгээ хийсэн. СХЗГ-ын Техникийн зөвлөлийн 2012 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Замын үүдийн гаалийн боомтын салбар лабораторийг 2 жилийн хугацаагаар итгэмжилсэн;

Дорнод аймаг дахь гаалийн боомтын лабораторийг итгэмжлүүлэх ажлыг СХЗГ-ын үнэлгээний ажлын хэсгийн хуваарьт оруулсан;

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын лаборатори нь Стандартчилал, хэмжил зүйн газрын 2013 оны 6 дугаар сарын 28-ын техникийн хорооны хурлаар орж, 3 жилийн хугацаатайгаар итгэмжлэлийн эрхээ авсан. Бусад боомтын лабораториудын итгэмжлэлийн эрх хүчинтэй байгаа;

Баян-Өлгий аймгийн Цагаануур боомтын химийн лабораторит 20 сая төгрөгийн үнэ бүхий шинжилгээний багаж төхөөрөмжийг олгосон.

2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу салбар лабораториудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай химийн урвалж бодис, шилэн сав суулгаар хангах арга хэмжээ авсан. Хяналт шалгалтын ажлын дүнг баталгаажуулах лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн нэгдсэн лаборатори, Цагаануур боомтын химийн лабораториудад 55.0 сая төгрөгийн үнэ бүхий шинжилгээний багаж төхөөрөмж нэмж олгосон байна. Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийн эрхлэгч, халдвартын их эмч, Мэргэжлийн хяналтын газрын химийн лаборантыг Улаанбаатар хотод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан.

2014 онд төсвийн хөрөнгө оруулалтаар “Гаалийн байгууллагуудын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл” төсөл, арга хэмжээнд 1.9 тэрбум төгрөг, “Гаалийн албаны мэдээллийн системийг бэхжүүлэх” төсөл, арга хэмжээнд 235.4 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон. Хилийн 15 боомтод орох гарах чиглэлд 80 ширхэг цацраг илрүүлэгч монитор суурилагдсан.

ХШҮ- 90 %

Үйл ажиллагаа 3.5. *Хүнсний үйлдвэрлэл, экспорт, импорт, хүн амын хүнсний хэрэглээ, эрүүл мэндийн мэдээллийн сан, мэдээллийн сүлжээ бий болгох.*

“Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Хяналтын байгууллагын дэргэд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, итгэмжлэгдсэн төрийн болон орон нутгийн, хувийн өмчит лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний лавлагаа лаборатори байгуулагдаж, ажиллах дүрэм журам нь батлагдан, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Эрдэм шинжилгээ, судалгаа, эрсдлийн үнэлгээний төвийг 2014 онд байгуулан ажилласнаар эрсдлийн үнэлгээ, ур чадварын сорилтын хөтөлбөр, мэдээллийн санг бүрдүүлэх үйл ажиллагааг бүрэн эхлээд байна.

Хүнсний аюулгүй байдлын тогтолцоог шинэчлэн сайжруулах чиглэлээр НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллагад хүсэлт гарган Олон улсын Зөвлөх ирүүлж, “Монгол улсын Хүнсний аюулгүй байдлын өнөөгийн байдал сайжруулах арга зам” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Олон улсын зөвлөхийн өгсөн зөвлөмжийн дагуу санал боловсруулан, Улсын Их Хурлын зарим гишүүд болон холбогдох хүмүүст танилцуулсан. “Хүнсний тухай” хуулийн 7.3, 9.1.1, 16.1 гэсэн заалтуудаар хувиргасан амьд организмээс гаралтай хүнс, хүнсний шим тэжээлийн зохистой байдал, баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүртгэлийн асуудлыг шийдвэрлэсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Олон улсын хүнсний аюулгүй байдлын нэгдсэн сүлжээ (INFOSAN)-нд холбогдон мэдээлэл солилцож байна. Хилийн боомтын байцаагч нар болон аймаг орон нутгийн хүнсний мэргэжилтнүүдэд онлайн сургалт явуулах боломж бүрдсэн.

ҮХААЯ-ны www.mofa.gov.mn, худалдааны чиглэлээр www.mongoliantrade.mn, ЭМЯ-ны www.moh.mn, МХЕГ-ын www.ssia.gov.mn, www.mhg.bgd.gov.mn, Стандартын байгууллагын www.masm.gov.mn, www.estandart.mn, Гаалийн ерөнхий газрын www.customs.pmis.gov.mn, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн www.ttcenter.mn зэрэг вэб сайтуудаар дамжуулж хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл, зохистой хооллолтын талаар олон нийтэд мэдээлэл өгч байна.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 3.6. *Хүнсний хангамж, тэжээллэг чанар, аюулгүй байдлын асуудлыг хангахад төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж өргөнөөр оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх.*

Шинээр батлагдсан “Хүнсний тухай” хууль болон “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн төсөлд Монголын хүнсчдийн холбоо болон мэргэжлийн холбоодын саналыг авч тусгасан. Мөн эдгээр хуулийн хүрээнд боловсруулж буй журмын төслүүдийг боловсруулах ажлын хэсэг, “Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай” болон “Органик хүнсний тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнд салбарын ТББ болон ЭШ-ний байгууллагын төлөөлөл оролцуулан, санал авч хамтран ажиллаж байна.

Стандартчиллын техникийн хороодын бүрэлдэхүүнийг батлах, стандарт боловсруулах ажлын хэсгээс стандартын төслийг хэлэлцүүлэх, боловсруулж буй стандартын төсөлд санал авах зэрэг арга хэмжээнд төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийг оролцуулж байна.

СХЗГ-ын дэргэд төрийн болон төрийн бус байгууллагууд, хэрэглэгчийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус баталгаажуулалтын зөвлөл ажиллаж, бүтээгдэхүүн, үйлчилгээнд явуулсан тохирлын үнэлгээний дүн болон аж ахуйн нэгж байгууллагын тогтолцоонд хийсэн аудитын дүнг үндэслэн хараат бус байдлаар шийдвэр гарган ажилладаг. Тус зөвлөл 2012 онд 8 удаа хуралдаж “Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо /MNSISO22000:2007/-ны стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлсэн 2 аж ахуйн нэгж, байгууллагад хийсэн давтан аудитын дүн, “Үндэсний тохирлын тэмдэг” хэрэглэх эрх олгох 3 аж ахуйн нэгжийн 4 нэрийн бүтээгдэхүүн, эрхийн хугацаа сунгах, 7 аж ахуйн нэгжийн 17 нэрийн бүтээгдэхүүн, дотоодын үйлдвэрлэлийн 46 аж ахуйн нэгжийн 280 нэр төрлийн бүтээгдэхүүнд явуулсан тохирлын үнэлгээ, аудитын дүн зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Дээрх зөвлөл нь 2013 онд 9 удаа хуралдаж Чанарын удирдлагын тогтолцоо-ISO9001 стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлсэн 20 аж ахуйн нэгж, байгууллагад хийсэн анхдагч болон давтан аудитын дүн, “Үндэсний тохирлын тэмдэг” хэрэглэх эрх олгох 23 аж ахуйн нэгжийн 96 нэрийн бүтээгдэхүүний эрхийн хугацаа сунгах буюу шинээр олгох, дотоодын үйлдвэрлэлийн 75 аж ахуйн нэгжийн 481 нэр төрлийн бүтээгдэхүүнд явуулсан тохирлын үнэлгээ, аудитын дүн зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, өмнөх оноос илүү ачаалалтай ажилласан байна.

Стандарт боловсруулах асуудал иргэн, аж ахуйн нэгж байгууллагад нээлттэй бөгөөд нөгөө талаас стандартын төслийг хэлэлцэхэд аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч байна.

Төрийн захиргааны зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлын хүрээнд онд 2014 сургалт, сурталчилгаа, судалгааны ажлыг гүйцэтгэхэд 5 төрийн бус байгууллага, холбоо оролцов.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 3.7. Газар тариалангийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах, эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн холбоог өргөтгөх.

2014 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод усалгааны дэвшилтэт техник технологи эзэмшүүлэх богино хугацааны сургалтанд 15 хүн оролцуулсан.

НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж буй “Ургамал хамгааллын салбарын чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд МХЕГ-ын хилийн хорио цээрийн байцаагч нарт зориулсан “Хилийн нэвтрүүлэх цэг дээрх хөнөөлт организмын хяналт шалгалт”-ын талаарх сургалт, Дархан –Уул аймагт орон нутгийн агрономи, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон ургамал, хорио цээрийн мэргэжилтнүүд нийт 200 гаруй хүнийг хамарсан “Үр тариа, төмс хүнсний ногоонд ургамал хамгааллын цогцолбор аргыг хэрэглэх”, “Пестицидийн менежмент” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан.

Тосонцэнгэл суманд МСҮТ шинээр байгуулагдаж Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо нөөшлөх мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх чиглэлээр элсэлт авч эхний 25 элсэгчийг сургаж, мэргэжил эзэмшүүлэх нөхцөл бүрдсэн.

ХШҮ-70%

Зорилт 4: Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах;

Үйл ажиллагаа 4.1. “Мах”дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй, мах боловсруулах үйлдвэрүүд болон махны экспортын үйл ажиллагаа эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж, махны үйлдвэрлэл, хангамж, үнийн улирлын хэлбэлзлийг бууруулах.

Улсын хэмжээнд жилд дунджаар 8.2 гаруй сая толгой мал хүнсэнд хэрэглэж, 200 орчим мянган тн мах үйлдвэрлэн, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг.

МАХ ҮЙЛДВЭРЛЭЛ, мянган тонн

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014 УГ
ХАА-аас бэлтгэсэн мах	269	204.4	210.0	220.4	249.7	294.5
Үйлдвэрийн аргаар боловсруулсан мах	21.4	14.7	16.6	13.1	19.7	15.1
Экспортлосон малын мах	17.9	23.8	10.6	3.7	3.0	2.3

Эх сурвалж: Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал 2014/12, Хөдөө аж ахуй 2013

Хэрэглээний зориулалттай малын тоо болон хэрэглээнд зарцуулсан малын тооны зөрүүгээр экспортод гаргах боломжтой малын тоо гарах боловч, малын эрүүл мэнд, махны үйлдвэрүүдийн нөхцөл байдлаас шалтгаалан уг боломжийг бүрэн ашиглаж чадахгүй экспортын махны хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Хэрэглээний зориулалттай мал, хэрэглээнд зарцуулсан малын тоо, сая.тол



2014 онд махны нөөц бэлтгэх боломжтой малын тоо 13.7 сая толгойд хүрч, үүний 49.0 хувь нь ямаа, 40.0 хувь нь хонь, 6.1 хувь нь адуу, 4.4 хувь нь үхэр, 0.5 хувь нь тэмээ байна.

Засгийн газрын 2010 оны “Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоолоор махны үнийн өсөлтийг сааруулах зорилгоор хүн амын хаврын махны хэрэгцээнд зориулан мах нөөцлөн борлуулах арга хэмжээ авч үйлдвэрүүдэд 2011 онд 8.0 тэрбум, 2012 онд 10.8 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон.

Монгол банкны ерөнхийлөгч болон ҮХАА-н сайдын хамтарсан 2012 оны А/166, А/24 тоот “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2013 оны хэрэгцээнд зориулан 11,4 мян.тн махны нөөц бэлтгэж, 87.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, хуваарийн дагуу 100 хувь буцаан төвлөрүүлсэн. Хэдийгээр нөөцөлсөн мах дээрх 3 хотын хүн амын 1-7 хүртэлх сарын махны хэрэгцээний зөвхөн 24.0 хувийг хангаж байсан боловч махны үнийн өсөлтийн эрчим хөтөлбөр хэрэгжүүлсэн хугацаанд буюу 2012 оны 10 дугаар сараас 2013 оны 7 дугаар сарын хооронд өмнөх оны мөн үеэс 2 дахин бага байв. Мөн мах, махан бүтээгдэхүүний жилийн инфляцийн түвшин 2013 оны 7 дугаар сарын байдлаар 6.2 хувьтай байгаа нь өмнөх 5 жилийн дундаж өсөлтөөс 3.7 дахин бага байна.

2014 онд Улаанбаатар хотод “Баатарууд тэнгэр” ХХК 6001.6 тн, “Эй Эн Ди Эм” ХХК 6560.3 тн, Дархан хотод “Дархан мийт фүүд” ХХК 1000.0 тн, Эрдэнэт хотод “Эрдмийт” ХХК 1001.5 тн нөөцийн мах бэлтгэн, сертификатаар баталгаажуулан худалдан борлуулж байна. УИХ-ын 2013.11.14-ны 62 дугаар тогтоолын 4.1-д заасны дагуу зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх зорилгоор хөтөлбөрийн санхүүжилтийн 20%-ийг банкны өөрийн эх үүсвэрээр, 80%-ийг Монголбанкны эх

үүсвэрээр санхүүжүүлэв. Нөөцийн махны худалдааг 2013 оны 12-р сарын 25-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, 2014 оны 5-р сарын 25-ны өдрийн байдлаар 8547.4 тн (нийт бэлтгэсэн махны 61.1%) махыг борлуулж, хуваарийн дагуу 31.5 тэрбум төгрөгийн зээлийг буцаан төлөөд байна. Энэ хугацаанд махны жижиглэн худалдаалах үнийн хэлбэлзэл (жилийн дундаж өсөлтөөр тооцов) өнгөрсөн оноос 2.3 дахин бага, хөтөлбөр хэрэгжүүлэхээс өмнөх 3 жилийн дунджаас 5.1 дахин бага байна.

“Нөөцийн махны менежер”-т урамшуулал олгох ажлын хүрээнд нөөцийн махны тонн тутамд 1000 төгрөгөөр тооцон 2014 онд 14.0 тэрбум төгрөгийн урамшуулал олгохоос гэрээний явцыг дүгнэж, 9.5 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон ба үлдэх 4.5 тэрбум төгрөгийн урамшууллын санхүүжилт хүлээгдэж байна.

2013 оны хүн амын хэрэгцээнд зориулж УБ хотын жилийн нийт махны хэрэгцээний 15.4 хувийг бүрдүүлсэн бол 2014 онд 16.2 хувийг бүрдүүлээд байна.

2015 онд: Улаанбаатар хотын хүн амын 2015 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх, хадгалах, ангиалан савлах, худалдаалах үйл ажиллагааг гүйцэтгэх нөөцийн махны менежерийн 1 дүгээр багцад “Эи Эн Ди Эм” ХХК, 2 дугаар багцад “Мах импекс” ХК, 3 дугаар багцад “Баатарууд тэнгэр” ХХК, 4 дүгээр багцад “Мах маркет” ХХК-ийг тус тус шалгаруулж, оролцогч тус бүр 3000 (гурван мянга) тонн махны нөөц бүрдүүлэхээр МХЕГ, ОБЕГ-уудтай хамтран дөрвөлсөн гэрээг байгуулаад байна.

Дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл сонгон шалгаруулалтад 310 иргэн, хуулийн этгээдийн төсөл ирснээс “Эрчимжсэн мал аж ахуйн” чиглэлээр шаардлага хангасан 160 иргэн, аж ахуйн төслийг харилцагч арилжааны 10 банкуудад хувиарлан техник, эдийн засаг, үр ашгийн тооцоо, эрсдлийн үнэлгээг арилжааны банкуудтай хамтран хийв.

Үр дүнд нь эрчимжсэн мал аж ахуйгаас нийлүүлэх махны үйлдвэрлэлийг, ялангуяа шинэ махны хаврын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл ирүүлсэн 6 иргэн, 59 аж ахуйн нэгжид нийт 71.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг өгөх боломжтой гэсэн дүгнэлт гарсан. Ажлын хэсэг нарийвчилсан үнэлгээ, судалгааг дахин хийж, төслийн ач холбогдол, зах зээлд шинэ мах нийлүүлэх хүчин чадал, төсөл хэрэгжүүлэх боломж зэрэг шалгуур үзүүлэлтүүдээр эрэмбэлэн эхний ээлжинд 3 иргэн, 40 аж ахуйн нэгжтэй ҮХААЯам “Төсөл хэрэгжүүлэх бодлогын гэрээ” байгуулан 46.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгуулах шийдвэрийг Монголбанкинд хүргүүлсэн.

Засгийн газрын 2013 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу 2013 онд экспортлох, импортлох хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг боловсруулан Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлд танилцуулсан. Үндэсний зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн хонины мах 2.0 мян.тн, адууны мах 7.5 мян.тн, ямааны мах 750.0 тн, ундны савласан цэвэр ус 100.0 тн-ыг эспорлохоор, үхрийн мах 2.0 мян.тн, гурил 50.0 мян.тн, хуурай сүү 4.2 мян.тн, үйлдвэрийн аргаар боловсруулсан шингэн сүү 350.0 тн, ундны цэвэр ус 3.0 мян.тн-ыг импортлохоор шийдвэрлэж, яамны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулан олон нийтэд мэдээлсэн. 2013 онд хонь, адууны мах 6.4 мян.тн экспортлох зөвшөөрлийг 11 ХХК, үхрийн мах 143.0 тн импортлох зөвшөөрлийг 3 ХХК-д тус тус олгов.

“Махны чиглэлийн цэвэр үүлдрийн үхэр импортолж, аж ахуй эрхлэх” төсөл сонгон шалгаруулах тендерт шалгарсан Гацуурт ХХК-тай гэрээ байгуулж, Франц улсаас импортоор оруулж ирсэн “Limousin” үүлдрийн 144 толгой үхэр (Үүнээс: 138 толгой нь үнээ, 6 толгой нь бух), “Montbeliarde” үүлдрийн 32 толгой үхэр (Үүнээс: 30 толгой нь

үнээ, 2 толгой нь бух) нийт 176 толгой үхрийг хүлээлгэн өгсөн. Энэ арга хэмжээнд 1 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

2013 оны байдлаар махны үхрийн 70 аж ахуйд 5675 үхэр, мах-сүүний 418 аж ахуйд 8853 үхэр, мах, гахайн 314 аж ахуйд 31501 гахай, тахианы 309 аж ахуйд 543974 толгой тахиа үржүүлж байна.

МАХНЫ ЧИГЛЭЛЭЭР ӨСГӨН ҮРЖҮҮЛЖ БҮЙ

Бүс	2013 он		2014 он	
	Аж ахуйн тоо	Үхрийн тоо	Аж ахуйн тоо	Үхрийн тоо
Нийт	508	14789	351	12705
Баруун	12	287	26	1189
Хангайн	363	5926	180	3698
Төвийн	120	6732	89	6239
Зүүн	12	1742	53	1315
УБ	1	102	3	264

Мөн махны чиглэлийн тахиа үржүүлэхэд зориулж “Түмэн шувуут” ХХК-д 2 тэрбум, “TAST” ХХК-д 1.7 тэрбум, “Ажигана” ХХК-д 4.9 тэрбум нийт 8.6 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Улаанбаатар хотын “Ажигана” ХХК нь 2013 онд БНСУ-аас махны чиглэлийн үр тогтсон 83520 ширхэг өндөг импортлон тэдгээрээс 75.8 хувиар буюу 63.3 мянган дэгдээхэй бойжуулж мах бэлтгэсэн байна. Мөн “Ажигана Мах импекс” ХХК нь БНСУ, Бельги улсаас 120240 өндөг импортлон тэдгээрээс 77.1 хувиар буюу 92.7 мянган дэгдээхэй бойжуулж махны хэрэгцээнд нийлүүлсэн байна.

ХШҮ- 90%

Үйл ажиллагаа 4.2. Хот, суурин газрын захын дүүрэг, хороолол, хөдөөгийн орлого багатай иргэдэд зуны болон өвлийн хүлэмж, гахай, шувуу, зөгий, туулайн аж ахуй эрхлэх, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалахад нь санхүүгийн болон мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж, санал боловсруулах.

ЖДҮХС-аас 2014 оны байдлаар хүнсний үйлдвэрлэлийн салбарт 383.0 сая, гахайн аж ахуйд 2330.0 сая, газар тариалангийн салбарт 12634.5 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн. Гахайн мах үйлдвэрлэх, боловсруулах чиглэлээр төсөл боловсруулсан “Зургаан хошуу” ХХК, “Түмэн тооройт” ХХК, “Данзамд хайрхан” ХХК-ийн зээлийн асуудлыг холбогдох банкуудаар шийдвэрлүүлж, 2014 онд нийт 4.5 тэрбум төгрөгийн зээлийг олгуулсан. Төсөл хэрэгжсэнээр гахайн махны үйлдвэрлэл 1076 тн-оор нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

2014 онд ОХУ-ын Башкирын БНУ-аас өндөр ашиг шимтэй 800 бүл зөгийг, шаардлага хангасан үүр хайрцагтай нь болон 500 эх зөгийг тус тус импортоор оруулж ирж, зөгийн аж ахуй эрхэлж буй 61 иргэн, аж ахуйн нэгжид эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгох ажлыг зохион байгуулав. ОХУ-ын Башкирын БНУ-аас дээрх өндөр ашиг шимтэй зөгийн бүлийг импортлон оруулж ирснээр 1 бүл зөгийнөөс жилд 20 кг бал авдаг байсныг 50 кг зөгийн бал хүртэл нэмэгдүүлж, үүний үр дүнд 2015 онд 50 тн зөгийн бал үйлдвэрлэх боломж бүрдэж байна. Мөн 1 зөгийн бүлээс жилд 3 бүл салгах боломжтой болж 2016 он гэхэд дотооддоо 150 тн зөгийн бал үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангах, импортын зөгийн балыг бууруулах зорилттой ажиллаж байна. “Зөгийн аж ахуйн лабораторийн тоног төхөөрөмж, эм урвалж” нийлүүлэх тендерийг зарлаж, гэрээний дагуу нийлүүлсэн лабораторийн тоног төхөөрөмжийг хүлээн авч холбогдох газар хуваарилан олгов. Зөгийн аж ахуй хөгжүүлэх боломжтой Хэнтий нурууны эхлэл, Төв аймгийн Мөнгөнморьт сум,

Хангай нурууны хэсэг Булган аймгийн Хялганат сумдын нутагт ургамлын зүйлийн бүрдлийг тодорхойлох болон балт ургамлын нөөц тогтоож, зөгийн бэлчээрийн зураглал гаргаж орон нутагт зөгийг үр ашигтайгаар үржүүлэх зөвлөмжийг холбогдох судалгааны болон ТББ-тай хамтран боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулав.

ҮХААЯ-ны багцад “Зөгийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх /орон нутагт/” төсөл арга хэмжээнд 1396.5 сая төгрөг олгосон. Энэ төслийн хүрээнд орон нутагт ҮХААЯ-аас тендер зарлан шалгарсан зөгийн аж ахуй эрхэлдэг 1 хоршоо, 5 иргэнд эргэн төлөгдөх нөхцөлтэй 76.8 сая төгрөгийн үнэтэй зөгийн бүл, үүр хайрцаг олгож дэмжлэг үзүүлсэн байна.

Орон нутаг бүр сум хөгжүүлэх сангаас мах, гахай, тахиа, ямааны болон зөгийн аж ахуйг хөгжүүлэхэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн. Үүнд: Сэлэнгэ аймаг сум хөгжүүлэх сангаас хүлэмжийн чиглэлээр 48 сая, гахайны аж ахуйн чиглэлээр 32.8 сая төгрөг, зөгий 4 сая төгрөг; Орхон аймагт хүнсний үйлдвэрт орон нутгийн ЖДҮДС-аас 60.0 сая төгрөг, СХС-аас 64 сая төгрөгийн зээлийн зээл олгосон ба **Баян-Өндөр суманд сум хөгжүүлэх сангаас тахиа, гахай, зөгийн аж ахуйн чиглэлээр 88.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг**, Өвөрхангай аймагт 477.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг, Архангай аймагт ҮХААЯ-наас сүүний үхэр, зөгий, гахай, шувууны чиглэлээр 65.0 сая төгрөг олгож, ЖДҮХСангаас 52 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Чиглэл	2012 он	2013 он	2014*
Гахайн аж ахуйн тоо	181	314	476
Гахайн тоо	17775	31501	46305
Тахианы аж ахуйн тоо	152	319	405
Тахианы тоо	594936	544234	785013
Туулайн аж ахуйн тоо			30
Туулайн тоо			521
Зөгийн аж ахуйн тоо			83

Эх сурвалж:ХАА-2013, УСХ

Хүлэмжийн аж ахуй эрхлэх сониорхолтой 4 иргэнд 5.3 сая төгрөгийн өртөг бүхий 2 хүлэмж, 3 бичил услалтын систем буцалтгүйгээр олгосон. Чингис бондын эх үүсвэрээс 2014 оны жилийн эцсийн байдлаар хүлэмжийн аж ахуйн 28 төсөлд 22.17 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 4.3. *Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, ургамлын тос, өндөг, загасны хангамжийг тогтворжуулах зорилгоор дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.*

Монголд ургах боломжтой жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2013 онд 74 иргэн, аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаатай 2.4 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлж жимс жимсгэний талбайг 150 га-гаар нэмэгдүүлсэн. Дотоодын үржүүлэгчдээс 770.0 мянган ширхэг чацарганы суулгацыг худалдан авч 18 аймгийн 208 иргэн аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаатай зээлээр олгож тариалуулан чацарганы тариалалтыг 616 га-гаар нэмэгдүүлэв.

“Чацаргана” хөтөлбөрийн хүрээнд ҮХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны А/154 дугаар, А/369 дугаар тушаалаар 118 иргэн байгууллагад 271.4 мянган ширхэг чацарганы суулгацыг 5 жилийн хугацаатай зээлээр олгож тариалалтыг 217.2 га талбайгаар нэмэгдүүллээ.

Мөн жилд 2.7 сая ширхэг жимсний суулгац үржүүлэх боломжийг бүрдүүлж, 626 ногоон ажлын байр шинээр бий болгон, 2014 онд жимс жимсгэний тариалалтыг

нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд хуурай уур амьсгалтай орнуудад жимст мод тариалахад зориулсан жимсний мод тариалах мөр гаргагч, мөр хоорондын хог ургамал устгаг хадуур, ургамал хамгааллын бодис цацах төхөөрөмжийг өндөр хүчин чадлын тракторын хамт нийлүүлж богино хугацаанд их хэмжээний талбайд жимс жимсгэнэ тариалах нөхцлийг бүрдүүлэв. ҮХАА-н яамны ТНБД-ын 2014.05.02-ны А/154 тоот тушаалаар “Чацарганы суулгац зээлээр олгох” төсөл сонгон шалгаруулалтад шалгарсан 82 иргэн байгууллагад 404.5 сая төгрөгийн үнэ бүхий 188575 ширхэг чацарганы суулгацыг зээлээр олгоод байна. Мөн 28 аж ахуйн нэгжид 1.05 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлж, жимст цэцэрлэгийн талбайг 100 га-гаар нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв.

ЖИМС, ЖИМСГЭНИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

Жимсний төрөл	2012 он		2013 он		2014 он	
	талбай /мян.га/	ургац /тн/	талбай /мян.га/	ургац /тн/	талбай /мян.га/	ургац /тн/
Чацаргана	4.5	1043	4.4	1151	5.1	1486.5
Бусад жимс /гүзээлзгэнэ, үхэр нүд, алим, чавга/			0.45	271	0.53	190.9

ХХААХҮ-н сайд болон БОАЖ-ын сайдын 2012 оны А/104, А/252 дугаар хамтарсан тушаалаар “Загас” дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.

НҮБ-ын ХХААБ, МУ-ын Засгийн газраас хамтран “Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг монголд хөгжүүлэх” төслийн хүрээнд гадаадын 3 зөвлөх, үндэсний 2 зөвлөхийг сонгон авч ажиллаж байна. Төслийн зөвлөхүүд УБ хотын Туул голын сав дагуу загас үржүүлгийн “Хилэм ост”, “Жижиг горхи” аж ахуйн нэгжид цөөрмийн барилгын зураг төслийг гарган өгч, жарамхай нийлүүлэх судалгаа хийсэн бөгөөд 2015 онд жарамхай авах ажлыг зохион байгуулна.

- “Жижиг горхи” аж ахуйн нэгж нь 200.0 сая төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтаар хаалттай цөөрөм, үйлдвэрийн барилга байгууламжийг барьж дуусгасан. Тоног төхөөрөмж худалдан авах, угсарч суурилуулах бэлтгэлийг хангаж, тооцоо судалгаа хийх, санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна.
- “Хилэм ост” ХХК нь Чингис бондын төслөөс 200.0 сая төгрөгийн зээл болон өөрийн 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хаалттай цөөрөм, үйлдвэрийн барилга байгууламжийг барьж дуусгаад байна. Тоног төхөөрөмж худалдан авах, угсарч суурилуулах ажлыг хийхээр төлөвлөж байна.

2012 онд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад шувууны аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн тоо нийт 98-д хүрч нийт өндөглөгчийн тоо 260,705-д хүрсэн. Үүний зэрэгцээ аж ахуйн нэгж, иргэдэд 74200 толгой хоногийн настай дэгдээхэйг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 200,0 сая төгрөгийн зээлийг 1 жилийн хугацаатай олгосон.

2013 онд шувууны аж ахуй эрхлэгчдийг дэмжих зорилгоор төсөл сонгон шалгаруулж, Улаанбаатар хот, Дархан-Уул аймгийн 11 аж ахуйд нийт 160.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэв. 2013 оны жилийн эцсийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулан үзэхэд аж ахуйн тоо 2 дахин нэмэгдэж, өндөглөгч тахиа 9.4 хувиар буурсан байна.

	2012 он		2013 он		2014 УГ	
	Аж ахуйн тоо	Тахиан тоо	Аж ахуйн тоо	Тахиан тоо	Аж ахуйн тоо	Тахиан тоо
Дүн	152	594436	319	544234	405	

Тахиан тоо толгой 2013 онд өмнөх жилийнхээс буурсан нь дэмжлэгээр олгосон зээлийг сүрэг сэлбэж, өндөглөх чадварыг нь нэмэгдүүлэхийн тулд үзлэг ангилалт хийж, хэрэгцээлсэнтэй холбоотой байна. Тахиан аж ахуй эрхлэгчийн тоо нэмэгдэж байгаа хэдий ч дотоодын эрэлт хэрэгцээг бүрэн хангах боломж бүрдээгүй байна. 2013 оны урьдчилсан дүнгээр 34332.0 мянган ширхэг өндөгийг гадаадын зах зээлээс импортоор худалдан авч хүнсний хэрэгцээг хангасан байна.

“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд 2014 онд шувууны аж ахуй эрхэлдэг 3 аж ахуйн нэгжид 8.6 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэгийг үзүүлээд байна. Эрчимжсэн тахианы аж ахуйн эрхэлж буй аж ахуйн нэгжийн 2014 оны судалгааг өмнөх онтой харьцуулан үзэхэд баруун бус болон нийслэлд тахианы тоо 557-8257 толгойгоор тус тус буурч, хангайн, төвийн, зүүн бүсийн тахиан тоо 1869-211979 толгойгоор тус тус нэмэгдсэн байна.

Гаалийн ерөнхий газрын импортын 2014 оны урьдчилсан дүнг өмнөх онтой харьцуулахад 87.3 сая ширхэг өндөг оруулж, өмнөх оноос өндөгний импорт 15.7 сая ширхэгээр буурч, дотоодын өндөг үйлдвэрлэл нэмэгдсэн гэж үзэж байна.

ХШҮ- 90%

Үйл ажиллагаа 4.4. Тариалангийн техник шинэчлэл, усалгаатай тариалан, бордоо, ургамал хамгаалал, механикжсан зоорь, үр тарианы агуулах, зуны болон өвлийн хүлэмж, үрийн шинэчлэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх болон урамшуулал олгох.

Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдэж байгаа техник, тоног төхөөрөмжийг иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлттэй үнээр олгож байсан хугацааг 7 жил болгож сунгах саналыг боловсруулж, шийдвэрлүүлэв. Төсвийн хөрөнгө оруулалтаар төмсний зориулалттай өндөр хүчин чадлын тракторын 9 иж бүрдэл, 2 мөрийн төмс ухагч 41 ширхэг, мөр хоорондын сийрүүлэгч 34 ширхэгийг нийлүүлж хөнгөлттэй нөхцлөөр олгох ажлыг зохион байгууллаа.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр үр тарианы комбайн 48, 125-165 М/Х-тэй трактор 92, эрдэнэшишийн комбайн 10, эрдэнэшишийн үрлүүр 10 худалдан авахаар үйлдвэрлэгчтэй гэрээ байгуулсан. Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын ЭКЗИМ банкттай “Газар тариалангийн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх” төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээрийг байгуулах бэлтгэл ажил хангагдсан.

Герман-Монголын хамтын ажиллагааны хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх зорилгоор “Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд тосны ургамал тариалах дэвшилтэт техник, технологи үйлдвэрлэлд нэвтэрч байна. Үр тариа, тэжээл үйлдвэрлэлд цомхотгосон технологид суурилсан Германы Клаас брендийн зүтгэх хүчний трактор, Лемкен үйлдвэрийн хөрс боловсруулах техникийг, төмсний үйлдвэрлэлд Германы Гримме үйлдвэрийн үрлүүр, сийрүүлүүр, комбайныг ашиглахаар Төв аймгийн Угтаалцайдам сумын “Агрокомплекс” ХХК, Сэлэнгэ аймгийн “Элит үр” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Тэжээл, тос, техникийн таримлын тариалалтын техник тоног төхөөрөмжийн хангамж 2013 оны байдлаар 35 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 5 хувиар өссөн дүнтэй байна. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний техник тоног төхөөрөмжийн механикжилтын түвшин 2013 оны байдлаар 30 хувьтай байна.

2012 онд Итали улсын “Cifarelli” компаниас жимсийг доргиож хураах SC-800, соруулж хураах V77S төхөөрөмжийг тус компанийн мэргэжилтнүүд Төв аймгийн Батсүмбэр, Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд ашиглаж туршсан.

2013 онд улсын төсвийн 50.0 сая төгрөгөөр чацаргана хураах тоног төхөөрөмжийн судалгаа, туршилтийн инновацийн төсөл хэрэгжүүлж, олон улсын чацаргана хураах тоног төхөөрөмжүүдтэй харьцуулсан судалгаа хийсэн. Монголын эрдэмтэд гар аргаар чацаргана хураах жижиг оврын доргиогч төхөөрөмжийн загварыг гарган Төв аймгийн Батсүмбэр сумын “Поливет” ХХК-д туршин, өөрийн орны нөхцөлд ашиглах боломжтойг тогтоосон.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 25 морины хүчтэй бага оврын 5250 трактор худалдан авч, иргэн, аж ахуйн нэгжид 50 хувийн урьдчилгаа төлбөртэй 5 жилийн хугацаатай зээлээр олгох ажлыг хэрэгжүүлэн, 2012 онд 540, 2013 онд 356 тракторыг гэрээ байгуулж олгосон.

Өрхийн тариаланг механикжуулах зорилгоор төмс, хүнсний ногооны иж бүрдэл 528 техник (мотоблок) худалдан авсан ба иргэн, аж ахуйн нэгжид 156 техникийг хөнгөлөлттэй нөхцөлөөр гэрээ байгуулж нийлүүлсэн.

2013 онд улсын төсвийн 1,331.0 сая төгрөгийн хөрөнгөөр бага оврын тракторт тохирох ногооны сийрүүлүүр, үрлүүр, хураагчийн 110 иж бүрдэл, төмсний 38 үрлүүр, 38 хураагч, үрсэлгээ суулгагч 33 машин зэрэг техник хэрэгслийг худалдан авч ҮХАА-н сайдын 2013 оны “Техник, тоног төхөөрөмжийн худалдах үнэ, нөхцлийг батлах тухай” А/106 дугаар тушаалаар иргэн аж ахуйн нэгжид 20 хувийн урьдчилгаатай 4 жилийн хугацаатай лизингээр олгоод байна.

Хүнсний ногооны тариалан эрхэлдэг иргэд, ногоочдын бүлэг, хоршоодыг усалгааны тоног төхөөрөмжөөр тоноглоход зориулж 3 хүртэл га талбайг услах хүчин чадал бүхий 280 ширхэг зөөврийн усалгааны систем, усан сангийн иж бүрдлийг ҮХАА-н Сайдын 2013 оны А/149 дугаар тушаалаар 20 хувийн урьдчилгаатай 4 жилийн хугацаатай зээлээр олгохоор шийдвэрлэсэн.

2013 онд хүнсний ногооны үйлдвэрлэлийн техник хангамж 40 хувьтай болж, 600 га талбайн тариалалт, хураалтыг механикжуулан 840 га талбайн усан хангамжийг сайжруулах боломж бүрдлээ.

АҮЯ-ны ЖДҮХС-аас зоорь байгуулах төсөлд 8050.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба орон нутагт төмс, хүнсний ногооны зоорины шинээр барих төслийн тендер зарлан дэмжлэг үзүүлсэн байна. Тухайлбал: Дархан-Уул аймгийн “Хос шарга” ХХК 250 тонны зоорь байгуулахад 44.1 сая төгрөг, “Орхон Сэлэнгэ ургац” ХХК 500 тонны зоорь байгуулахад 56,2 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг үзүүлснээр 750 тонны багтаамжтай зоорийг ашиглалтанд шинээр оруулсан байна. Өвөрхангайн Хархорин суманд 300 тн-ын багтаамжтай үрийн агуулах барьж хүлээлгэн өгсөн.

Сайхан суманд хоногт 120 тн үр тариа боловсруулах, Завхан аймгийн Асгат суманд 20,0 тн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай гурилын үйлдвэрийг байгуулж ашиглалтанд оруулсан байна.

Бүрэнтолгойн 5 га-ийн услалтын систем шинээр байгуулахад улсын төсвөөс 45.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлсэн ба ҮХААЯ-наас Мандал, Ерөө, Жавхлант, Зүүнбүрэн, Цагааннуур сумдын ногоочид 24 тракторыг иж бүрдлийн хамт 3 жилийн хугацаатай гэрээ хийж олголоо.

- Говьсүмбэр аймагт “Шивээгийн булгийн 18 га услалтын систем”-ийн 1-р шатны ажил дуусч 5.4 га талбайг сувгаар услах боломжтой болсон.
- Хүлэмжийн аж ахуй эрхлэх сониорхолтой 4 иргэнд 5,3 сая төгрөгийн өртөг бүхий 2 хүлэмж, 3 бичил услалтын систем буцалтгүйгээр олгосон.

“Гол нэрийн хүнсний үнийг тогтворжуулах”, “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд мах, ногооны зоорь агуулах, махны төрөлжсөн худалдааны төв байгуулах чиглэлээр 2013 онд төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулж, шалгарсан 33 аж ахуйн нэгж байгууллагаас 27 аж ахуйн нэгжид нийт 78320 тэрбум (55.000тн агуулах) төгрөгийн зээл олгосон. Тухайлбал:

- Дагнасан зоорь, хөргөлттэй агуулах: 22 ААНэгж – 36.320 тэрбум төг (27200тн агуулах) зээл авсан.
- Дунд хэмжээний зоорь, хөргөлттэй агуулах, худалдааны төв: 8 ААНэгж – 17,500 тэрбум төг (20,800тн агуулах) зээл авсан.
- Хадгалалт борлуулалтын иж бүрэн цогцолбор: 3 ААНэгж – 24.500, тэрбум төг (16.000тн агуулах) зээл авсан ба төсөлд оролцсон 33 аж ахуйн нэгжүүдээс 23,160 тэрбум төгрөгийн төсөл 100% дууссан нь нийт санхүүжилтын үнийн дүнгийн 30%-г эзэлж байна. Үлдсэн 55.160 тэрбум төгрөгийн төслийн ажил нь 20%-90%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Одоогоор Траст трейд” ХХК, “Хүнсний технологийн коллеж”, “Тэнгэр плаза” худалдаа үйлчилгээний төв, “Эи Эн Ди Эм” ХХК, “Хүнс комплекс” ХХК, “Монтува” ХХК, “Саян-Уул” ХХК зэрэг 7 аж ахуйн нэгжийн 12 мян.тн хөргөлттэй агуулах ашиглалтад ороод байна.

ХШҮ- 90%

Үйл ажиллагаа 4.5. *“Таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх” төсөл хэрэгжүүлж шар будаа, тосны ургамал, хөх тариа, вандуй, шар буурцгийн болон мөөг, бусад түгээмэл биш хүнс, тэжээлийн ашигт таримлын тариалан эрхлэгчид, боловсруулах үйлдвэрт хөрөнгө оруулалт, зээлийн дэмжлэг үзүүлж, эдгээр таримлын импортыг бууруулах асуудлыг судалж, санал боловсруулах.*

Таримал ургамлын үр үржүүлэг, таримлын сэлгээ, шинэ сортуудыг сорих, нутагшуулах, сорт сорилтын төвүүдийн үйл ажиллагааг сэргээх ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний ТББ боловсруулж зарлаад байна.

2012 онд 316.9 мянган га талбайд уринш бэлтгэснээс 148.4 мянган га талбайд химийн уринш хийсэн. 2013 онд 311.1 мянган га-д чанар сайтай уринш боловсруулж бэлтгэснээс 135 мянган га талбайд цомхотгосон уринш хийсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 12.6 мянган га талбай буюу 8.5%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Төмсний элит үр үржүүлэх лицензтэй аж ахуйн нэгжүүд 110 тн үрийн төмс нийлүүлсэн. Ургамал хамгааллын бодис импортлох, борлуулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Улаанбаатар хотын “Гэрэлт Асар” ХХК, Сэлэнгэ аймгийн “Нью Элит” ХХК- тус тус олгов. “Хишиг гурил” үйлдвэрт хөх тарианы гурил үйлдвэрлэж эхэлсэн.

“Мөөг сармисны зах зээлийн судалгаа” зөвлөх үйлчилгээний ажлыг 2014 оны 10 сард хүлээн авсан.

“Эрдэнэт гурил” ХХК нь 2014 онд нийт 10800 тн багтаамжтай үр тариа хадгалах агуулахтай, хоногт 150 тонн улаанбуудай, Монгол Улсад анх удаа 30 тонн хөх тариа боловсруулах хүчин чадал бүхий сүүлийн үеийн бүрэн автоматжуулсан тоног төхөөрөмж, технологиор тоноглогдсон гурлын үйлдвэр ашиглалтад оруулж, БГ-055, БГ-085, БГ-115 ангиллын гурил, хөх тарианы гурил үйлдвэрлэж, тэжээлийн үр тариа, хүнсний болон тэжээлийн хивэг зах зээлд нийлүүлж байна.

ХШҮ- 50%

Үйл ажиллагаа 4.6. Баруун болон зүүн бүсэд эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг сэргээн хөгжүүлэх, түүний дотор Халх голын бүс нутагт тариалангийн зориулалтаар ашиглаж болох атаршсан болон атар газрыг эргэлтэд оруулах зорилго бүхий "Халх гол" төслийг хэрэгжүүлэх.

Баруун бүсэд 2013 оны байдлаар эрчимжсэн аж ахуйн 60 гаруй хувь нь үйл ажиллагаа явуулж байна /Хөдөө аж ахуй 2013/. Баруун болон зүүн бүсийн тариаланг хагжүүлэх асуудлыг цогц байдлаар боловсруулж "Газар тариалангийн тогтвортой хөгжил" хөтөлбөрийн төсөлд тусгав.

Зүүн бүсэд буюу Халхгол суман дах атаршсан 40 мянган га талбай бүрэн эргэлтэнд орсон ба нийт 10 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. "Халх гол" төслийг 2011-2014 онд хэрэгжүүлж Халхголын бүс нутагт 200 га талбайд мал аж ахуй газар тариалан хосолсон загвар аж ахуй байгуулсан.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 4.7. Газар тариалангийн үйлдвэрлэлд байгаль орчинд халгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэх, тариалангийн талбайг хашиж хамгаалах, ойн зурвас байгуулах, хөрсний үржил шимийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

2012 онд 316.9 мянган га талбайд уринш бэлтгэснээс 148.4 мянган га талбайд химийн уринш хийсэн. 2013 онд 311.1 мянган га-д чанар сайтай уринш боловсруулж бэлтгэснээс 135 мянган га талбайд цомхотгосон уринш хийсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 13.4 мянган га талбайгаар буурсан үзүүлэлттэй байна. Аж ахуйн нэгж, иргэд 2014 онд 337.1 мянган га-д чанар сайтай уринш боловсруулж бэлтгэсний 133.7 мянган га талбайг нь дэвшилтэт технологиор боловсруулсан нь өмнөх оныхтой харьцуулахад 1.3 мянган га талбайгаар буурсан үзүүлэлттэй байна.

Ургацын чанарыг сайжруулах, өвчин хортонтой тэмцэх ажлын хүрээнд 702 аж ахуйн нэгжид 358.4 мянган литр ургамал хамгааллын бодис, 640 тонн эрдэс бордоог 30 хувийн урьдчилгаа нөхцөлтэйгээр зээлээр олгов. Эрдэс бордооны үйлдвэр байгуулах 2 төслийн саналыг дэмжиж, Чингис бондын эх үүсвэрээс санхүүжүүлэхээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.

Жилд 2.0 сая ширхэг жимсний суулгац үржүүлэх боломжийг бүрдүүлснээр 625 ногоон ажлын байр шинээр бий болгон 209.7 га талбайг элсний нүүдлээс хамгаалан, уул уурхайн нөхөн сэргээлт хийсэн байна.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 4.8. Таримал ургамлын шинэ сортыг бий болгох, нутагшуулах, сорт сорилт, судалгааны ажлыг эрчимжүүлж, үрийн чанар, хангамжийг сайжруулах, хүнсний гол нэрийн таримлын үр үржүүлэг, үйлдвэрлэл, нийлүүлэлтийг боловсронгуй болгох.

Үрийн чанар, хангамжийг сайжруулах зорилгоор "Тэрээ байгуулах эрх олгох тухай" ТНБД-ын 2014 оны А/69 тоот тушаалаар Дарханы УГТЭШХ-гээс улаанбуудайн Дархан 144 сортын элит үр 60 тонн, Дархан 34 сортын элит үр 5 тонн, нийт 65 тонн элит үрийг хүлээн авч, Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ тариа", Төв аймгийн "Алтан залаа", "Жаргалант харвес" ХХК-дад үржүүлэхээр гэрээ байгуулан олгож, 510 га-д тариалан, ургац хураалтын дүнгээр нийт 958 тонн буюу нэгжээс 18.7 цн ургац хураан авч, ТЭДС-д 157 тонн, Улсын нөөцөд 211 тонн, аж ахуйн нэгжүүдэд үрийн зориулалтаар 660 тонныг тус тус нийлүүлсэн байна.

2014 оны байдлаар хүнсний ногооны үр үйлдвэрлэгч 44 иргэн, 3 байгууллага таримал ургамлын үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж, төмс болон голлох хүнсний ногооны таримлын үрээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж байна.

Улсын 2013 оны төсөвт таримал ургамлын үрийн чанар хангамжийг сайжруулах, сорт сорилтын төвүүдийн үйл ажиллагааг сэргээх ажилд 300 сая төгрөг батлагдсан. Таримал ургамлын үр үржүүлэг, таримлын сэлгээ, шинэ сортуудыг сорих нутагшуулах сорт сорилтын төвүүдийн үйл ажиллагааг сэргээх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах Зөвлөх үйлчилгээний ажлыг 2013 оны төсвийн 198.0 сая төгрөгөөр, “Алслагдсан бүсэд газар тариаланг сэргээн хөгжүүлэх ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээ”-ний ажлыг 98.9 сая төгрөгөөр “Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо”-оор тус тус гүйцэтгүүлэн 11 дүгээр сард хүлээн авав. Уг ТЭЗҮ-д сорт сорилтын салбаруудын бүтэц, үйл ажиллагаа, дэмжлэг үзүүлэх чиглэлийг тусгасан. Сэлэнгэ аймгийн Найрамдал, Сайхан, Хөвсгөл аймгийн Тариалан, Төв аймгийн Борнуур сумын сорт сорилтын салбарын үйл ажиллагааг сэргээж, Төв аймгийн Жаргалант суманд шинээр нэгийг байгуулахаар төлөвлөөд байна.

“Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөх байгуулах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд бүтцийн өөрчлөлт хийх этгээдүүдийн жагсаалтад Дархан-Уул, Төв, Хөвсгөл, Сэлэнгэ аймгууд дахь Сорт, сорилтын төвүүд болон лабораторийг өөрчлөн зохион байгуулж, ХААҮШҮОНТ-д нэгтгэхээр тусгаж, Засгийн газрын 2014.06.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, хувьчлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтож, бүтцийн өөрчлөлт хийх этгээдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн.

2014 онд Үр үржүүлэг, сорт сорилтын төв байгуулах талаар “Газар тариалангийн тогтвортой хөтөлбөр”-ийн төсөлд тусгасан.

Монгол төмс хөтөлбөрийн хүрээнд 2012 онд “Импала”, “Гала”, “Солист” сортуудын 131.4 мянган бичил булцуу, 2013 онд 125.0 мянган бичил булцуу тус тус үйлдвэрлэв. 2014 онд Аэропоник орчинд ургуулсан 125.0 мянган ширхэг булцуугаар тариалалт хийсэн. 2015 оны тариалалтад шаардлагатай 250 мянган ширхэг булцуу үйлдвэрлэхээр төлөвлөсөн ч улсын төсвөөс төсөв батлагдаагүй учир Монгол төмс хөтөлбөрийн хүчин чадлын хүрээнд 150.0 мянган ширхэг булцуу үйлдвэрлэж 2015 оны тариалалтад бэлтгэв.

Төмсний үр шинэчлэлийн хүрээнд 2013 онд аймгуудын ХХААЖДҮГ-аар дамжуулан 130 тн элит үрийг олгож, 2014 оны тариалалтад 520 тн элит үрээр тариалалт хийх нөхцөлийг бүрдүүлэв. Баянхонгор, Увс, Завхан, Сэлэнгэ, Дархан-уул, Дорнод, Хэнтий аймуудын ногооны үр үйлдвэрлэгчдэд төрөөс дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж 106.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Хүнсний ногооны тариалан эрхлэгчдэд 200 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэв. Төслийн дэмжлэгийн үр дүнд байцаа, сонгино, сармисны тариалалт 2012 оныхоос 1.2 хувиар өслөө. Элит үрийн хангамжийн хэмжээ 60 хувьд хүрээд байна.

ХШҮ- 90%

Үйл ажиллагаа 4.9. *Нэг болон олон наст тэжээлийн ургамал, техникийн таримлыг тариалангийн талбайн сэлгээнд тариалах замаар таримал тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хослон эрхлэх, хөдөлмөрөө хоришн ажиллахыг дэмжих.*

Үр тарианы ургамлын сэлгээнд тэжээлийн өндөр ач холбогдолтой уурагт ургамал тариалах замаар малын тэжээлийн ургамал тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлж байна.

Улаанбаатар хотын орчимд 30 гаруй эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгж /”Мон триамал” ХХК, “Нүүдэлчин” ХХК зэрэг/, иргэн газар тариалан хослон эрхэлж байна.

	2012 он	2013 он	2014УГ
Тэжээлийн ургамал тариалсан талбай, га	13783.6	14390.4	16975.6
Бэлтгэсэн гар тэжээл, тэжээлийн нэгжээр	39069.0	36602.3	40260.3

Эх сурвалж:ҮСХ, Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал 2014/12

ХШҮ-90%

Зорилт-5. Хот, хөдөөгийн болон улирлаас хамаарах хүнсний хүртээмжийн ялгааг багасгах хүрээнд:

Үйл ажиллагаа 5.1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагаанд дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэгчээс хэрэглэгч хүрэх дамжлагад хүнсний тэжээллэг чанарыг алдагдуулахгүй байх нөхцөл бүрдүүлэх.

Хүнсний бүтээгдэхүүний зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар, зөвлөмжийг батлуулж хэрэгжүүлснээр анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн, хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн, хүнс боловсруулах үйлдвэрлэлд үйлдвэрийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх, нөхцлийг бүрдүүллээ. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч өөрт хамаарах хүнсний сүлжээний үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох, бүртгэл хөтлөх, хүнсний хяналтын байгууллагаас энэхүү бүртгэлд үндэслэн, ул мөрийг мөшгин, хүнсний сүлжээний эрсдэл гарсан үе шатыг тогтоох, малчны хот, тариан талбайгаас хэрэглэгчийн ширээ хүртэлх хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”, аргачлалыг батлуулж, нэвтрүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 257 тоот тушаалаар батлагдсан “Хүн амын хоол тэжээлийн физиологийн норм”-ыг баримтлан хүнсний хэрэгцээ, хангамжийг гол нэр, төрлийн бүтээгдэхүүнээр тооцсон дүнгээс харвал хүн амыг хүнсний хэрэгцээг 5 нэр, төрлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангаж, хүнсний ногооны хангамж дунджаар 78.5%, өндөг болон жимсний хангамж жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

ХҮН АМЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН ХҮНСНИЙ ХЭРЭГЦЭЭ, ХАНГАМЖ

Гол нэр төрөл	Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ, мян.тн					Хүнсний хангамж, %				
	2009	2010	2011	2012	2013	2009	2010	2011	2012	2013
А										
Мах, махан бүтээгдэхүүн	172.8	176.2	172.7	179.1	182.6	155.7	116.0	121.7	127.1	141.9
Сүү	172.8	176.2	172.7	179.1	182.6	287.7	208.2	268.6	285.8	315.1
Гурил	98.7	100.7	98.7	102.3	104.3	213.8	207.9	175.3	161.3	201.4
Төрөл бүрийн будаа	77	78.5	77	79.87	81.44	27.8	35.3	20.1	39.6	25.0
Саахар, чихрийн зүйл	22.7	23.2	22.7	23.54	24	163.0	196.1	347.1	242.6	207.5
Төмс	138.2	140.9	138.1	143.2	146	126.2	125.2	150.2	173.9	129.6
Хүнсний ногоо	197.5	201.4	197.3	204.6	208.6	65.3	69.5	90.7	88.0	79.2
Жимс	177.7	181.2	177.6	184.1	187.7	10.0	9.3	9.0	11.3	14.0
Өндөг	18.8	19.1	18.7	19.34	19.72	18.1	24.6	25.7	25.3	26.9

Эх сурвалж:Хоол судлалын үндэсний төв, ҮСХ

“Үнэ тогтворжуулах” дэд хөтөлбөрийн “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх” хөтөлбөрийн хүрээнд “Улаанбаатар хот орчимд хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн зоорь, агуулах, махны дагнасан болон төрөлжсөн бөөний, жижиглэн худалдааны төв шинээр байгуулах, өргөжүүлэх” төсөл хэрэгжүүлэх 23 аж ахуйн нэгжид харилцагч арилжааны банкуудаас нийт 74.9 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Төсөл

хэрэгжсэнээр мах, махан бүтээгдэхүүний зоорь агуулах 19.5 мян тн-оор, төмс, хүнсний ногооны зоорь 66.5 мян тн-оор, худалдааны төвийн агуулахын багтаамж 6.0 мян тн-оор тус тус нэмэгдэх боломжтой. Эдгээр зоорь нь механикжсан, автомат болон хагас автомат удирдлагатай болно.

БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох экспортын зээлийн хөрөнгөөр санхүүжих "Сүүний хөргөлтийн төвийн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх", "Үр тариа хадгалах элеватор байгуулах" төслийн хүрээнд хөнгөлөлттэй зээлийн 20.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар тариалангийн бүс нутгуудад үр тариа хадгалах зориулалттай 91.0 мянган тоннын нийлбэр багтаамжтай элеватор барьж байгуулах бол сүүний хөргөлтийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр нийслэлчүүдийг шингэн сүүгээр тасралтгүй хангах нөхцөл бүрдэх юм.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 5.2. *Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд борлуулах худалдааны нэгдсэн сүлжээ бий болгоход болон сүү цуглуулах, хөргөх төв байгуулах, технологи эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх.*

“Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн тухай” хууль УИХ-ын чуулганы 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар батлагдсан. Энэ хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд гарсан УИХ-ын “Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоол, Засгийн газрын “Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн бирж байгуулах, бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 235 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2013 оны 30 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хуулийн этгээд байгуулагдаж, Улаанбаатар хотын 14 компани, 16 аймгийн төв, зүүн 3 аймгийн 49 сум биржийн сүлжээнд холбогдон үйл ажиллагаа явуулж байна. ХАА-н бирж” ХХК нь хуулиар олгогдсон чиг үүргийнхээ хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий 29 брокерт гишүүнчлэл олгож, 30 агуулах, 2 тээврийн компанид түр итгэмжлэл олгон арилжаанд оролцуулсан бөгөөд улсын итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажиллаж байна. Баруун, төв, зүүн бүсийг хамарсан нийт 16 аймагт түүхий эд бүтээгдэхүүний агуулахыг сэргээн засварласан. 2013 оны байдлаар арьс шир, ноос, ноолуур тордох, хадгалах зориулалтаар ашиглаж болох 385504 м² талбай бүхий агуулах байна. ХАА-н бирж дээр 2014 оны байдлаар тосны ургамал 2 төрөл, мал 1 төрлөөр тус тус арилжигдаж байна.

Түүхий эд бэлтгэлийн логистик тогтолцооны ерөнхий зохион байгуулалтын төлөвлөгөө, хадгалах агуулахын хүчин чадлын тооцоолол, жишиг агуулах барих танилцуулга, дотоод зохион байгуулалтын ерөнхий төлөвлөлт, агуулахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргав. Аймгийн төв, сумдад байгуулах ХАА-н биржийн итгэмжлэгдсэн агуулах, лабораторийн зураг, төсөл боловсруулах даалгавар, мал, мах бэлтгэлийн ерөнхий судалгааг тус тус боловсруулсан.

БНХАУ-ын Засгийн газрын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хоногт 5.0 тн сүү хөргөх, хадгалах зориулалттай 50 хөргөлтийн төв байгуулах гэрээ байгуулахаар ажиллаж байна.

ХШҮ- 70%

Үйл ажиллагаа 5.3. *Нийгмийн эмзэг бүлгийн хоол, тэжээлийн чанарыг сайжруулах чиглэлээр хандивлагчдын дэмжлэгт тулгуурлан төсөл хэрэгжүүлж эхэлнэ.*

2012 онд “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр”-ийг Дархан-Уул, Дундговь, Өвөрхангай аймгуудад хэрэгжүүлж, Дархан-Уул аймгийн эзэг бүлэгт

хамраарах иргэдэд сар тутамд 1 хүнд 14 мянган төгрөгийн үнэ бүхий талон, Дундговь аймагт 703 өрхийн 3698 иргэн хамрагдаж, Өвөрхангай аймагт Азийн хөгжлийн банк, Япон улсын хүнсний төслөөр 141 өрхийн 636 хүн амд 9180.0 төгрөг, хөдөлмөр эрхэлдэггүй 23 иргэнийг 27 хоног түр ажлын байранд ажиллуулж 3105000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 31 өрхийн 16 наснаас дээш гишүүдэд 10000 төгрөг, 16 хүртэлх насны хүүхдэд 5000 төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүн болон талон тус тус олгосон байна.

Орлого багатай өрхийн хүн амын хоол, тэжээлийн дутлыг бууруулах, нийгмийн халамжийн тогтолцоог сайжруулах зорилтын хүрээнд “Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн дагуу НХХЯ-ны дэргэд “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр” төслийг хэрэгжүүлэх нэгж байгуулагдан, 2011 онд эхний шатны судалгаанд хамрагдсан Дундговь, Дорнод, Хөвсгөл, Ховд аймаг, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргээс сонгогдсон нийт 4271 өрхийн 26257 иргэнд хүнсний талоныг 5 удаа төлөвлөсөн хугацаанд хүргүүлсэн ба 89343 өрх, 323576 иргэнийг хамарсан мэдээллийн сан бүрдүүлсэн байна.

НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлсэн “Хүн амын хүнсний баталгаат байдлыг сайжруулах” төслийн хүрээнд Дундговь аймгийн Адаацаг, Эрдэнэдалай суманд тус бүр бага орлогтой 40 өрх ногоо тариалах болж дадлагатай болж, өөрсдийн тариалсан төмс хүнсний ногоог нөөцлөн хүнсэндээ хэрэглэж байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн А/18 тоот тушаалаар батлагдсан “Улсын хэмжээнд тооцсон амьжиргааны түвшний 5 хувийн шугамаас доогуурт багтсан хүн амын хамгийн бага хэрэглээтэй хэсэг болох нийт 16535 өрхийн 97918 иргэнд хүнсний эрхийн бичиг олголт хийгдэж байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд сард дунджаар 720 орчим сая төгрөгийг зарцуулдаг бөгөөд 2013 оны 10 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 16535 өрхөд 7,3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Нийгмийн эмзэг бүлгийн хоол, тэжээлийн чанарыг сайжруулах, энэ чиглэлийн төслийн тогтворжилтийг хангах талаар Монгол Улсын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлсэн олон талт арга хэмжээ нь дор дурдсан эерэг үр дүн гарсан. Үүнд:

- Нийгмийн халамжийн тухай хуульд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нийгмийн халамжийн салбарын нэг шинэ үйлчилгээ болгон тусгасан нь ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд зориулан хоол, хүнсээр өдөрт 2500 ккалори илчлэгийг хэвийн хэмжээнд авах боломжийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг нийгмийн эмзэг хэсэгт хязгаарлахад чиглэсэн томоохон арга хэмжээ болсон;
- Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан хүмүүсийн 51 хувь буюу 50712 нь 0-18 хүртэлх насны хүүхдүүд, үүнээс 19526 нь 0-5 насны хүүхдүүд эзлэж байна. Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд 0-5 настай хүүхдийн хоол тэжээлийн дутал болон тураалтай хүүхдийн тоог бууруулахад чухал дэмжлэг болж байна.
- Улсын хэмжээнд тооцсон амьжиргааны түвшний 5 хувийн шугамаас доогуурт багтсан өрхийн гишүүн ахмад настны талаар төр, засгаас баримтлах бодлогын хэрэгжилтэд үр дүн гарч байна.
- Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг “Хадгаламж” банкны орон нутаг дахь нийт 30 салбар, хүнсний бүтээгдэхүүний худалдан авалт хийхэд зориулсан 668 хүнсний

дэлгүүр, цаасан талон хэвлэх хэвлэлийн компани, орон нутгийн шуудангийн үйлчилгээний 30 салбар зэрэг байгууллага нэгжүүдийн оролцоотойгоор зохион байгуулснаар төр, хувийн хэвшлийн түншлэлийг салбарын бодлого, хэрэгжилтээр дамжуулан хөхүүлэн дэмжих боломж бүрдэж байна.

2013 оны 8 дугаар сараас салбар дундын мэдээллийн системийг ашиглалтад оруулж офлайн програмыг онлайн хэлбэрт шилжүүлснээр шилжилт хөдөлгөөн болон бусад шалтгаанаар үүссэн үйлчилгээний давхардлыг бүрэн арилгаж, цаасан эрхийн бичгийн хуваарилалтыг нэгдсэн журмаар програмаас хийдэг болсноор үйлчилгээ илүү хялбаршуулсан.

“Хүнсний эрхийн бичиг олгох журам”, “Хүнсний цаасан эрхийн бичгийн загвар”, “Хүнсний эрхийн бичгээр олгох бүтээгдэхүүний жагсаалт”, “Өрхийн гишүүн-иргэнд хүнсний эрхийн бичиг олгосон тайлангийн маягт”, “Худалдан авсан бүтээгдэхүүний төлбөрт зарцуулсан хөрөнгийн нэгдсэн тайлангийн маягт”-ыг тус тус боловсруулан ХАХНХ-ын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2014 оны А/32 дугаар тушаалаар батлуулан улсын нэгдсэн бүртгэлийн 3445 дугаарт бүртгүүлсэн ба нийт 15131 өрхийн 87718 иргэнд 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус тооцож, хүнсний эрхийн бичиг олгох арга хэмжээг зохион байгуулж эхэлсэн.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг орлогыг орлуулан тооцох аргачлалаар хийж, судалгааны үр дүнгээр хамгийн эмзэг бүлгийн иргэнд сар бүр том хүнд 10.0 мянган төгрөг, хүүхдэд 5.0 мянган төгрөг буюу 2014 онд 10.0 тэрбум төгрөгийг төсөвлөн санхүүжүүлсэн. 2015 оны төсвийн тодотголд 18.0 тэрбум төгрөг болгож, нийгмийн халамжийн эмзэг бүлэгт чиглэсэн дээрх зардлыг нэмэгдүүлээд байна.

Томоохон хот, аймгийн төвүүдэд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур, ядуу иргэдэд халуун хоолоор үйлчлэх цэг байгуулахад 2014 оны байдлаар түр хоноглуулах болон халуун хоол цайгаар үйлчлэх үйлчилгээг 7 дүүрэг 2 аймагт төрийн байгууллагуудаар дамжуулан нийт 1073.3 сая төгрөг зарцуулан иргэдэд үйлчилгээ үзүүлээд байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 5.4. *Өрхийн мал аж ахуй болон газар тариалан эрхлэх үйл ажиллагаа, орлого нэмэгдүүлэх бусад арга хэмжээнд төв, орон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хандивлагчаас олгож байгаа дэмжлэг тусламжийг нэгдсэн удирдлага, зохицуулалт, тайлан мэдээлэлтэй болгох.*

Европын Холбооны “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төслийн хүрээнд ҮХААЯ-ны дэргэд маркетингийн хороо байгуулан бусад төсөл хөтөлбөртэй хамтран ажилласан. Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй гадаад орон, олон улсын байгууллагын 20 гаруй төслийн танилцуулгыг нэгтгэн эмхтгэл болгон хэвлүүлж, хэрэглэгчдэд түгээсэн.

Гадаад орон, Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийн давхардлыг арилгаж үр өгөөжийг нь дээшлүүлэх зорилгоор хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй төслийн хэрэгжилтийн байдалд судалгаа дүгнэлт хийж, төсөл хөтөлбөрийн менежментийг сайжруулж, үр дүнг дээшлүүлэх арга хэмжээ авч байна.

НҮБ-ын ХХААБ, Европын Холбооны “Хүн амын хүнсний баталгаат байдлыг сайжруулах” төсөл, Европийн Холбоо, Каритас Франц ТТБ-ын “Шинэлэг санаан дээр суурилсан хүнсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр”, “Монгол төмс” төслийн хүрээнд өрхийн газар тариалан эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байна.

ХШҮ-70%

Зорилт 6. Байгалийн гамшиг, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнсний хомсдолын үед хүн ам, ялангуяа эмзэг бүлгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах хүрээнд:

Үйл ажиллагаа 6.1. Стратегийн болон гамшигийн үеийн хүнсний нөөцийг бүрдүүлэх, зарцуулах, нөхөн бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, гамшигийн үед хүн амын хүнсний хэрэглээний хоногийн нормыг тогтоож мөрдүүлэх.

Гамшиг тохиолдсон үед хүн амыг хүнсний зүйлээр хангах зорилготой улсын нөөцийн хүнсний бараа, материалыг батлагдсан төсвийн хүрээнд Засгийн газрын нууцын зэрэглэлтэй 2012 оны 248 дугаар тогтоолоор баталсан байршил, нэр төрөл, тоо хэмжээнд нь бүрдүүлж, технологийн дагуу хадгалж байна. ЭМ-ийн сайдын 2011 оны 185 дугаар тушаалаар “Гамшгийн үед хүн амын хүнсний хэрэглээний хоногийн жишиг хэмжээ”-г баталсан.

Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам”-ын дагуу улсын нөөцөд хадгалж байгаа хүнсний бараа, материалыг шинэчлэх төлөвлөгөөг Монгол Улсын Шадар сайдын тушаалаар жил бүрийн эхэнд батлуулан хэрэгжүүлж, улсын нөөцийн хүнсний бараа, материалын аюулгүй байдлыг хангаж байна.

ХШҮ- 100%

Үйл ажиллагаа 6.2. Гамшиг болон эдийн засгийн тогтворгүй байдал, хүнсний хомсдлын үед улсын нөөцөд байвал зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг шинэчлэн тогтоож, нөөц бүрдүүлэх.

Засгийн улсын 2012 оны 248 дугаар нууцын зэрэглэлтэй тогтоолоор гамшиг болон стратегийн хүнсний нөөцийн байршил, нэр төрөл, тоо хэмжээг тогтоосон.

2013 оны байдлаар стратегийн нөөцийн хүнсний бараа, материалын бүрдүүлэлт 86.1 хувь, гамшгийн нөөцийн хүнсний бараа, материалын бүрдүүлэлт 83.0 хувьтай байв.

2014 оны байдлаар стратегийн нөөцийн хүнсний бараа, материал 78.8%, гамшгийн нөөцийн хүнсний бараа, материал 81.3%-ийн биелэлттэй байна. Гамшиг онцгой байдлын үед ашиглах нөөц бүрдүүлж 30000ш өндөр тунт Д аминдэмийг бэлдсэн.

Улсын нөөцөд хадгалах хүнсний бараа, материалыг мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн хүлээж авах, Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу сэлгэх, шинэчлэх, технологийн дагуу чанар байдлыг нь бууруулахгүй хадгалах, улсын байцаагчийн дүгнэлтийг жилд 2-оос доошгүй удаа гаргуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 6.3. Улсын нөөцийн агуулахуудыг хүнсний бүтээгдэхүүн удаан хугацаагаар хадгалах шаардлагад нийцүүлэн тоноглож, хүчин чадлыг нь нэмэгдүүлж, бүс нутгийн онцлогийг харгалзан зохистой байршуулах.

Хүнсний бараа, материал хадгалж байгаа агуулахуудад жил бүр их болон урсгал засвар, агуулахын ариутгал, халваргүйжүүлэлтийн ажлыг төлөвлөгөөний дагуу тогтмол хийж, агуулахын бэлэн байдлыг хангаж ажилласан. Улсын нөөцийн агуулахуудын дийлэнх хувийг хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн тоногдсон бөгөөд нарийн хадгалах горим шаардсан бүтээгдэхүүнийг гэрээт агуулахуудад хадгалж байна.

Онцгой байдлын ерөнхий газраас Улаанбаатар хотод улсын нөөцийн хүнсний бараа, материалыг технологийн дагуу хадгалах зориулалтын иж бүрэн механикжсан агуулахын цогцолборын зураг төслийн хөрөнгийн асуудлыг 2014-2015 оны хөрөнгө оруулалтын ерөнхий төлөвлөгөөнд оруулах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2014 оны хөрөнгө оруулалтын ерөнхий төлөвлөгөөнөөс хасагдсан. Уг цогцолборын хөрөнгийн

асуудлыг 2015-2016 оны хөрөнгө оруулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгах саналыг Сангийн яаманд дахин хүргүүлэхээр ажиллаж байна.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 6.4. *Аймаг, сумын түвшинд гамшгийн үед хэрэглэх хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцтэй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.*

Шинээр батлагдсан “Хүнсний тухай” хуульд монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаанбуудай, гурил, ундны усыг стратегийн хүнсэнд хамааруулахаар заасан. Улсын нөөцийн хүнсний бараа, материалыг Засгийн газрын 2012 оны 248 дугаар тогтоолоор баталсан байршил, нэр төрөл, тоо хэмжээнд нь бүрдүүлж, технологийн дагуу хадгалж байна.

Аймаг, сумын түвшинд гамшгийн үед хэрэглэх хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг тухайн шатны Засаг дарга нар бүрдүүлэхээр “Улсын нөөцийн тухай” хуулиар зохицуулсан.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 6.5. *Гамшгийн үед хоол тэжээлийн дуталд өртөмтгий бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эхэд хүнсний тусламж үзүүлэх, тэдгээрийг аминдэм, эрдсийн бэлдмэлээр хангахад чиглэгдсэн нөөц бий болгож хэрэгжүүлэх механизм бүрдүүлэх.*

Улсын нөөцөд чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн байлгах зорилгоор чийг хэмжигч болон цацрагийн хэмжигч багаж ашиглан цаг тухайд нь тэмдэглэл хөтөлж ирсний зэрэгцээ цэвэр усны нөөцийг тоо хэмжээ, чанарын шаардлагын дагуу бүрдүүлсэн.

Болзошгүй гамшиг тохиолдсон үед хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой хангах зорилгоор стратегийн болон гамшгийн нөөцөд хадгалах хүнсний бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, эслэгийн болон хүнсний бүтээгдэхүүний хоногийн хэрэгцээний дагуу шинэчлэн тогтоосон.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хүнс тэжээлийн хяналт болон хямралын үед эрт сэрэмжлүүлэх систем”-ийн талаар судалгаа хийлгэж, судалгааны дүн, тайлан, зөвлөмжийн төслийг танилцуулах семинарыг 2012 оны 5 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж холбогдох талуудыг урьж оролцуулав.

Гамшгийн үед хүүхэд, жирэмсэн, хөхүүл эхийг аминдэм, эрдсийн бэлдмэлээр хангах НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ-ын зөвлөмжийг үндэслэн нөөц бүрдүүлэх зөвлөмж боловсруулж холбогдох газруудад хүргүүлэн, гамшгийн үед хэрэглэх өндөр тунт А, Д аминдэм, ОНБТБ/олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл/-ийн нөөц бүрдүүлээд байна. 2013 онд гамшгийн үед шаардагдах хүнс болон амин дэм, эрдэс бодисын нөөцийг бүрдүүлэх хөрөнгийн 50-60 хувийг санхүүжүүлсэн.

Гамшиг онцгой байдлын үед ашиглах нөөцөд 30000ш өндөр тунт Д аминдэмийг бэлдсэн.

ХШҮ-70%

Зорилт 7: Хүнсний үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулж Монгол брэндийн хүнс экспортлох нөхцөлийг бүрдүүлэх

Үйл ажиллагаа 7.1. *Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрүүдийн хоршсон цогцолбор бий болгоход татвар, зээл, санхүүгийн түрээсийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж, санал боловсруулах.*

“Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын тухай ” хууль 2009 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан. Эдийн засгийн хөгжлийн яамнаас хүнсний үйлдвэрүүдийн кластерийн чиглэлээр судалгаа хийгдсэн.

Сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр 2012 онд сүүний үхрийн 25 аж ахуйн нэгжид 400.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 5 жилийн хугацаатай зээл олгосон. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд сүүний үхрийн 70 үнээтэй цогцолбор улсын төсвийн хөрөнгөөр бий болсон. Сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг өргөтгөн хөгжүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулж, Булган, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Архангай аймгийн болон Нийслэлийн зарим дүүрэгт сүүний үхрийн 74 аж ахуйд нийт 1.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн.

Хот суурин газрын сүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газрын 2013 оны 141 дүгээр тогтоолоор 27.7 сая ам.долларын эх үүсвэрийг шийдвэрлэсэн. Гадаад орноос өндөр ашиг шимтэй сүүний үхэр импортлон нутагшуулах чиглэлээр 32 төслийг сонгон шалгаруулж, төслийн баримт бичгийг санхүүжүүлэхээр Голомт банкинд хүргүүлсэн.

2013 оны 12 дугаар сарын байдлаар сүүний үхрийн аж ахуй эрхэлдэг 7 аж ахуйн нэгж 6.6 тэрбум төгрөгийн зээл авсан, зээл авах банкны шалгуур үзүүлэлтийг 8 аж ахуйн нэгж хангаад байна.

“Ажигана” ХХК “Оргио” махны тахианы аж ахуй-үйлдвэрийн цогцолбор, “Мон таримал” ХХК сүүний үхэр-газар тариалан-сүү боловсруулах цехийн цогцолбор, “Гацуурт” компани махны үүлдрийн үхрийн аж ахуй-махны үйлдвэр, НБЦ компани өндөглөгч тахиа-өндөгний үйлдвэр, “Тайширын хүлэг” компани сүүний үхрийн аж ахуй-сүүний үйлдвэрийн цогцолбор, орон нутгийн 11 гурилын үйлдвэр газар тариалан хослон эрхэлж хоршсон цогцолбор бий болгоод байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 7.2. Хот, суурингийн хүн амыг үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүгээр хангах шаардлагад нийцүүлэн үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж, санал боловсруулах.

2013 онд улсын хэмжээнд тараг, аарц зэрэг уурагт бүтээгдэхүүний үйлдвэрийн цехийн тоо нэмэгдэж, нийт дүнгээр 152 цех ажиллаж байсан бол 2014 оны 9-р сарын байдлаар улсын хэмжээнд нийт 166 үйлдвэр, цех ажиллаж байна. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон нэг хүнд ногдох сүүний хэмжээ жил бүр өсч байна.

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

	2012 он	2013 он	2014.ХII
Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сая төгрөг	40519.0	44492.4	53567.3
Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, мянган тн	53.2	50.1	73.1
Нэг хүнд ногдох сүү, кг	187	203.6	258.3

Эх сурвалж:ХАА 2013, УСХ

АПУ ХХК нь хоногт 150 тонн шингэн сүү хүлээн авч боловсруулах хүчин чадал бүхий бүрэн автомат сүүний үйлдвэрийг 2014 оны 6 сард ашиглалтанд оруулан “Сайн”, “Маамуу”, “Цэвэр сүү”, мөн тараг, йогурт, цөцгий зэрэг нийт 21 нэр төрлийн сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүргэж байна. “Монфреш” ХХК монгол

үнээний цэвэр сүүгээр франц технологи ашиглан 9 нэр төрлийн бяслаг үйлдвэрлэн дотоодын зах зээлд нийлүүлж байгаа ба удахгүй экспортонд гаргахаар ажиллаж байна. ТЭСО ХХК нь хоногт 100 тн шингэн сүү боловсруулан 10 тн хуурай сүү үйлдвэрлэх үйлдвэрийг 2014 оны 10 сард ашиглалтанд оруулсан. Үйлдвэрээсээ 300 км-ийн радиуст байрлах сонгон авсан сумдад тус бүр 15 тонны хүчин чадалтай 8 хөргөлтийн төв, 20 тасгийг байгуулж, 5 тонны багтаамж бүхий 8 цистернээр үйлдвэртээ татан авч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны "БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох экспортын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалт батлах тухай" 127 дугаар тогтоолын дагуу 4.1 сая ам.долларын өртөгтэй "Сүүний хөргөлтийн төвийн техник, тоног төхөөрөмж худалдан авах" хэлэлцээрийг БНХАУ-ын "China National Technical Import & Export Corporation" (CNTIC) компанитай хийж, гэрээ байгуулахаар ажиллаж байна.

Засгийн газраас сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 27.7 сая ам.долларын хөрөнгө оруулалтын зээлийг Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Голомт банкаар дамжуулан аж ахуйн нэгжүүдэд олгох шийдвэр гаргаснаас сүү боловсруулах 4 үйлдвэрт нийт 12.3 тэрбум төгрөг, сүү боловсруулах цехийн 15 төсөлд 2.2 тэрбум төгрөгийн зээл тус тус батлагдсан байна

Улсын хэмжээнд жилд дунджаар 8.2 гаруй сая толгой мал хүнсэнд хэрэглэж, 200 гаруй мянган тн мах үйлдвэрлэн, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг. Улсын хэмжээнд 2013 оны байдлаар мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн тоо: Мал нядлах, эхлэн боловсруулах 42, Хиама, нөөшилсөн бүтээгдэхүүний үйлдвэр 131, Хагас боловсруулах үйлдвэр 21 байна. Нийт үйлдвэрийн нядалгааны хүчин чадал нь хоногт 18620 толгой бог буюу 559 тн/хоног жилд 55.9 мянган тн /100 хоног/, 3600 толгой бод буюу 900 тонн/хоног жилд 90.0 мянган тн /100 хоног/ байна. Хөлдөөлтийн хүчин чадал 1160.2 тн, хөргөлттэй агуулахын хүчин чадал 80237 тн байна.

МАХНЫ НӨӨЦ, ХАНГАМЖ

	2012 он	2013 он	2014УГ
ХАА-д бэлтгэсэн мах, мян.тн	220.4	249.7	294.5
Махны экспорт, мян.тн	3.7	3.8	2.57
Махны импорт, мян.тн	7.24	13.24	13.93
Махны нөөц, мян.тн	224.6	259.2	-
Хүн амын махны хангамж,%	127.1	141.9	-

Аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (НАССР)-г “Мах маркет” ХХК-ийн Төв махны үйлдвэрийн ангилан савлах цех нэвтрүүлэн баталгаажуулсан, “Дархан мийт фүүдс” ХХК-ийн махны үйлдвэр нэвтрүүлж, баталгаажуулалтын шатанд байгаа бөгөөд уг тогтолцоог нэвтрүүлэхэд гадаадын төслийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажилласан. Махны нөөц бэлтгэлд зориулж эргэлтийн хөрөнгийн зээлийг “Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд олгож байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 7.3. *Аймаг, сум, суурин газруудын хэрэгцээнд тохирсон бага, дунд хүчин чадал бүхий мах, сүү, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, ургамлын тос боловсруулах жижиг үйлдвэр, цех байгуулах үүсгэл санаачилга болон энэ чиглэлийн хөрөнгө оруулалтыг дэмжих.*

Хөвсгөл аймагт өрхийн болон малчны бүлгийн түвшинд сүү боловсруулах бага оврын тоног төхөөрөмж нийлүүлэх 36 багц нийлүүлэх тендер зарлаж шалгарсан компанитай гэрээ байгуулан ажиллаж, 2012 оны 9 дүгээр сард дээрх багц тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн.

“Түүхий эд боловсруулах үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэх”, “Хоногт 1000-аас доошгүй литр сүү хүлээн авч боловсруулах үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэх” тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулан ажилласнаар Өвөрхангай аймгийн Уянга, Хужирт, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий суманд хоногт 1000 тонн сүү боловсруулах үйлдвэр байгуулагдсан.

БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр хоногт 60 тн сүү боловсруулах хүчин чадалтай хуурай сүүний үйлдвэр байгуулах асуудлаар CNTIC, САМС компаниудтай хэлцэл хийсэн. Мөн сүүний хөргөлтийн 50 төв, жилд 5000 тонн чацаргана боловсруулах үйлдвэр байгуулах гэрээг байгуулав.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Баянхонгор аймгийн Бууцагаан суманд өдөрт 10 бод, 50 бог нядлах хүчин чадалтай сум дундын мал нядалгааны цехийг 396 155 694 төгрөгийн төсвийн санхүүжилтээр байгуулагдсан. НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж буй “Махны чанар, аюулгүй байдлыг сайжруулах” төсөлтэй хамтран 2012 онд хоногт 5 бод, 20 бог мал төхөөрөх хүчин чадалтай 15 цехийг ашиглалтад оруулсан. 2013 онд улсын хэмжээнд тараг, аарц зэрэг уурагт бүтээгдэхүүний цехийн тоо 45-аар нэмэгдэж, урьдчилсан судалгаагаар 152 цех ажиллаж байна.

- НҮААГ- Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, фермерийг дэмжин 500 сая төг-ийн хөнгөлөлттэй зээл олгосон.
- Завхан аймгийн 4 суманд мал нядалгааны цэг, Говьсүмбэр амийгийн Шивээговь суманд мал нядалгаа, “Цөцгийнтос, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 196.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд (ҮХААЯамны 198.0 сая төгрөгийн дэмжлэгээр) мал нядалгааны газар, Хэнтий аймагт сум хөгжүүлэх сангаас сум дундын мал нядалгаа, цагаан идээ боловсруулах цехийг 93.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр дэмжлэг үзүүлж байгуулсан.

Зөвхөн аймаг орон нутагт 2014 онд урьдчилсан судалгаагаар хүнсний чиглэлийн 15 үйлдвэр, 114 цех шинээр ашиглалтад орсноос гурилын 7 үйлдвэр 47 цех, сүү, сүүн бүтээгдэхүүний 6 үйлдвэр, 30 цех, төмс, хүнсний ногоо боловсруулах 2 үйлдвэр, 8 цех, мах, махан бүтээгдэхүүний 12 цех, мал нядалгааны 13 цех бусад чиглэлийн 4 цех байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2014 онд хүнсний салбарт 383.0 сая төгрөгийн зээл олгосон.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 7.4. *Органик хүнсний үйлдвэрлэлийг урамшуулан дэмжиж, тэдгээрийг эрх бүхий олон улсын байгууллагаар баталгаажуулах, үндэсний болон олон улсын түвшинд Монголын газар зүйн заалттай бүтээгдэхүүнд бүртгүүлэх арга хэмжээ авах.*

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хооронд байгуулсан хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд 2012 онд Монгол хүнснийг “органик бүтээгдэхүүн” болохыг баталгаажуулах, экспортлоход чиглэсэн төсөл хэрэгжүүлэх саналыг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагад, органик бүтээгдэхүүнийг хянах, баталгаажуулах талаар төсөл хэрэгжүүлэх санал, төслийн танилцуулгыг БНСУ-ын “КОЙКА” байгууллагад тус тус хүргүүлсэн.

“Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “органик хүнс”-ний тодорхойлолт болон түүний үйлдвэрлэл, экспортод үзүүлэх дэмжлэгийн талаар тусгасан. УИХ-ын 2012 оны хаврын чуулганаар байгаль орчны багц хуулиуд шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийн 18.4 дэх заалтад “Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газар батална” гэсэн нэмэлт өөрчлөлт орсны дагуу органик хүнс боловсруулах үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийг байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийн жагсаалтад оруулахаар ажиллаж байна.

“Органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх журам”, “Байгаль орчинд халгүй, дэвшилтэт технологиор бүтээгдсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагад эко-тэмдэг олгох тухай журам” болон “Ногоон эдийн засгийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн төсөлд органик үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх талаар тусгасан.

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 242 дахь заалтад органик үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэхээр 14.1 тэрбум төгрөг тусгуулсан.

Тайланд Улсын Бангкок хотноо 2012 оны 6 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд хийгдсэн Бүс нутгийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (APLAC)-ын “Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-ийн Зөвлөлийн 29 дүгээр хуралдаанаар Монгол Улсын итгэмжлэлийн байгууллагыг тус хэлэлцээрт нэгдэн орохыг дэмжсэнээр Монгол Улс үндэсний итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлж, үйл ажиллагаагаа олон улсын жишигт нийцүүлсэн, хэлэлцээрт нэгдсэн 38 дахь гишүүн орон болсон. Гишүүн орнуудын хүрээнд экспортын бараа бүтээгдэхүүн давтан шинжилгээ хийхгүйгээр бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг харилцан хүлээн зөвшөөрөх тогтолцоог бүрдүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүрэгт өөрийн нэрийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээ, “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн, худалдааны үеэр бүтээгдэхүүнээ сурталчлах, борлуулах ажил өргөн хүрээтэй хийгдлээ. Үүний үр дүнд олон улсын түвшинд Монгол Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр хүнд өсч, өрсөлдөх чадвар сайжрах боломж бүрдэж байна.

“Органик хүнсний тухай” хуулийн болон “Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулсан.

СХЗГ-аас 2013-2014 онуудад төв орон нутгийн 20 аж ахуйн нэгж, байгууллагын 93 бүтээгдэхүүнд “Үндэсний тохирлын тэмдэг” хэрэглэх эрх олгосон бөгөөд үүний 54 нэр төрөл нь органик хүнсний бүтээгдэхүүн эзэлж байна.

“Органик хөдөө аж ахуйг дэмжих” төслийн хүрээнд олон улсын газар тариалангийн органик аж ахуйн өнөөгийн байдлын талаарх судалгаа, эх орны байгальд ээлтэй, газар тариалангийн аж ахуйн өнөөгийн байдал, зах зээлийн судалгаа”, “Органик хүнсний нэмүү өртгийн сүлжээг тодорхойлох” зэрэг судалгааг хийж байна.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 7.5. *Бэлчээрийн малын мах, сүү, экологийн цэвэр орчинд ургуулсан төмс, хүнсний ногоо, байгалийн жимсийг шилдэг технологиор боловсруулж, гадаад зах зээлд "Монгол брэндийн хүнс" нийлүүлэхийг дэмжих.*

Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүн /чацаргана, мах, төмс гэх мэт/ боловсруулах органик үйлдвэр байгуулах, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн арга, технологид шилжсэн шилжилтийн үйлдвэр бий болгох, органик хүнсийг баталгаажуулах,

Европын холбооны Ерөнхий хөнгөлөлтийн "GSP+" журамд хамрагдах экспортлох зорилгоор Европын холбоонд төсөл хэрэгжүүлэх санал, танилцуулгыг 2013 онд хүргүүлсэн.

Үндэсний тохирлын тэмдэг хэрэглэх эрхийн хугацааг 2012 онд 5 аж ахуйн нэгжийн 11 нэр төрлийн бүтээгдэхүүнд сунгах буюу шинээр олгосны дотор Завхан аймгийн “Завхан баялаг” ХХК-ийн үйлдвэрлэдэг жимсний чанамал, хатуу чихэр, хүнсний иоджуулсан давс, мөн аймгийн “Гарамгай” ХХК-ийн “Отгонтэнгэр” цай зэрэг бүтээгдэхүүнд, 108 нэр төрлийн мах, махан бүтээгдэхүүн, 54 нэр төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг холбогдох стандартын дагуу баталгаажуулалтад хамруулж үндэсний тохирлын гэрчилгээ олгосон.

Нялхас, бага насны хүүхдийн нунтаг сүүн тэжээлийн эрүүл ахуйн дадлын шаардлага MNS CAC RCP 66:2010 стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор батлуулсан. Энэ дагуу 2012 онд Витафит ХХК-ийн үйлдвэрлэдэг “Гоё” нэрийн тарганд тохирлын гэрчилгээ олгосон.

Сэлэнгэ аймгийн Аргангат ЗГБХ нөхөрлөлийн “Шижир” нэрийн зөгийн бал /сунгасан/, Баян-Өлгий аймгийн Акбоар ХХК-ийн үйлдвэрлэдэг Казы бүтээгдэхүүн, Дорноговь аймгийн Далт мөнгөн шанд ХХК-ийн үйлдвэрлэдэг “Загсгал” цай/шинээр/, Өмнөговь аймгийн Ингэн тагш ХХК-ийн Ингэний 6 төрлийн сүүн бүтээгдэхүүн /шинээр/, Говь-Алтай аймгийн “Цонж” ХХК –ийн тариалж үйлдвэрлэдэг “Хөх арвайн гурил”/шинээр/, мөн Говь-Алтай аймгийн “Бор голын цагаан толгой” ЗГБХ нөхөрлөлийн үйлдвэрлэдэг Хорхой ааруул /шинээр/, Говь-Алтай аймгийн “Тулга-Алтай” ХХК –ийн үйлдвэрлэдэг Чацарганатай жигнэмэг /шинээр/, Овьёост жигнэмэг /сунгасан/, Хөвсгөл аймаг Аяны жолоо ХХК-ийн үйлдвэрлэдэг Сүүт, Шанзтай еэвэн /сунгасан/, Зохицуулах үйлчилгээтэй 5 нэрийн (Овьёосны, Хөх тарианы, Хивэгтэй, Арвайн, Гурвалжин будааны) жигнэмэг /шинээр/, Хөвсгөл аймаг Титаник ХХК –д үйлдвэрлэсэн Монгол зөөхий /сунгасан/, Сүүн ааруул /шинээр/ зэрэг бүтээгдэхүүнд тус бүрт нь “Үндэсний тохирлын тэмдэг” хэрэглэх эрх олгосон.

Монгол брэндийн төмсийг боловсруулан экспортлох төслийг Чингис хаан бондын хөнгөлөлттэй зээлэнд хамруулахаар Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Эх орны хүнсний бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд таниулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд экспортын бүтээгдэхүүний баталгаажуулалтаар дэмжлэг үзүүлэх чиглэлээр “Үхрийн нүдний жимс. Техникийн шаардлага”, “Чацарганы тос. Техникийн шаардлага”, “Чацарганы тос шинжлэх арга” стандартуудыг шинэчлэнтехникийн хороогоор хэлэлцүүлсэн. “Адууны махан уламжлалт бүтээгдэхүүн. Каз, карта, чужук, жал, жая. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг Стандартын үндэсний зөвлөлийн 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

2014 онд Монгол улс Япон улсын хооронд байгуулсан “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”-т чацарганы бүтээгдэхүүнийг Япон улсад экспортлоход гаалийн татварыг хөнгөлөхөөр тусгуулав. 2012-2014 онд чацарганы тос 138.7 литр, чацарганын шүүс 12.0 тонныг тус тус гадаадын зах зээлд экспортолсон байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 7.6. *Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх бүс нутаг болон бүтээгдэхүүн, үйлчилгээний салбар бүрээр тэргүүлэх чиглэлийг тогтоож хэрэгжүүлэх.*

“Органик үйлдвэрлэл эрхлэх экологийн цэвэр бүсийн судалгаа”-г хийж, органик болохыг тодорхойлох шалгуур үзүүлэлт, органик чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийн

судалгаа, органик үйлдвэрлэлийн түвшинд хүрэх арга замыг тодорхойлсон зөвлөмж гаргав.

Орон нутагт өөрсдийн нөөц, боломжоор органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн сургалтыг хүнс үйлдвэрлэгч, тариалан эрхлэгч, иргэдийг оролцуулан зохион байгуулсан. “Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулсан.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 7.7. Монгол брэндийн болон органик бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ-эко маркетинг бий болгох, энэ чиглэлээр гадаад, дотоод зах зээлийн судалгаа явуулж, сурталчлах арга хэмжээ авах.

НҮБ-ын ХХААБ-тай хамтран хэрэгжүүлж буй органик хүнсийг баталгаажуулах талаар техник туслалцааны төслийн хүрээнд органик хүнсний чиглэлээр суурь судалгаа хийх, сургалт сурталчилгаа явуулах, органик ферм байгуулахад дэмжлэг үзүүлэх, баталгаажуулалтын байгууллага байгуулах, органик Монгол хүнсийг баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөөд ажиллаж байгаа ба МҮХАҮТ-ын Эко зөвлөл, СХЗГ-тай органик хүнсний баталгаажуулалт, итгэмжлэлийн асуудлаар хамтран ажиллах талаар уулзалт зохион байгуулав. Органик үйлдвэрлэлийн чиглэлээр “Монгол төмс” хөтөлбөр, Зөгийн аж ахуй эрхлэгчдийн холбоо, ШУТИС-ын лаборатори, Монгол сонгино судлаач, Экоэрдэнэ ХХК-ын чацарганын үйлдвэр, Артишок тариалалтын хүлэмж зэрэг үйлдвэрийн төлөөлөлтэй хамтран ажиллах уулзалт хийж, санамж бичиг байгуулахаар ажиллаж байна.

Стандартчиллын үндэсний зөвлөлөөс экологийн цэвэр орчинд ургасан жимс, жимсгэнийг түүх, хадгалах, тээвэрлэх техникийн шаардлагын дараах 8 стандартыг баталсан. Үүнд: Нохойн хошуу, алирсны жимс, хөх нэрс, үхрийн нүдний жимс, ойн мөөг, хушны боргоцой түүх, хадгалах, тээвэрлэх, техникийн шаардлага; хусны шүүс бэлтгэх, хадгалах, тээвэрлэх техникийн шаардлага.

ХШҮ-50%

Үйл ажиллагаа 7.8. Органик бүтээгдэхүүний нэр төрлийг олируулахад чиглэгдсэн шинжлэх ухаан, технологийн төсөл, судалгаа, шинжилгээний ажилд нэн тэргүүнд дэмжлэг үзүүлэх.

АФАСИ ОУБ-аас хэрэгжүүлж буй “Органик хөдөө аж ахуйн Азийн орнуудын сүлжээ байгуулах” төслийн хүрээнд Органик Монгол хөтөлбөртэй хамтран ажиллах гэрээ байгуулан “Органик чацаргана ургуулах технологи нэвтрүүлэх” төсөл хэрэгжүүлж Багануур дүүрэгт чацаргана ургуулах технологийг УХЭШХ-ийн эрдэмтэдтэй хамтран боловсруулсан.

“Монгол төмс” хөтөлбөрийн хүрээнд “Органик төмс” үйлдвэрлэж байна.

ХШҮ-90%

Зорилт 8: Хүнсний түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүх дамжлагад хөдөө аж ахуй, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлуудыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах:

Үйл ажиллагаа 8.1. Мал нядалгааны газар, сүү хүлээн авах цэгүүдийн үйл ажиллагаанд эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж гэрчилгээжүүлэх.

“Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын 8.1.5-д үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлсэн аж ахуй нэгжид төрөөс дэмжлэг урамшуулал үзүүлэх тухай заалт оруулж эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Мөн хуулийн 10 дугаар зүйлд заасан хүнсний

чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлагад зохистой дадал нэвтрүүлэх асуудал тусгагдсан.

“Хүнсний үйлдвэрлэл, эрүүл ахуйн зохистой дадлыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, уг сургалтад ЭМЯ, ҮХААЯ-ны холбогдох мэргэжилтэн, МХЕГ, НМХГ-ын хүнс, халдвар судлал, орчны эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид болон Сүү, АПУ ХК, Эм си эс, Жем интернейшнл, Талх чихэр, Мах импекс, Хаан хүнс, Жүр-Үр, Бамбууш, Витафит, Траст трейд, Хүнс комплекс, Хаан брой, Мон сүү ХХК-ийн төлөөллийг оролцуулан нийт 105 хүнд гэрчилгээ олгосон.

Хүнсний сүлжээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмж тус тус боловсруулж Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014 оны 156 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эрүүл ахуйн зохистой дадлын Олон улсын Хүнсний эрх зүйн хорооноос гаргасан 2 стандартыг үндэсний стандарт болгон баталсан. Үүнд:

MNS CAC RCP 58:2013, Махны эрүүл ахуйн дадлын дүрэм,

MNS CAC RCP 57:2014, Сүү, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуйн дадлын дүрэм.

НҮБ-ийн ХХААБ-ын TCP/MON/3401 төслийн санхүүжилтээр ҮХААЯ, ЗГХА МЭҮГ, МХЕГ, Кодексийн үндэсний зөвлөл хамтран аймаг, нийслэлийн (Увс, Завхан, Дархан-Уул, Орхон, Улаанбаатар) мал, амьтны хорио цээр, чанарын хяналтын улсын байцаагчид болон малын эмч, технологич, холбогдох албан тушаалтан, мэргэжилтэн нарын 50 гаруй төлөөллийг оролцуулсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх, экспортын махны мал эмнэлэг, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагыг хангах, холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх” 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан.

“Хөдөө аж ахуйн зохистой дадлыг эзэмшүүлэх нь”, “Эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх”, “Үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх”, “Ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх нь”, “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох, бүртгэл хөтлөх”, “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал” сэдэвт сургалтыг Өвөрхангай, Архангай, Орхон, Говьсүмбэр сэдэвт сургалт зохион байгуулсан.

Зүүн, баруун, хангайн бүсийн сүүний фермийн аж ахуй, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлд хөдөө аж ахуй, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх, холбогдох кодексийн стандартыг таниулах онол практикийн сургалтыг холбогдох аж ахуйн нэгж байгууллага, малчид, фермерийн төлөөлөл бүхий нийт 160 гаруй оролцогчдыг хамруулан амжилттай зохион байгуулав

“Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам”-ын сургалтыг зохион байгуулж, сургалтанд оролцсон хүмүүст “Хүнсний аюулгүй байдлын талаарх хууль тогтоомжийн эмхэтгэл” №6 боловсруулан, эмхэтгэн хэвлүүлж тараасан.

НМХГ-аас Баянгол, Хан-уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй сүү, сүүн бүтээгдэхүүний 12 аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал /GMP, GHP/ нэвтрүүлэх зөвлөмжийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулав.

“Хөдөө аж ахуйн зохистой дадал, Эрүүл ахуйн зохистой дадал, Үйлдвэрийн зохистой дадал нэвтрүүлэх хялбаршуулсан заавар”-ын төслийг боловсруулсан.

Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, цех зэрэг 104 ААН-ийн менежер, эрүүл ахуйч, технологич, мастер зэрэг удирдах албан

тушаалтан, нийслэл дүүргийн 12 улсын байцаагчийг оролцуулсан “Үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал” нэвтрүүлэх талаарх сургалт явуулсан.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 8.2. Хүнсний боловсруулах үйлдвэрт хэрэглэх цэвэр өсгөврийн хөрөнгө, хүнсний нэмэлт, туслах түүхий эдийн бүртгэл, хяналтыг боловсронгуй болгох.

“Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын 16.1-д “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын бүртгэлд бүртгэлд бүртгэнэ” гэсэн заалт тусгагдсан. Үүнтэй холбогдуулан “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-ын төслийг боловсруулан хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох байгууллагын саналыг тусгасан.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 8.3. Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэл, пестицид, бусад химийн бодисын үлдэгдэл, хүнд металл болон өвчин үүсгэгч нянгийн бохирдлыг хянах, тандах чиглэлээр төсөл боловсруулан хэрэгжүүлэх.

Мал эмнэлэг, үржлийн газар, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори, Жаст-Агро ХХК-ийн “Мах маркет” үйлдвэртэй хамтран 2011 онд “Баруун бүсийн нутгийн малын махан дахь үлдэгдэл бодисын тандалт шинжилгээ”, “Үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөрийн төсөл” боловсруулах захиалгат ажлыг гүйцэтгүүлсэн. Баруун бүс нутгийн малын махан дахь үлдэгдэл бодисын тандалт шинжилгээнд Завхан, Хөвсгөл, Баянхонгор, Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай аймгийн зарим сум хамрагдсан. Үхэр, хонь, ямаа, адууны махны 257 дээжинд 13 үзүүлэлтээр 4097 экспертиз шинжилгээг хийж дүгнэлг гаргасан байна. Энэ тандалтын шинжилгээний дээжинд каратэ, авермектин, ивермектиний үлдэгдэл илрээгүй. Цаашид шинжилгээнд хамрагдах малын тоог нэмэгдүүлэн судалгааны ажлыг өргөтгөн цаг хугацааны давтамжтай болгох шаардлагтай гэж үзсэн.

Малын гаралтай бүтээгдэхүүн дэх эмийн үлдэгдлийн хэмжээг тодорхой төлөвлөгөөний дагуу жил бүр хянах, түүний үр дүнд тулгуурлан эмийн үлдэгдлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор малын эм, бэлдмэлийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтоож, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар баталсан.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 8.4. Хүнсний боловсруулах үйлдвэрүүдэд аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (НАССР), Хүнсний аюулгүй байдлын чанарын удирдлагын тогтолцоо (ISO9001), Хүнсний хэлхээ (дамжлагуудын)-ний хяналтын тогтолцоо (ISO22000:2007)-г нэвтрүүлэх.

“Мах Маркет” ХХК нь Аюулын дүн шинжилгээ ба эгзгийг хянах цэгийн /НАССР/ тогтолцоог, “Сүү” ХК, “АПУ” ХК, “MCS” ХХК, “Алко” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд MNS ISO22000:2007 стандартын дагуу чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээр түүхий эд, бүтээгдэхүүний стандарт, чанарт технологийн хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн. Тохирлын үнэлгээ хийгдсэн хүнсний чиглэлийн 120 гаруй үйлдвэрт дотоод хяналтын болон удирдлагын тогтолцооны талаар заавар, зөвлөмж өгсөн. Спирт бал бурам ХХК болон түүний УБ дахь салбар үйлдвэр, АПУ ХК, Трансинконсулт ХХК, Увс хүнс ХХК, Витафитинвест ХХК, “Арвайн үндэс” ХХК зэрэг үйлдвэр, аж ахуйн газарт Чанарын

удирдлагын тогтолцоо(ISO 9001 олон улсын стандартын дагуу), Хүнсний үйлдвэрлэлийн хэлхээний аюулгүй байдлын хяналтын тогтолцоо (ISO 22000 олон улсын стандартын дагуу)-г нэвтрүүлсэн гэрчилгээ олгосон.

СХЗГ-ындэргэдэх бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын алба нь олон улсын /ISO/IEC 17021/ стандартын дагуу ур чадвараа тогтоолгон итгэмжлэгдсэн. Дархан-Уул аймгийн Дархан meat фүүдс ХХК-иас гаргасан хүсэлтийг үндэслэн Стандарт хэмжил, зүйн газрын даргын 2013 оны А/272 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг тус компанийн мал нядлах болон мах боловсруулах үйлдвэрт Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо(НАССР), “Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах тогтолцооны баталгаажуулалтын журам”-ын шаардлага, батлагдсан удирдамжийн дагуу анхдагч аудитыг хийж, зарим асуудлыг дахин хянаж үзэхээр шийдвэрлэсний дагуу тус компани зохих шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Европын Холбооноос хэрэгжүүлсэн “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төслийн хүрээнд махны үйлдвэрлэл болон махны хяналтыг олон улсын шаардлагад нийцүүлэн сайжруулж, махны үйлдвэрлэлийн бүх гинжин хэлхээнд ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэн стандартын шаардлага хангасан эрүүл хүнсээр хүн амын хэрэгцээг хангах, энэ талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг сайжруулах зорилгоор шийдвэр гаргах түвшний албан тушаалтанд болон малын эмч, мэргэжилтнүүд, мал нядалгааны газар, мах боловсруулах үйлдвэрийн удирдлага, инженер техникийн ажилтнуудад зориулж НҮБ-ын ХХААБ-аас эрхлэн гаргасан “Махны үйлдвэрлэлийн зохистой дадал” гарын авлага(А4-ийн 32 хэвлэлийн хуудас)-ыг монгол хэл дээр анх удаа орчуулж хэвлэсэн.

БНСУ-ын Хөдөөгийн хөгжлийн KRC байгууллагын “Монгол Улсад амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуйн хяналтын системийг сайжруулах” төсөл 2012 оноос эхлэн Технологийн дээд сургууль дээр хэрэгжиж байна.

- НАССР/- тогтолцоог "Дархан meat фүүдс" ХХК –ний Мал төхөөрөх, сэврээх, хэсэглэх, ангилах, савлах, хөлдөөх, хадгалах үйл ажиллагааны хүрээнд;
- Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог олон улсын ISO 22000 стандартын шаардлагын дагуу "Спирт бал бурам" ХК согтууруулах ундаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд;
- “Ажигана” ХХК /дэгдээхэй бойжуулах/, “Лоудстоуне Могул” ХХК /катеринг/, Тэсо корпорацийн "Кингснэк" үйлдвэр /хөнгөн зууш/,"Витойл" үйлдвэр /хүнсний тос/, "Айсмарк" үйлдвэр /зайрмаг/, "Агь" ХХК /гоймонгийн болон хүнсний бүтээгдэхүүн савлах/ чанарын удирдлагын тогтолцоог олон улсын ISO 9001 стандартын шаардлагын дагуу хэрэгжүүлснийг баталгаажууллаа.
- "Дойчевурст" ХХК, “Агь” ХХК, “Айсмарк” ХХК-ний хүнсний аюулгүй байдлын болон НАССР тогтолцоог баталгаажуулах ирүүлсэн дээрхи байгууллагуудын баримт бичигт дүн шинжилгээ хийгдэж байна.
- ЕХ-ны “МУ-ын Стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгох” төслийн хүрээнд хүнс үйлдвэрлэгч, төрийн байгууллагуудын ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулсан
- Дархан-Уул аймагт хүнсний боловсруулах үйлдвэрлэлд эгзэгтэй цэгийн хяналт (НАССР), үйлдвэрийн эрүүл ахуйн зохистой дадал (GHP), үйлдвэрийн зохистой дадал (GMP) нэвтрүүлэх зорилгоор хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг 17 аж ахуйн нэгжийн технологичдыг Улаанбаатар хотын Атар өргөө, Траст, Бамбууш, Витафит, Мах маркет, Төв аймгийн Эрдэнэ зэрэг үйлдвэрүүдийн газруудын үйл ажиллагаатай танилцуулан, туршлага судлуулах аялалыг зохион байгуулсан.

ХШҮ-50%

Үйл ажиллагаа 8.5. Хүнсний боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд магадлан итгэмжлэл хийж зэрэглэл тогтоох.

Хүнсний боловсруулах үйлдвэрүүдэд аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (НАССР), Чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001), Хүнсний хэлхээний хяналтын тогтолцоо (ISO 22000)-г нэвтрүүлэхээр хүсэлт гаргасан аж ахуй нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Талх чихэр, Сtimo ХХК, Атар өргөө, Тесто, Сүү ХК зэрэг компанийн хүнсний үйлдвэрийн дотоод хяналтын лабораториуд ISO/IEC 17025 стандартын дагуу ур чадвараа тогтоолгон итгэмжлэгдсэн.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа аявуулж байгаа мал нядлах, мах боловсруулах 37 үйлдвэрийн техник технологи, мал эмнэлэг, ариун цэврийн байдалд хянан магадлагаа хийж зэрэглэл тогтоосон. Үүний дагуу “АА” зэрэглэл буюу импортлогч оронтой тохиролцсон нөхцлийн дагуу бүтээгдэхүүнийг зөвхөн тухайн оронд экспортлох эрхийг 30 үйлдвэрт олгож, дотоодын болон олон улсын зах зээлийн стандартын шаардлагыг хангасан мал нядлах, эхлэн боловсруулах 3, мах боловсруулах 4, нийт 7 үйлдвэрт “ААА” зэрэглэл тогтоов.

ОХУ-ын Мал эмнэлэг, ургамал хорио цээрийн хяналтын албанаас (Россельхознадзор) 2012 онд Монгол Улсын мал нядлах, мах боловсруулах 19 үйлдвэрт мал эмнэлэг ариун цэврийн хянан магадлагаа явуулж, үнэлэлт дүгнэлт өгсөн. Гаалийн Холбооны гишүүн орнуудын нутаг дэвсгэрт (ОХУ, Беларусь, Казахстан) малын гаралтай түүхий эд, мах экспортлох эрхийг манай улсын мал нядлах, мах боловсруулах 14 үйлдвэрт олгосон тухай 2013 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн ФС-ЕН-7/5415 тоот албан бичгийг монголын талд ирүүлсэн.

Мах, махан бүтээгдэхүүний боловсруулах чиглэлийн үйлдвэрүүдэд хянан магадлагааг ҮХААЯ, МЭҮГ, Махны холбоотой хамтран явуулж зэрэглэл тогтоох журам боловсруулж байна. ҮХААЯ-наас томилогдсон ажлын хэсэгтэй хамтран “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”, “Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрт хянан магадлагаа хийх журам”-ын төслийг боловсруулан ҮХААЯ-ны сайдын зөвлөлийн хуралд танилцуулан, Засгийн газрын хуралдаанд оруулахаар бэлтгэл ажил хангаад байна.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 8.6. Хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлын стандарт, техникийн нөхцөлийг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн шинэчлэх.

“Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан “Зайлшгүй хэрэглэх сав, баглаа, боодол болон шошголох түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголох тухай журам”-ыг боловсруулж, Үйлдвэр хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлуулсан.

Монгол Улсад мөрдөгдөж буй хүнстэй харьцах гадаргуу, хүнсний сав баглаа боодлын нийт 31 стандартад Шинжлэх ухаан техникийн үзлэг явуулж, дүгнэлт гарган Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. Витафит ХХК Хүнсний сав баглаа боодлыг шинжлэх лаборатори байгуулсан.

Хүнстэй харьцах гадаргуу, хүнсний сав баглаа боодлын материалын эрүүл ахуйд үнэлгээ хийх чиглэлээр зөвлөх үйлчилгээний тендер зохион байгуулахаар зардлыг 2014 оны төсөвт суулгасан. Хүнсний нийлэг сав баглаа боодол. Техникийн ерөнхий шаардлагыг батлуулсан.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 8.7. Түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх, борлуулах шат дамжлагад хөргүүртэй тоног төхөөрөмж ашигладаг нөхцөлийг бүрдүүлэх.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 3000 тн хүнсний ногооны зоорь, 10000 тн мах, махан бүтээгдэхүүний зориулалтын зоорь агуулах, хөргөлттэй тээврийн хэрэгсэл бүхий бөөний худалдааны төв байгуулахаар тендер зарлан сонгон шалгаруулалт хийсэн.

“Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэхэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэхээр заасан ба Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газраас тухайн төслөөр зоорь, худалдааны төв байгуулах газрын зөвшөөрлийн талаар тодруулга авч 33 аж ахуйн нэгжтэй бодлогын гэрээ байгуулж, төслийн санхүүжилтийг хийлгэх хүсэлтийг Монгол банкинд хүргүүлсэн. Үүнээс 23 аж ахуйн нэгжид харилцагч арилжааны банкуудаас нийт 74.9 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

Эдгээр зээл авсан төсөл хэрэгжсэнээр мах, махан бүтээгдэхүүний зоорь агуулах 19.5 мян тн-оор, төмс, хүнсний ногооны зоорь 66.5 мян тн-оор, худалдааны төвийн агуулахын багтаамж 6.0 мян тн-оор тус тус нэмэгдэх боломжтой боллоо. 7 аж ахуйн нэгж зоорь байгуулах ажлаа бүрэн дуусгасан, 6 аж ахуйн нэгж зоорь байгуулах ажлын 50-90 хувийн гүйцэтгэлтэй, 7 аж ахуйн нэгж 5-50 хүртэл хувийн гүйцэтгэлтэй, 5 аж ахуйн нэгж тайлан ирүүлээгүй байна.

ХШҮ-50%

Үйл ажиллагаа 8.8. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хадгалах хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг борлуулалтын сүлжээнээс буцаан татах, устгах журмыг боловсруулан хэрэгжүүлэх.

“Хүнсний туухий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам” Засгийн газрын 2013 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 172 дугаар тогтоолоор батлагдсан. Уг журмыг хэрэгжүүлэх талаар сургалтыг МХЕГ-аас зохион байгуулсан.

Журмыг хэрэгжүүлэх хүрээнд 2014 оны хяналт шалгалтаар улсын хэмжээнд нийт 2408.9 кг, 104.9 литр, 7324 ширхэг хүнсний бүтээгдэхүүнийг хурааж, 1768 кг бүтээгдэхүүнийг буцааж, 181 кг, 120 ширхэг бүтээгдэхүүнийг татан авахуулж, 2982.2 кг, 1061.3 литр, 4364 ширхэг хүнсний бүтээгдэхүүнийг акт тогтоон устгасан байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 8.9. Нийтийн хоолны үйлчилгээ, хүнсний худалдаа эрхлэгчид, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээл бэлтгэн нийлүүлэгчдийг эрүүл ахуйн зохистой дадал мөрдүүлэх сургалтад хамруулах.

Монгол хүний хоногийн хоол тэжээлийн физиологийн норм, зөв зохистой хооллолтын зөвлөмжийг үндэслэн 1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 228/А/365 тоот тушаалаар батлуулсан.

Кодексын үндэсний хорооноос баталсан “Нийтийн хоолны эрүүл ахуйн дадлын дүрэм” САС MNS стандартыг мөрдүүлж байна.

“Биотехнологи, микробиологи, хоол, хүнсний аюулгүй байдал” сэдвээр хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтын улсын байцаагчдыг мэргэшүүлэх 3 дахь шатны сургалтыг Монголын хоол зүйн технологичдын холбоотой хамтран зохион байгуулав.

“Хүчит шонхор” махны төрөлжсөн захын худалдагч нарт “Мах, махан бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, борлуулах явцад шаардлагатай эрүүл ахуйн нөхцөл” сэдвээр,

Жаргалант, Туул, Хонхор, Гачуурт тосгоноос сүү, сүүн бүтээгдэхүүн зөөвөрлөн борлуулагч нарт “Бусдын эрүүл мэнд танаас хамаарна”, “Гар тань цэвэр үү” зэрэг 20 удаагийн сургалтад 876 хүнийг хамруулан явуулж, 12 төрлийн 1351 танилцуулга, зөвлөмжийн материал тараасан.

Нийслэлийн 58 дугаар сургууль, Дархан хотын 10 жилийн сургуулийн цайны газруудад эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж, НАССР тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Баянхонгор, Завхан, Говьсүмбэр, Архангай, Өвөрхангай зэрэг аймгуудад “Тогоочид-Хоол үйлдвэрлэгчдийн” аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж, ажил мэргэжлийн уралдаан, нийтийн хоолны үйлчилгээ, хүнсний худалдаа эрхлэгч, сургууль, цэцэрлэгийн хүнс бэлтгэн нийлүүлэгчдийн эрүүл ахуйн зохистой дадал мөрдүүлэх, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний илчлэгийг тооцох арга сургалтуудыг зохион байгуулсан.

Монголын Мастер тогооч шалгаруулах уралдаан зохион байгуулсан.

МХЕГ-Зориулалтын бус ажлын байртай хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудад хяналт хийх удирдамж боловсруулан МХЕГ-ын даргын 2014 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01/100 дугаараар батлуулан аймаг, нийслэлийн МХГ-г хүргүүлэн хяналт шинжилгээний ажил 5 сараас эхлэн хийгдэж байна

Аймаг орон нутагт худалдаа, нийтийн хоол үйлдвэрлэлийн газруудад “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн зохистой дадал, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл нэвтрүүлэх” сургалтуудыг зохион байгуулсан. Тухайлбал: Арвайхээр, Хужирт, Хархорин сумдын хоол үйлдвэрлэлийн нийт 69 хүн, худалдааны төвийн 140 худалдаа эрхлэгч хамрагдсан.

Хоол тэжээлийн талаархи хүн амын боловсролыг дээшлүүлэх зорилгоор нийт 749 удаа сургалт хийж, 20197 хүнийг хамруулан, 80 төрлийн 20552 ширхэг сургалтын материал, ном тарааж, орон нутгийн 4 телевизэд 12 удаа мэдээлэл хийж, 3 төрлийн 160 ширхэг DVD, 26 төрлийн 700 ширхэг зурагт хуудас, сурталчилгаанд ашиглалаа.

Аймаг, нийслэлийн 9 дүүргийн нийт 156 ерөнхий боловсролын сургуулийн үдийн цайнд хоол бэлтгэх үйл ажиллагааг шалгалтанд хамруулж, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн 42 дүгнэлт хүргүүлсэн ба мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулсан /37 удаа/.

Аймаг орон нутагт сургууль, цэцэрлэгийн тогооч, нярав нарын сургалтыг зохион байгуулсан. Тухайлбал: Архангай, Орхон аймгийн сургууль, цэцэрлэгийн тогооч, нярав нар 60 хүн хамрагдсан.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 8.10. *Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг гарал үүсэл, эрүүл ахуйн баталгаа, хаяг, шошготойгоор зах зээлд нийлүүлэх ажлыг зохион байгуулах.*

Төмс, хүнсний ногоо, жимсний гарал үүсэл, эрүүл ахуй, ариун цэвэрт хяналт тавих зорилгоор импортын буудай, гурил, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнд шинжилгээ хийх хүнс, нян судал, ургамал, хорио цээрийн лаборатори “Барс” худалдааны төвд байгуулагдан ISO/IEC17025 стандартын дагуу итгэмжлэгдсэн.

Орон нутгаас ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэж зах зээлд худалдаалах үед ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн баталгаажуулалт хийх, гарал үүслийг тодорхойлох болон ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг хуваарилах, олгох, зарцуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг

зохицуулах зорилгоор “Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл-хорио цээрийн гэрчилгээ, түүнийг хэрэглэх журам”-ын төслийг боловсруулав.

“Мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн тухай журам”-ыг боловсруулж, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/98 дугаар тушаалаар батлуулсан.

Засгийн газрын 2013 оны 268 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, ногоочдын бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг борлуулалтыг дэмжих худалдааг нийслэлийн 6 дүүргийн 13 цэгт зохион байгуулав. Энэ арга хэмжээний хүрээнд 14 аймгийн 540 ногоочин 3 сарын хугацаагаар нийслэлд 1140 тн төмс, хүнсний ногоо, 2 тн зөгийн бал, 5.0 мянган ширхэг жимсний суулгац борлуулсан байна.

“Монгол төмс” хөтөлбөрийн хүрээнд тариалсан төмсийг “Органик төмс” шошготойгоор супермаркетаар борлуулж байна. “Эвридэй Ферм” ХХК япон технологиор гүзээлзгэнэ тариалж /5-11 сард ургац хураана/ сав баглаа боодол, шошготойгоор зах зээлд нийлүүлж байна.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 8.11. Хүнсний зориулалттай түүхий эд, бүтээгдэхүүнд хүнд металл, цацраг үүсгүүр, ургамал хамгааллын бодис, малын эм зэрэг бодисын үлдэгдлийн тандалт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулах, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах.

ҮХАА-н сайдын 2013 оны А/31 дүгээр тушаалаар “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэл болон пестицидийн үлдэгдэлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”-г тогтоосон. MNS 5076:2013, Малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд цацраг идэвхит элемент тодорхойлох Гамма спектрометрийн арга стандартыг шинэчлэн баталсан.

Хүнсний зориулалттай түүхий эд, бүтээгдэхүүнд хүнд металл, цацраг үүсгүүр, ургамал хамгааллын бодис, малын эм зэрэг бодисын үлдэгдлийг УМЭАЦТЛаборатори, Үндэсний лавлагаа лабораториуд тодорхойлох чадавхитай.

Лабораторийн мэргэжилтнүүдийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтад шат дараатай хамруулдаг.

ХШҮ-90%

Зорилт 9: Хүнсний чанар, аюулгүй байдлын хяналт, мэдээллийн сүлжээ, үйл ажиллагааг сайжруулах

Үйл ажиллагаа 9.1. Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний лабораториудад Монгол Улсын болон олон улсын стандарт нэвтрүүлж, зэрэглэл тогтоох.

Монгол Улсын үндэсний итгэмжлэлийн байгууллага Бүс нутаг, Олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон. Хүнс, малын тэжээлийн микробиологи. Усны идэвх тодорхойлох MNS ISO 21807:2012, Амьтан, ургамлын гаралтай тос-Тусгаарлагдсан хоёрчийн холбоо бүхий трансизомерийг нил улаан туяаны спектрометрээр тодорхойлох MNS ISO 13884:2012 стандартуудыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээний хүрээнд менежментийн тогтолцооны ISO/IEC 17025 стандартыг ишлэл болгон “Хүнсний захын лабораторит тавих нэмэлт шалгуур” баримт бичгийг боловсруулж гаргасан. Түүнчлэн “Химийн сорилтын лабораторит тавих итгэмжлэлийн шалгуур”, “Биологийн

сорилтын лабораторид тавих итгэмжлэлийн шалгуур” баримт бичгийг боловсруулж батлуулсан.

Хүнсний үйлдвэрлэлийн “Талх чихэр”, “Сtimo”ХХК, “Атар өргөө”, “Тесто”, “Сүү” ХК зэрэг компанийн үйлдвэрийн дотоод хяналтын лабораториуд болон МУИС, ШУТИС –ийн дэргэдэх сургалт, судалгааны лабораториуд ISO/IEC 17025 стандартын дагуу ур чадвараа тогтоолгон итгэмжлэгдсэн.

Стандарт хэмжил зүйн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх орон нутгийн сорилтын лабораториудыг Засгийн газрын 2012 оны 175 дугаар тогтоолоор “Нэг цэг”-ийн үйлчилгээнд шилжүүлэн нэгтгэсэн. Энэ лаборатори нь сүлжээ сорилтын лабораториудын ур чадварыг тогтоох, боловсон хүчнийг сургах, зөвлөмж, аргачлалыг баталгаажуулах, зарим нэг шинжилгээнд лавлагаа гаргах чиг үүрэгтэй ажиллаж байна.

2013 оны эхний хагас жилд МХЕГ-ын төв болон орон нутгийн харьяа 18, аймгуудын ҮХААГ-ын харьяа мал эмнэлгийн 13, бусад аж ахуйн нэгжийн харьяа 6 лабораторийг хими, нян судлалын шинжилгээний ур чадварыг сорих сорилт явуулсан.

2013 оны сүүлийн хагас жилд зохион байгуулсан ур чадварын сорилтын хөтөлбөрт МХЕГ-ын төв, орон нутгийн харьяа 22, аймгуудын ҮХААГ-ын харьяа мал эмнэлгийн 5, бусад аж ахуйн нэгжийн харьяа 7 лабораторийг оролцуулсан байна.

БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар дээр хэрэгжиж байгаа “Нэгдсэн төв лабораторийн барилга барих, техникийн чадавхи бэхжүүлэх” төслийн хүрээнд нэгдсэн лабораторийг ашиглалтад оруулж, Засгийн газрын тогтоолоор Үндэсний лавлагаа лаборатори болгож, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, эм, био бэлдмэл, ургамлын үр, хорио цээрийн лабораторийн нэгдсэн сүлжээг баталсан.

Хилийн боомт дахь лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хурдавчилсан шинжилгээний аргыг нэвтрүүлэх, итгэмжлэлд хамруулах чиглэлээр:

- Стандартчилал, хэмжил зүйн газрын итгэмжлэлийн үнэлгээний ажлын хэсэг 2012 оны 6 дугаар сарын 14,17-ны өдрүүдэд Замын-Үүдийн гаалийн боомт дахь салбар лабораторит ажиллаж, MNS ISO 17025 “Сорилтын болон калибровкийн лабораторит тавих техникийн шаардлага” стандартын хүрээнд үнэлгээ хийсэн. СХЗГ-ын техникийн зөвлөлийн 2012 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Замын үүдийн гаалийн боомтын салбар лабораторийг 2 жилийн хугацаатайгаар итгэмжилсэн.
- Дорнод аймаг дахь гаалийн боомтын лабораторийг итгэмжлүүлэх ажлыг СХЗГ-ын үнэлгээний ажлын хэсгийн хуваарьт оруулсан.
- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын лаборатори нь Стандартчилал, хэмжил зүйн газрын 2013 оны 6 дугаар сарын 28-ын техникийн хорооны хурлаар орж, 3 жилийн хугацаатайгаар итгэмжлэлийн эрхээ авсан. Бусад боомтын лабораториудын итгэмжлэлийн эрх хүчинтэй байгаа болно.

2014 оны жилийн эцсийн байдлаар СХЗГ-аас хүнсний салбарт 65 лаборатори итгэмжлэгдэн үйл ажиллагаа явуулж байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 9.2. *Хүнсний бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж зөвшөөрөл, тохирлын гэрчилгээтэй болгох замаар импортын хүнсэнд хяналт тавих.*

“Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын заалтыг үндэслэн

“Стратегийн хүнсийг экспортлох, импортлох нэр төрөл, тоо хэмжээг тогтоох, зөвшөөрөл олгох тухай журам”-ыг Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 77 дугаар тогтоолоор баталснаар стратегийн хүнсний бүтээгдэхүүнийг импортлоход аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах эрх зүйн орчин бүрдсэн.

Дээрх журмын дагуу “2014 оны эхний хагас жилд импортлох стратегийн зарим хүнсний тоо хэмжээг тогтоох тухай” Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2014 оны А/08, А/16, А/35 тушаал болон “2014 оны хоёрдугаар хагас жилд импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоох тухай” Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2014 оны А/72 дугаар тушаалыг батлуулан, сонгон шалгаруулалтыг явуулж, стратегийн хүнсний экспорт импортын зөвшөөрлийг олголоо.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 9.3. Түргэн муудах хүнсний бүтээгдэхүүний импортын талаар экспортлогч оронтой байгуулсан гэрээ, хэлцлийг олон улсын жишигт нийцүүлэн хянах, шинэчлэх асуудлыг судалж хэрэгжүүлэх.

Хүнсний тухай хуулийн дагуу Стратегийн хүнсийг экспортлох, импортлох нэр төрөл, тоо хэмжээг тогтоох, зөвшөөрөл олгох тухай журам”-ыг Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 77 дугаар тогтоолоор баталснаар стратегийн хүнсний бүтээгдэхүүнийг импортлоход аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах эрх зүйн орчин бүрдсэн. Энэхүү журмын дагуу хүнсний бүтээгдэхүүнийг импортолж байна.

Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газрын хооронд “Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг Монгол Улс, БНХАУ-д экспортолж, импортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцлийн тухай” протоколын хүрээнд БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газрын төлөөлөгчид Монгол Улсын 17 үйлдвэрт эрсдлийн үнэлгээг хийж ажилласан.

Гаалийн холбооны улсын мал эмнэлгийн шинжээчид мах экспортлох хүсэлт гаргасан (12) мал нядлах, мах боловсруулах үйлдвэрт хянан магадлагааг явуулж, мал эмнэлэг, төв, орон нутгийн байгууллага, мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаатай танилцаж, “Преком” ХХК, “Эрдмийт” ХХК-ууд шалгуурт тэнцэж, бусад үйлдвэрт санал, зөвлөмж хүргүүлсэн. Зөрчил, дутагдлыг арилгасан тухай МХЕГ-ийн Улсын байцаагчийн дүгнэлт, холбогдох материалыг нэгтгэн ОХУ-ын Мал эмнэлэг, ургамал хорио цээрийн хяналтын албанд (Россельхознадзор) тоот албан бичгээр хүргүүлсэн.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 9.4. Генийн өөрчлөлт бүхий хүнсний бүтээгдэхүүнд эрсдлийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг тогтоож мөрдүүлэх.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны дэргэд “Биоаюулгүй байдлын үндэсний хороо”-ны генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүний лаборатори 2011 онд байгуулагдсан. “Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдлийг үнэлэх, бүртгэх журам”-ын төслийг боловсруулан холбогдох саналуудыг оруулж байна.

Хүн амд зориулсан ухуулга сурталчилгаа хийж 3 төрлийн баримтат киног монгол хэл рүү орчуулан Like HD телевизээр цацсан, уг 3 киног DVD-д хуулбарлан олшруулж сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргэх ажлыг зохион байгуулж байна

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн “Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн” гэсэн 14 дүгээр зүйлд

хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих хяналт, зохицуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн. Энэ хуулийн 14.1-т “Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг эрүүл мэнд, хүнсний болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч хэлэлцүүлэг зохион байгуулсан.

“Хувиргасан амьд организмыг лабораторит тодорхойлох, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн менежмент” сэдэвт үндэсний хэмжээний сургалтыг зохион байгуулж, эрсдэлийн үнэлгээний анхан шатны ойлголтуудыг эзэмшсэн 45 мэргэжлийн экспертийг бэлтгэсэн. Хувиргасан амьд организм түүнээс гаралтай хүнсний бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийж илрүүлэх ISO, CAC, Европын Холбооны гишүүн улс орнуудад мөрдөж байгаа 16 стандартыг үндэсний стандарт болгох ажлыг хийгдсэн. Үүнд:

- Декомбинат - ДНХ бүхий бичил биетэн ашиглан үйлдвэрлэсэн хүнсний аюулгүй байдлын удирдамж CAC/GL 46-2003;
- Рекомбинант - ДНХ бүхий амьтнаас гарган авсан хүнсний эрсдэлийн үнэлгээний удирдамж CAC/GL 68-2008;
- Орчин үеийн Биотехнологийн аргаар гаргаж авсан хүнсний бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээг хийх зарчмууд CAC/GL 44-2003;
- Рекомбинант - ДНХ бүхий ургамлуудаас гарган авсан хүнсний эрсдэлийн үнэлгээний удирдамж CAC/GL 45-2003;
- Европын Зөвлөлийн Журам №619/2011 Зөвшөөрөл нь хараахан шийдэгдээгүй, зөвшөөрлийн хугацаа дууссан малын тэжээлд шилжмэл генийн материал байгаа эсэхэд хяналт тавих албан ёсны хяналтын дээж авалт ба шинжилгээний аргууд;
- Хүнсний бүтээгдэхүүн - Хувиргасан амьд организм, түүний гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний аргууд - Нуклейн хүчлийн тоонд суурилсан аргууд ISO 21570:2005(E);
- Хүнсний бүтээгдэхүүн - Хувиргасан амьд организм, түүний гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний аргууд - Уурагт суурилсан арга ISO 21572;
- Хүнсний бүтээгдэхүүн - Хувиргасан амьд организм, түүний гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний аргууд - Үндсэн шаардлага, ухагдахуун ISO 24276:2006(E);
- Хүнсний бүтээгдэхүүн - Хувиргасан амьд организм, түүний гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний аргууд - ISO 21569, ISO 21570, ISO 21571-ын стандартад шаардлагатай мэдээлэл, нэмэлт аргачлал ISO TS21098;
- Хувиргасан бичил биетнүүдийн хязгаарлагдмал хэрэглээний тухай. Европын Парламент ба Зөвлөлийн Тогтоол 2009/41/ЕЗ;
- Хувиргасан амьд организмаас гаралтай хүнс ба малын тэжээлийн тухай Европын Парламент ба Зөвлөлийн Журам (ЕЗ) Ио 1829/2003;
- Хувиргасан амьд организмыг хүрээлэн буй орчинд чөлөөлөх тухай удирдамж 90/220/ЕЕС;
- Генетик инженерчлэлийн ба генетик инженерчлэлийн бус бүтээгдэхүүнүүд Хүнсийг Сайн Дураар Шошгожуулах ба Сурталчлах CAN/CGSB-32.315-2004;

Биоаюулгүй байдлын чадавхийг сайжруулах төслийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулсан.

“Полимеразын гинжин урвал ашиглан GT 73 сортын генийн өөрчлөлттэй рапсыг илрүүлэх арга” стандарт ажиллагааны заавар, MNS ISO 21570:2013 Хүнсний бүтээгдэхүүн - Хувиргасан амьдорган-Нуклейн хүчилд суурилсан тоон тодорхойлолтын арга, MNS ISO 21572:2013, Хүнсний бүтээгдэхүүн - Хувиргасан амьд организм, түүнээс гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний арга–Уурагтсуурилсан арга, MNS ISO 24276:2013, Хүнсний бүтээгдэхүүн - Хувиргасан амьдорган, түүний гаралтай бүтээгдэхүүнийг таньж илрүүлэх шинжилгээний арга. Ерөнхий шаардлага ба тодорхойлолт зэрэг стандартуудыг тус тус боловсруулан батлуулсан.

XIIIY-90%

Зорилт 10: Ундны усны хүртээмж, чанар, аюулгүй байдлыг сайжруулах:

УИХ-ын 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор “Ус” үндэсний хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөрт тусгагдсан стратегийн 6 зорилтод чиглэсэн хоёр үе шаттай 122 бүлэг арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж байна. Усны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуулиудыг УИХ-ын чуулганы 2012 оны 5 дугаар сарын 17- ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан. Засгийн газрын 2012 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар “Монгол улсын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн зааг”-ийг тогтоосон. Усны экологи, эдийн засгийн үнэлгээний төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж баталгаажуулсан.

Үйл ажиллагаа 10.1. Хүн амын ундны усны хэрэгцээнд тохиромжгүй усыг цэнгэгжүүлэх технологи боловсруулж нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

“Ус бохирдуулсаны төлбөрийн тухай” хуульд бохирдуулагч нь төлбөр төлөхөөр тусгасан ба хаягдал усыг усны чанарын стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэсэн хэмжээгээр, хаягдал усыг цэвэрлэж, эргүүлэн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан бол дахин ашигласан хэмжээгээр төлбөрөөс чөлөөлж, хөнгөлөхөөр тусгасан .

Шинжлэх ухаан технологийн "Усыг эргүүлэн ашиглах" төслийн хүрээнд нанотехнологи нэвтрүүлэн Туул гол руу орж байгаа бохир усыг бүрэн цэвэршүүлэх зорилгоор туршилт явуулж, Туул голын усны чанартай ойролцоо хэмжээнд цэвэршүүлсэн байна. Үүний үр дүнд жилд 73 сая шоометр бохир ус Туул гол руу цутгахгүй болж, энэ хэмжээний цэвэр усаар Туул голыг сэлбэх боломж бүрдэх юм.

Төв цэвэрлэх байгууламжаас хагас боловсруулж Туул голд хаяж байгаа бохир усанд БНСУ-ын “Барбендро” технологиор гүн цэвэршүүлэлт хийж эргүүлэн ашиглах зорилгоор хоногт 200 000 м³ бохир ус цэвэршүүлэх хүчин чадал бүхий бохир усны гүн цэвэрлэх байгууламж бүхий үйлдвэр барих төслийн урьдчилсан судалгаа, төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлын ерөнхий үнэлгээ хийгдсэн. Үүний дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийж байна.

Ус хангамжийн хөгжлийн томоохон төслийг хандивлагч орны буцалтгүй тусламж, гадаадын хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлж байна. Тухайлбал, Чехийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Хөвсгөл аймгийн Мөрөн сумын усан хангамжийг сайжруулах ажлыг /1,2 сая ам.доллар/ эхлүүлсэн. Австралийн Засгийн газраас өмнөд говийн бүсийн усан хангамжийн судалгааны ажлыг хийхэд зориулсан 7.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийг Дэлхийн банкаар дамжуулан хэрэгжүүлэхээр хэлцэл хийгдсэн.

НҮБ-ын Ази-Номхон далайн бүсийн нийгэм, эдийн засгийн комиссын буцалтгүй тусламжаар БНСУ-ын “Синопекс” ХХК-ийн ус цэвэршүүлэх явуулын төхөөрөмжийг турших ажлыг Дорноговь аймгийн Өргөн суманд эхлүүлсэн. Энэхүү төхөөрөмжийг турших ажлын үр дүнг нягтлан үзэж, цаашид усны чанар хангалтгүй гэж үздэг 100 гаруй суманд тус төхөөрөмжийг эсвэл суурин цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Өвөрхангайн Баян-Өндөр, Төгрөг, Богд сумдад шинээр 3 гүний худаг баригдсан. Богд, Уянга, Баян-Өндөр, Төгрөг, Сант, Тарагт сумын 3 худагт цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулж, 7 гүний худаг, голын эхийг хашиж хамгаалалтын бүс тогтоосон. Азийн хөгжлийн банкны Мон-2301 “Тэр хорооллын усан хангамжийг сайжруулах” төслөөр 18 ус түгээх байр шинээр баригдаж ашиглалтанд орсноор хүн амын 60 хувийг төвлөрсөн системд холбогдсон ундны усаар хангаж эхэлсэн.

Дорнод аймгийн 10 сумын ус магни ихтэй, 7 сумын ус эрдэсжилт ихтэй, 3 сумын ус хатуулаг ихтэй байдаг. Тус аймгийн Чулуунхороот, Сэргэлэн, Матад, Цагаан-Овоо сумдын төвийн усан хангамжийн гүн өрмийн худгуудын цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмжүүд ажиллаж байна. 2014 онд Хөлөнбуйр, Баянтүмэн, Дашбалбар Халх гол сумын төв, Халх гол сумын Ялалт баг, Халх гол суман дах Хилийн цэргийн 0198-р анги зэрэг унд, ахуйн зориулалтаар ашиглаж буй гүн өрмийн худгуудад цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулсан. Чойбалсан сум 2013 онд суурилуулсан ус цэвэршүүлэх төхөөрөмжөө улам сайжуулж нэмэлт цэнгэгжүүлэх төхөөрөмжийг орон нутгийн төсвийн 26 сая.төг-өөр суурилуулж сум орон нутгийн иргэдийг эрүүл, аюулгүй ундны усаар хангаж өгсөн байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 10.2. *Усны нөөц хомс бүс нутгуудад цас, борооны усыг нөөцлөх сан байгуулж, хүн амын хэрэгцээ, мал аж ахуй, газар тариаланд ашиглах.*

Байгаль хамгаалах сангийн зардлаар 2012 онд цас, борооны усыг нөөцөлж мал, амьтны хэрэгцээг хангах хөв цөөрмийг:

- Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Ямаат залаат;
- Нийслэлийн Хан-Уул дүүргийн Түргэний гол;
- Дархан-Уул аймгийн Орхон сумын Шарын голд,
- Завхан аймгийн Алдархаан сумын Ямаатын сайрт
- Цагаанчулуут сумын Жавцагын гол
- Баянхонгор аймгийн Заг сумын Сүүжийн булагт
- Хэнтий Дархан сумын хөв
- Өвөрхангай аймгийн Өлзийт сумын Ар булаг
- Дорнод аймгийн Гурванзагал сумын Сайхан булгийн хөв зэрэг газарт байгуулсан.

2013 онд Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Завхан, Улаанбаатар хотод барих 15 хөв цөөрмийн зураг төслийг хийлгэсэн. Үерийн ус, цас борооны ус ашиглан усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх технологийг нэвтрүүлэх, зураг төсөл боловсруулах, бохир усыг эргүүлэн ашиглах технологийг судалж байна. Говьсүмбэр аймагт цас борооны ус нөөцлөх зориулалттай 1200 куб. метр багтаамж бүхий 2 сан байгуулагдсан.

Баянхонгор аймгийн Жаргалант суманд “Сум хөгжүүлэх сан”-гийн хөрөнгөөр Хамтын хүч нөхөрлөл “Ногоон толгой”-д 30х20 хэмжээтэй 1.8 м-ийн гүнтэй 18.0 мян.м³ эзэлхүүнтэй хиймэл цөөрөм байгуулан, 10 га талбайд төмс, хүнсний ногоо тариалан усалгаандаа ашиглаж 10 өрх амьжиргаагаа дээшлүүлсэн байна. Мөн аймгийн Заг сумын

“Сүүж”-д хөв байгуулах ажлыг 2010 оноос эхлэн энэ жил хийгдэж дууссан боловч зургийн дагуу хийгдээгүй гэж үзэн улсын комисс ашиглалтанд хүлээж аваагүй байна.

Говь-Алтай аймагт улсын төсвийн хөрөнгөөр Цогт сумын Тоонотын хоолойд хөв байгуулах ажлын гүйцэтгэгчээр ”Мөнхтооройт” ХХК шалгарч, БОНХЯ болон Говь-Алтай аймгийн Засаг даргатай гурвалсан гэрээ байгуулан гүйцэтгэлээ. Усан сангийн ашигтай эзлэхүүн нь 3346.0 м³, усан сангийн талбай 2895.5 м², усан сангийн усны гүн 3.5 м, боомтын урт 58.2 м, боомтын хярын өргөн 1.5 м, ус хаях байгууламж (автомат хаюур) өргөн 4.88 м, сувгийн өндөр 0.5 м, зарцуулга 1.1 м³/с байгааг газар дээр нь тогтоон хүлээн авч ашиглалтанд орууллаа. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө /51.2 сая.төг/-өөр Алтай сумд 1 хөв, “Зах зээл ба Бэлчээрийн менежмент” буюу IFAD төслөөр Цогт сумын Баян-Улаан багт Хуурай сайрт /42 сая.төг/ 1, Алтай сумын Бадрал багт Цахирын эхэнд /38 сая.төг/ 1 хөв байгуулсан байна.

Дорнод аймгийн Дашбалбар сумын “Нил өндөр” гэдэг газарт хөв цөөрөм байгуулах зураг төсөл хийгдсэн. 2014 онд 95 сая.төгрөгийн хөрөнгөөр хөв цөөрөм байгуулах ажил хийгдэхээр төлөвлөсөн хэдий ч ИТХТэргүүлэгчдийн хурлаас 4, 10-р багуудын нутагт хөрсний эвдрэлээс хамгаалах суваг шуудуу татаж, ус зайлуулах далан суваг байгуулах ажил гэж нэрийг өөрчилж баталсан.

“Дэлгэрэх гол” төслийн хүрээнд Өвөрхангай аймагт 260.0 сая.төгрөгийн өртөгтэй 53732.0 м³ ус хуримтлуулах хүчин чадалтай хөвийг “Онги-Ээж” ХХК хийж гүйцэтгэлээ. Хөвийн далангийн суурийн урт 84.3 м, хамгийн их өргөн нь 63 м, хярын өргөн нь 3 м, өндөр нь 11.6 м, автомат ус хаях суваг нь 94.97 м урттай усны барилга байгууламжийг байгуулсанаар үерийн эрчмийг бууруулж, Дэлгэрэх голын тэжээгдлийг нэмэгдүүлээ.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 10.3. Хөдөөгийн хүн амын ундны усны эх үүсвэрүүдэд шинжилгээ хийж, усны эх үүсвэрийн дэргэд түүний чанарын талаар анхааруулах тэмдэгтэй болгох арга хэмжээ авах.

Аймаг орон нутагт анхааруулах тэмдэг байрлуулах ажил хийгдэж байна. Дорноговь аймгийн сумдын унд, ахуйн усны эх үүсвэрийн 60 орчим хувь нь ариун цэврийн хамгаалалтын бүстэй болсон. Өвөрхангай аймгийн Баянгол, Баян-Өндөр сумд 5 булаг шандны усанд хамгаалалтын бүс тогтоосон байна. Улсын хэмжээнд 2013 онд нийт 1108 худаг, үүнээс инженерийн хийцтэй 438 худгийг хөдөөгийн хүн ам, мал сүргийн усан хангамжинд зохиулан гаргасан бөгөөд энэ ажлын үр дүнд 5.5 мянган малчин өрх, 3.1 сая мал сүргийг ундны усны эх үүсвэрээр шинээр хангах боломж бүрдсэн. 2014 онд инжежрийн хийцтэй 430 худаг, энгийн болон уурхайн нийт 1128 худгийг ашиглалтад оруулсан.

Завхан аймгийн Шилүүстэй суманд ДЗОУБ-ын Завхан ОНХХ-ийн хөрөнгө оруулалтаар 80.0 сая төгрөгний өртөг бүхий ундны усыг зөөвөрлөх цистерин машин нийлүүлсэн. Архангай аймгийн төвийн гүний худгийн барилга байгууламжинд /орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр/ их засвар хийж, төмөргүйжүүлэх төхөөрөмжийг тавьсан байна. Баянхонгор аймаг усны эх үүсвэр, булагийн эхийг хамгаалалттай болгож, анхааруулах тэмдэгтэй болгосон. Усны тухай хуулийн дагуу усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой (усны сан бүхий газрын эргээс 50 м-ээс доошгүй зайд болон гол мөрний татамд) болон энгийн хамгаалалт (усны сан бүхий газрын эргээс 200 м-ээс доошгүй зайд)-ын, эрүүл ахуйн бүс (ус хангамжийн эх үүсвэрээс 100 м-ээс доошгүй зайд)

тогтоохоор хуульд заасан холбогдох журам, дэглэмийг БОНХАЖЯ, БХБЯ хамтран шинэчлэн боловсруулж батлуулахаар ажиллаж байна.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 10.4. *Хөдөөгийн хүн амын унданд хэрэглэж байгаа усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, бохирдлоос хамгаалах, мал, амьтан услах цэгүүдийг хүний унданд хэрэглэдэг худаг, булаг, шандаас зайдуу болгон тусгаарлах.*

2012 онд 145 булгийн эхийг хашиж хамгаалахад 290.0 сая төгрөг төлөвлөж, аймаг, нийслэлийн БОАЖГ-уудаар хариуцан гүйцэтгүүлэв. Нийт ундны ус эх үүсвэрийн 70%-ийг хамгаалалттай болгосон.

Зарим аймаг, сумын төв, жижиг хот, суурингийн газрын дорхи унд ахуйн 84 эх үүсвэрийн тэжээлийн мужийн зургийг гаргаж, эрүүл ахуйн хамгаалалтын III бүсийн дотор газар шорооны болон уул уурхайн ажил, барилга байгууламж барихыг болон усан хангамжид ашиглагдаж байгаа уст давхаргын газрын дорхи усыг бохирдуулах ямар нэгэн ажиллагаа явуулахыг хориглох, энэхүү бүсийг заавал тодорхойлж байх, хамгаалалтад авах, бохирдлоос сэргийлэх тухай зөвлөмжийг орон нутагт хүргүүлсэн байна.

БОНХЯ-наас 2013 онд улсын болон орон нутгийн хөрөнгөөр 16 аймгийн 186, улсын хэмжээнд нийт 1716 булаг шандын эхийг хашиж хамгаалаад байна.

Архангай аймагт “Эзэнтэй монгол” хөтөлбөр, нийтийг хамарсан ажлын хүрээнд аймгийн төв болон сумдын гүний худгийн 68.1 хувьд нь нь эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоон хашаажуулж, энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлсэн байна.

Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 59 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хийсэн ажлын явцын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулж, зөвлөмж боловсруулах үүрэг өгөгдсөний дагуу 315 сумын 856 худгийн эрүүл ахуйн нөхцөл, усны аюулгүй байдлыг хангуулах талаар 38 хуудас бүхий зөвлөмж боловсруулж, ЗГХЭГ-аас аймаг, нийслэлийн Засаг дарга нарт (2014.02.14-ны өдрийн 1/268) албан бичиг хүргүүлсэн.

Баянхонгор аймгийн хэмжээнд ус хангамжийн эх үүсвэр, усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтэнд аймгийн мэргэжлийн хяналтын эрүүл ахуйн байцаагч, сав газрын захиргаатай хамтран хяналт шалгалт хийн ажиллаж байна. Сумдын усан хангамжийн эх үүсвэрт тогтоосон эрүүл ахуйн бүс нь хуульд заагдсан хэмжээндээ хүрэхгүй, дэглэм нь мөрдөгдөхгүй байх явдал байна.

Булган аймгийн хувьд ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлсний дүнд аливаа зөрчил гараагүй байна.

Говь-Алтай аймаг ил задгай ус ашигладаг 1 сум, ил задгай болон худгийн ус ашигладаг 3 сум, энгийн гар худаг, өрөмдмөл худгийн ус ашигладаг 16 сум сууринтай. Гадаргын ус унд, ахуйдаа хэрэглэж буй сумдын усны ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас сэргийлэх зорилгоор усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн зааг, дэглэмийг тогтоон тэмдэгжүүлэхээр Халиун, Тайшир, Тонхил сумдад байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал 6 сая төгрөгөөр энгийн хамгаалалын бүс тогтоож, тэмдэгжүүлэн загон татах ажлыг Тонхил сумын Зүйлийн гол, Тайшир сумын Завхан гол, Халиун сумын Халиун голуудын нөлөөлөлд өртдөг хэсгүүдэд тус бүр 3 нийт 9 самбар байршуулан, гол тус бүр дээр 3 км нийт 9 км газарт гортиг татах ажлыг “Эрхэм таван оргил” хоршоо гүйцэтгэж дууссаныг хүлээн авлаа.

Дорнод аймаг хүн амын усан хангамжийн эх үүсвэр 98 усны сан бүхий газар, 18 худгийг орон нутгийн хамгаалалтанд авсан бөгөөд 86 усны сан бүхий газар, 6 худгийг орон нутгийн хамгаалалтанд авсан. Хөлөнбуйр, Цагаан овоо, Чулуунхороот, Сэргэлэн, Дашбалбар, Халхгол сум, Чойбалсан сумын төвийн ундны усны худгуудын эрүүл ахуйн бүсийг тогтоон орон нутгийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэн хашаажуулсан байна. Цагаан-Овоо, Чулуунхороот, Сэргэлэн, Дашбалбар, Чойбалсан, Гурванзагал, Хөлөнбуйр, Булган сумын төвийн ундны усны худгуудын эрүүл ахуйн бүсийг тогтоон орон нутгийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэн хашаажуулсан.

Завхан аймаг төв суурин газрын ус хангамжийн эх үүсвэр болон усан сангуудад эрүүл ахуйн бүсийн дэглэм, ундны усны эрүүл ахуйн шаардлагуудыг иргэдэд сурталчилж ажилласан. 2014 онд БОГ, МХГ, ХНЗГСГЗ, “Амь-ус трейд” ХХК-иуд хамтран ус ашиглаж буй аж ахуй нэгжүүдийн ус ашиглалтын байдалд 4 дүгээр сарын 7-оос 12 хүртэл үзлэг шалгалт хийж, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх талаар мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Аймгийн төвийн усан хангамжинд ашиглагдаж буй усан хангамжийн эх үүсвэр тус бүрд эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоогоогүй байсан тул албан шаардлага тавьж хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Орхон аймаг хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг тогтоож, Дотоодын цэргийн хамгаалалттай ажиллуулж байна.

Төв аймаг хот, суурины хүн амын ус хангамжийн хамгаалалтын болон, эрүүл ахуйн бүсийг нарийвчлан тогтоож, дэглэмийг мөрдүүлэх ажлыг эрчимжүүлж аймгийн хэмжээнд хүн амын ус хангамжийн зориулалтаар ашиглаж буй уст цэгийн хамгаалтын бүсийг бүрэн тогтоож, эрүүл ахуйн бүсийн хэмжээнд хашаажуулсан байна.

ХШҮ-90 %

Үйл ажиллагаа 10.5. *Хүн амын ундны усны эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглох үйл ажиллагааг судалж, холбогдох хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх.*

Усны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуулиудыг УИХ-ын чуулганы 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан.

Засгийн газрын 2012 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагийг баталсанаар хамгаалалтын бүсэд хайгуул, ашиглалт явуулахыг хориглосон эрх зүйн үндэс бүрдсэн.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 22.3-т заасан хамгаалалтын бүсэд хамаарч байгаа хайгуулын 1007, ашиглалтын 488 тусгай зөвшөөрлийн жагсаалтыг гаргаж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 34 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэгт хүргүүлсэн.

ХШҮ-100%

Үйл ажиллагаа 10.6. *Усаар дамжин халдварлах өвчний тандалт хийх судалгаа, мэдээллийг сайжруулах.*

Ундны усны эх үүсвэрийн байршлын судалгааг тухайн орон нутгийн хэмжээнд гаргаж, мэргэжлийн хяналтын байгууллагаас “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 900:2005” стандартын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2012 онд хөдөөгийн хүн амын ундны усны чанар, аюулгүй байдалд хийсэн шинжилгээтэй хяналт шалгалтад 237 сумын 327 худаг хамрагдсан. Хөдөөгийн хүн амын ундны усны зориулалттай гүний худгийн усанд хийсэн шинжилгээгээр Говь-Алтай аймгийн Баян-Уул, Жаргалан, Тайшир, Хөхморьт, Цогт, Ёсөнбулаг, Сүхбаатар аймгийн Асгат, Завхан аймгийн Нөмрөг, Идэр, Тосонцэнгэл, Алдархаан, Түдэвтэй, Тэс, Отгон, Асгат, Цагаанхайрхан, Дорнод аймгийн Цагаан овоо, Эрэнцав, Халх гол зэрэг сумдын усанд магни, Дундговь аймгийн Хулд, Эрдэнэдалай, Дэлгэрхангай сумын усанд эрдэсжилт, Луус сумын усанд эрдэсжилт, хлорид, Өмнөговь аймгийн Цогтцэций, Баяндалай сумын усанд фтор, Манлай, Цогтцэций сумын усанд хатуулаг, кальци, хлорид стандартад заасан норм хэмжээнээс их, нийт худгийн 16.7 хувь нь нянгийн тоогоор хэвийн хэмжээнээс их гэсэн дүн гарсан байна.

Усны нөөц, чанарын хяналт-шинжилгээний иж бүрэн хөтөлбөр боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А-27 тоот тушаалаар баталсан.

Дундговь аймгийн Мандалговь хотын усан хангамжийн I худагт газрын дорхи усны хяналт-шинжилгээний автомат төхөөрөмж суурилуулж, хөдөлгөөнт болон суурин холбооны орчин үеийн технологийг ашиглан мэдээлэл, өгөгдлийг дамжуулах, хяналтын төв байгуулах гэрээг БНСУ-ын “Ора холдинг” ХХК-тай байгуулсан. Хяналтын цооногийн мэдээлэл, өгөгдлийг дамжуулах, хүлээн авах, боловсруулах орчин үеийн техник хэрэгсэлийг усны газарт суурилуулсан.

2012 оны улсын төсөвт орон нутгийн нийтийн аж ахуйн цэвэр, бохир усны лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэхэд зориулж 375.0 сая төгрөг тусган батлуулж, тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэх тендер зарлан, гүйцэтгүүлсэн.

Архангай аймагт усаар дамжин халдварлах өвчний тохиолдол гаргахгүйн тулд усны шинжилгээг “Ундарга” ХХК улирал тутам, мэргэжлийн хяналтын газар хөндлөнгийн хяналтын шинжилгээг 6 сар тутам, байгалийн голомтот халдварт өвчин судлалын газар жил тутам ус, хоол хүнсээр дамжин халдварлаж болох холерийн үүсгэгч илрүүлэх шинжилгээг жил бүр хоол хүнс, ус бусад зүйлээс 30 орчим сорьц авч хийдэг. Энэ шинжилгээг 2013 онд Цэнхэр, Эрдэнэбулган суманд хийхэд “сөрөг” гэсэн хариу гарсан байна. Аймгийн ус цэвэрлэх байгууламжийг 2014 онд шинэчлэх санхүүжилтийн асуудал шийдэгдсэн. Ус хангамжийн байгууллагын ажилтнуудад усаар дамжин халдварлах өвчний талаар 2 удаа сургалт зохион байгуулж, 3 төрлийн 66 ширхэг гарын авлага материал бэлтгэж тараасан байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 75 дугаар Захирамжаар баталсан “Усны үндэсний хорооны дүрэм”-д “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-г боловсруулж батлуулахаар заасан байдаг. “Шийдлийн” Засгийн газар Үндэсний хорооны Ажлын албыг татан буулгаад чиг үүргийг нь БОНХАЖЯ-нд шилжүүлээд байна.

2013 онд Усны үндэсний хороо удирдан зохион байгуулж, БОНХЯ, ЭМЯ, БХБЯ, Туул голын сав газрын захиргаа, НЭМҮТ, УСУГ, МХЕГ-тай хамтран “Унд ахуйн усны аюулгүй байдлын талаар хууль тогтоомж, бодлогын баримт бичигт оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулах ажил”-ыг эхлүүлсэн бөгөөд 7 хууль, 1 үзэл баримтлал, хөтөлбөр, төлөвлөгөө, стандартын хүрээнд үнэлгээ өгч ажилласан. Ундны усны стандартыг шинэчлэх болон “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-ний төлөв байдлын эмхэтгэлийн төслийг боловсруулах ажлыг эхлүүлсэн.

“Жижиг суурин газрын ус хангамжийн усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах нь” гарын авлагыг зураг, дүрслэлийг Монгол Улсад хэрэгжсэн туршлага,

жишээгээр илэрхийлэн тайлбарлан нэмэлт өөрчлөн хийж, хэвлүүлэх ажлыг ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр ТББ-аар хийлгүүлэхээр ДЭМБ-д санал хүргүүлээд байна.

Улаанбаатар хотын хүн амын усны аюулгүй байдлыг хангах хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нийслэлийн ИТХ-ын 2014.09.22-ны өдрийн 19/22 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Мөн Дорноговь аймгийн Сайшанд сум ДЭМБ-ын, Архангай аймгийн Эрдэнэбулган сум Дэлхийн зөн олон улсын байгууллагын, Хөвсгөл аймгийн 10 гаруй сум Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Хүн амын усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-гөө батлан хэрэгжүүлж байгаа. Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг орон нутагт өргөжүүлэх, тогтвортой байдлыг хангах үүднээс багийн бүрэлдэхүүнийг чадавхжуулах зорилгоор БХБЯ, НЭМС, МХЕГ-тай хамтран 9, 10, 11 сард 3 удаагийн сургалтыг хамтран зохион байгуулсан. Сургалтад аймгуудийн ЗД-ын орлогч, ус хангагч байгууллагын дарга, инженер, МХГ-ын улсын байцаагч болон Дорноговь аймгийн 14 сумын ЗД-ын орлогч, Сумын ЭМТ-ийн НЭМ-ийн мэргэжилтэн, Байгаль орчны байцаагч зэрэг 200 хүнийг хамруулсан.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын ЭМТ-ийн УАБТ-ний төсөл боловсруулах ажлыг 2014.12.04-ний өдөр МХЕГ, УСУГ, ЭМГ-тай хамтран хийж, төлөвлөгөөг боловсруулах үйл явцыг баримтуулан бигино хэмжээний дүрс бичлэг хийх ажлын агуулгыг гаргаж, сумын Иргэдийн төлөөлөгч, ЭМТ-ийн удирдлага, ажилтан зэрэг 20 орчин хүнд мэдээлэл хийж танилцуулсан.

Усаар дамжин халдварлах өвчний танадалт судалгаа хийх боловсон хүчин бэлтгэх ажлын талаар нэгдсэн дүн, мэдээлэл гаргаагүй байна.

ХШҮ-70%

Зорилт-11: Монгол хүний зохистой хооллолтын зөвлөмжийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, хоол тэжээлийн талаарх хүн амын боловсролыг дээшлүүлэх:

Үйл ажиллагаа 11.1. Хүн амын насны онцлог, хүйсийн ялгааг харгалзан хоол тэжээлийн сургалтын хөтөлбөр, стандарт бий болгож, сургагч багш, сайн дурын ажилтан бэлтгэх.

Аймаг, орон нутгийн хэмжээнд хүн амын хоол тэжээл, зохистой хооллолтын чиглэлээр Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал, хэмжил зүйн газар, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн алба, Мерси кор Олон улсын байгууллагуудтай хамтран “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл мэнд”, “Эрүүл хүнс- Жаргалтай амьдрал”, “Зөв зохистой хооллолт” зэрэг сэдвүүдээр 70 гаруй удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 8200 гаруй сургууль, цэцэрлэг, иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөл хамрагдсан. Нийгмийн эрүүл мэндийн “Хоол судлал” сургалтын хөтөлбөр батлагдаж, эрүүл мэндийн чиглэлээр сургалт явуулдаг сургуулиудад хоол тэжээлийн хичээл заадаг 25 хүнийг сургагч багшаар бэлтгэж, гэрчилгээ олгосон. Орхон аймагт эрүүл мэндийн газрын дэргэдэх сургалтын танхимыг түшиглэн 2013 онд зөв хооллолтын сургагч багш бэлтгэх сургалтыг 4 удаа 50 хүнийг хамруулан зохион байгуулсан. Өрхийн эрүүл мэндийн төвүүд 31 удаа хоол тэжээлийн боловсрол олгох сургалт явуулж, 317 хүнийг хамруулан давхардсан тоогоор 48 төрлийн 948 ширхэг сургалтын материалыг түгээсэн байна.

Архангай, Дархан-Уул, Дорноговь, Хөвсгөл аймагт зохистой хооллолтын сургалтыг нийт 14 удаа 1051 хүнийг хамруулан зохион байгуулсан байна. Нийслэлийн Эрүүл мэндийн газраас “Хамт олон бүх нийтээрээ жин хасах” 6 сарын аян, “Эрүүл зөв хоолыг эрхэмлэгч ресторан” 5 сарын аян зохион байгуулж, “Зохистой хооллолтын дэмжигч” байгууллага, хамт олон, засаг захиргааны нэгж, өрхийг шалгаруулсан байна.

Зохистой хооллолтын мэдлэгийг дээшлүүлэх, оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдалтай хобоотой заавар, журам” эмхтгэл гаргасан. “Хүнсний үйлдвэрлэл, эрүүл ахуйн зохистой дадлыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх зөвлөмж”-ийг хэвлэж, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, архи үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүд болон ЭМШУИС-д тус тус хүргүүлсэн. 2013 онд Эрүүл мэндийн яамнаас хүн амын хоол тэжээлийн сургалт, хүүхдийг зөв хооллох чиглэлээр 20 сургагч багшийг сургалтанд хамруулж бэлтгэсэн.

Олон нийтэд түшиглэсэн нялхас, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө” өгөх сургагч багш бэлдэх сургалтыг Хөвсгөл аймаг, Налайх дүүрэгт зохион байгуулсан.

"Бага насны хүүхдийн өсөлт хөгжлийн байдлыг хянах, мэдээллэх, үнэлэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулсан. “Монгол хүүхдийн хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ”-г Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалаар батлуулсан.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 11.2. Хот, хөдөөгийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагыг түшиглэн зохистой хооллолтыг дэмжих танхим бий болгож, байнгын сургалт явуулах.

Архангай, Сүхбаатар, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Ховд, Өмнөговь аймаг, Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт хүүхдийн сувиллын цэцэрлэг, хоол тэжээлийн боловсрол олгох сургалтын танхимтай болж, тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Архангай аймагт 8 сум, 3 өрхийн эрүүл мэндийн төвд зохистой хооллолтын зөвлөгөө өгөх, дадлагажуулах танхим ажиллуулж, “Дэлхийн Зөн” ОУБ-ын дэмжлэгээр 16 сая төгрөгийн үнэ бүхий гал тогооны хэрэгсэлтэй болсон байна.

Дорноговь, Өвөрхангай аймагт “Идэвхитэй амьдралын хэв маяг” сургалтад 282 хүнийг хамруулсан байна. Сүхбаатар аймагт Мянганы сорилтын сангийн эрүүл мэндийн төслийн хүрээнд архи, тамхинаас сэргийлэх, хөдөлгөөн, зөв хооллолтын талаар 8 удаагийн аян зохион байгуулсан. Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын зохистой хооллолтын танхим нь тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ХААН Банк, Дархан ТИС-ийн хүнсний тэнхим, Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн албатай хамтран “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих” үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, аж ахуйн нэгж байгууллагын тогооч, ажиллагсдад зориулсан “Эрүүл мэнд, идэвхтэй хөдөлгөөн”, “Эрүүл хүнс, зохистой хооллолт” сэдвүүдээр 17 удаа сургалт зохион байгуулж, 1404 иргэнийг хамруулсан байна. Өмнөговь аймагт хүн амын зохистой хооллолтыг дэмжих үйл ажиллагаа тогтмолжсон бөгөөд Мянганы сорилтын сангаас “Эрүүл ажлын байр” сэдвээр 20 гаруй байгууллагын 400 гаруй ажилтанд сургалт хийж, орон нутгийн телевиз, радиогоор 45 цагийн мэдээлэл хийсэн байна.

ЭМЯ-аас Солонгосын WITH ТББ-тай хамтран 2014 онд Сонгинохайрхан эрүүл мэндийн нэгдэлд Зохистой хооллолтын кабинетийг нээж ажиллуулсан.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 11.3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон хувийн хэвилийн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн дунд зохистой хооллолтыг дэмжих хөдөлгөөн, санаачилга өрнүүлж урамиуулан дэмжих.

Зохистой хооллолтыг дэмжих ажлын хүрээнд ДЭМБ, Мянганы Сорилтын сангийн санхүүжилтээр “Монгол хүний давсны хэрэглээ ” судалгааг үргэлжлүүлэн, статистик

боловсруулалт хийсэн. Мөн “Халдварт бус өвчний мэдлэг, хандлага, дадал”-ын үндэсний судалгаа хийгдсэн.

“Давсны илүүдэл хэрэглээг бууруулах дэлхийн 7 хоног, “Иод дутлын эмгэгтэй тэмцэх өдөр”, “Хөхөөр хооллолтын 7 хоног”-ийг тэмдэглэн өнгөрүүлсний зэрэгцээ халдварт бус өвчинтэй тэмцэх 3 сарын компанит ажлыг үр дүнтэй зохион байгуулав.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яамнаас “Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдалтай холбоотой тушаал, заавар, журмын эмхэтгэл” 500 ширхэгийг хэвлүүлсэний дотор “Хүнсний үйлдвэрлэл, эрүүл ахуйн зохистой дадлыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх зөвлөмж”-ийг нийтэлж хүргүүлсэн.

Бүх аймаг орон нутагт эрүүл мэндийн довтолгоо хөдөлгөөн өрнүүлж, “Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл”, “Эрүүл зохистой хооллолт”, “Заавал хэвшүүлэх 21 дадал” зохистой хооллолтын суралт, сурталчилгаа зохион байгуулж, мэдээллийн сувгаар төрөл бүрийн байдлаар сургалт, сурталчилгаа явуулж байна. Тухайлбал: “Хүнсний аюулгүй байдал, Зохистой хооллолт” сэдвээр Орхон аймгийн ЕБС, цэцэрлэгийн эмч, нярав, үдийн цай хариуцдаг аж ахуй нэгжүүдийн эздэд 5 хоногийн сургалт /70 хүн/, Сэлэнгэ аймгийн сургууль цэцэрлэгийн тогооч, няравуудад “Хүнсний аюулгүй байдал, Зохистой хооллолт” сэдвээр 3 хоногийн сургалт /70 хүн/ зохион байгуулсан.

Эрүүл мэндийн довтолгоо аяныг 2014 онд улсын хэмжээнд зохион байгуулж иргэн бүрт чиглэсэн эрүүл мэндийн зөв хэвшил төлөвшүүлэх, сургалт, сурталчилгаа эрүүл мэндийн боловсрол олгох талаар төлөвлөгөө боловсруулан “Заавар хэвшүүлэх 21 дадал”-д “Зохистой зөв хооллолт нь эрүүл саруул, урт удаан наслахыг эрмэлздэг хүн бүрийн эрхэмлэн хэрэгжүүлэх дадал мөн” гэж тусган хэрэгжүүлж байна.

XIIIY-90%

Үйл ажиллагаа 11.4. *Хоол судлалын чиглэлийн судалгаа, эрдэм шинжилгээний болон мэдээлэл боловсруулах ажлыг төрөөс дэмжих.*

Дархан-Уул аймаг дахь “Бүс нутгийн хүнс судлалын төв” нь 2009 онд хүнсний ногоо нөөшлөх цех, 2010 онд талх, нарийн боов үйлдвэрлэх цех, 2011 онд хагас боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цехийг тус тус байгуулсан байна. Тус төв нь 2013 онд хүнсний мөөг ургуулах технологийн судалгаа хийсэн бөгөөд одоо хүнсний шинэ технологи боловсруулах, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр судалгаа хийж байгаагийн зэрэгцээ 25 байгууллагад 11 төрлийн сэдвээр 29 удаагийн сургалт явуулж, 2895 хүнийг хамруулснаар малын гаралтай өөх тос болон давс, сахарын хэрэглээг багасгаж, жимс, хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэх, зохистой хооллох, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгох, эрүүл аргаар хоол, хүнсээ бэлтгэх мэдлэг хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлсэн байна. Цаашид үйл ажиллагааг нь өргөжүүлж, хоол судлалын чиглэлээр ажиллуулах боломжтой.

Орхон аймагт хоолны илчлэг болон тэжээллэг чанарт үнэлгээ өгөх зорилгоор сар бүр хүүхдийн хоолонд олгож буй хоол үйлдвэрлэлд зарцуулагдсан хүнсний бүтээгдэхүүний орцод тооцооны аргаар судалгаа хийж, дундажийг гарган цэцэрлэгийн эмч нарт зөвлөмж өгсөн байна.

Судалгаагаар гарсан 2013 оны эхний 5 сарын дундаж үзүүлэлтийг II хагасын дундаж үзүүлэлттэй харьцуулж үзэхэд:

🚦 Төсвийн зардлаар ажилладаг цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны өдрийн дундаж илчлэг 1227 ккал, өөх тос 35 гр, уураг 53 гр, нүүрс ус 172 гр, кальци 278гр, төмөр 6.5 гр, витамин С 100 гр байгаа нь шаардагдах илчлэгийн 97 хувийг, өөх тосны 88 хувийг, кальцийн 43 хувийг, А аминдэмийн 22 хувийг хангасан бол уураг, нүүрс

ус, төмөр, витамин С-г 100 хувь хангаж байна. 2013 оны II хагас жилд илчлэгийн хангамж 8 хувиар, өөх тосны хангамж 7 хувиар, төмрийн хангамж 7 хувиар тус тус буурсан байна.

✚ Хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны илчлэг 1598 ккал, өөх тос 50 гр, уураг 65 гр, нүүрс ус 280 гр, кальци 349, төмөр 9 гр, витамин С 75 гр, А аминдэм 320 мг байгаа нь шаардагдах илчлэг, өөх тос, уураг, нүүрс ус, төмөр, витамин С-г 100 хувь, кальцийн 58,0 хувийг хангасан байна. Хүүхдийн хоолны чанар, хүртээмж сайн байгаа боловч хоол хүнсэнд нүүрс усны хэмжээ хэт ихэссэнээс илчлэг илүүдсэн, цагаан идээ, нарийн ногооны хэрэглээ хангалтгүй байгаагаас кальци, А аминдэмийн дутагдалтай гэсэн дүгнэлт гарсан.

✚ Цэцэрлэгийн хүүхдийн тэжээллэг хоол хүнсний хэрэглээг тогтоох зорилгоор 20 цэцэрлэгийн 352 хүүхдийн эх эцэг, асран хамгаалагч нараас асуумж судалгаа авсан. Судалгаанд хамрагдсан хүүхдийн 1,4 хувь нь гэртээ хариад идэх хоол байхгүй гэсэн дүн гарсан байна. 2-6 насны хүүхэд өдөр бүр 1-2 нэгж сүү цагаан идээ, 1-2 нэгж жимс жимсгэнэ идэх ёстой гэж үзвэл, нийт хүүхдийн 11,0 хувь нь жимсийг 1 нэгжээр, 32 хувь нь сүү цагаан идээг 1,5 нэгжээр хэрэглэж байна. Нийт хүүхдийн 89 хувь нь жимс жимсгэнийг, 68 хувь нь сүү цагаан идээг хангалтгүй хэрэглэж байна.

Сүү, цагаан идээ, жимс жимсгэний хэрэглээ гэр хорооллын болон орон сууцанд амьдардаг хүүхдийн хувьд статистикийн ялгаагүй байгаа боловч орон сууцанд амьдардаг хүүхдүүд арай олон давтамжтай хэрэглэж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Цэцэрлэгийн насны хүүхэд өдөрт 3-аас доошгүй удаа гурилан бүтээгдэхүүнээр хооллож байна.

XIIIY-70%

Зорилт- 12: Хоол тэжээлтэй холбоотой өвчин, эмгэгээс сэргийлэх, хяналт тавих:

2014 онд улсын хэмжээнд хоол хүнстэй холбоотой 10 дэгдэлт бүртгэгдсэн бөгөөд 766 хүн өртсөн байна. Эдгээрийн 7 тохиолдол нь хоолны хордлогот халдвар, 2 нь цусан суулга, 1 нь нянгийн бус хордлогот халдвар гэж оношлогджээ.

Үйл ажиллагаа 12.1. Хүүхдийг 6 сар хүртэл нь эхийн сүүгээр дагнан хооллож, цаашид нэмэгдэл хоолонд оруулан хоёр нас хүртэл нь эхийн сүү хөхүүлэхийг бүх талаар урамшуулан сурталчлах.

2012 оны 8 дугаар сард “Хөхөөр хооллолтыг дэмжин өнгөрүүлсэн 10 жил” үндэсний долоо хоногийн арга хэмжээг тэмдэглэн, төв хөдөөд, сургалт сурталчилгааны ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулсан.

“Эхийн сүүгээр хооллохыг дэмжих” дэлхийн 7 хоногийн өдрөөр бүх эрүүл мэндийн байгууллагууд хөхөөр хооллолтын талаар сургалт сурталчилгааны ажлуудыг хийж 2560 гаруй иргэдийг хамруулсан байна. Нийт аймгийн дүнгээр хүүхдийн хооллолтын талаархи сургалт сурталчилгаанд 14520 эцэг эх, иргэдийг хамруулсан байна. Эхийн сүүгээр дагнан хооллолт 13,0 хувиар нэмэгдэж, хүүхдийн хоол тэжээлтэй холбоотой өвчлөлийн тохиолдлууд 2,7 хувиар буурсан үзүүлэлт гарсан байна.

Архангай аймагт 2013 онд хийгдсэн судалгаанд хамрагдсан хүүхдийн дунд 2 нас хүртлэх эхийн сүүгээр хооллолт 92.7%, 6 сар хүртлэх эхийн сүүгээр хооллолт маш бага буюу 69.6 % байв. Дорноговь, Хэнтий аймагт хөхөөр хооллолт, хөхний сүүний ач холбогдлын талаар нийт 44 удаа сургалтыг зохион байгуулж 2203 хүнийг хамруулсан байна.

Хоёр нас хүртэл нь эхийн сүүгээр бойжуулсан хүүхдийн тоог 2012 оны судалгаагаар 66% нь эхийн сүүгээр бойжуулж байна. Олон нийтэд түшиглэсэн нялхас, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө” өгөх сургагч багш бэлдэх сургалтыг 2014 онд Хөвсгөл аймаг, Налайх дүүрэгт зохион байгуулсан.

“Бага насны хүүхдийн өсөлт хөгжлийн байдлыг хянах, мэдээллэх, үнэлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлуулсан.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 12.2. Хот, суурин газруудад тураал, цус багадалт, рахит зэрэг хоол тэжээлийн дуталтай хүүхдийг эмчлэх сувиллын газар, мөн эмчилгээний болон бага насны хүүхдийн нэмэгдэл хоол үйлдвэрлэх үйлдвэр, цех бий болгох зэргээр хүнсний тэжээллэг чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог сайжруулах.

2010 онд хийгдсэн “Монголын хүн амын хоол тэжээлийн байдал” IV судалгааны дүнг III судалгааны дүнтэй харьцуулахад тав хүртэлх насны хүүхдийн дунд Д аминдэмийн дутал 20 орчим хувиар буурсан, уураг илчлэгийн дутал буураагүй, харин 7-11 насны хүүхдийн бахлуур өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 4 дахин буурсан, жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах цус багадалт өмнөх судалгааны дүнтэй адил түвшинд байсан байна.

2011- 2012 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн хоол судлалын төв хамтран Сонгинохайрхан дүүргийн хүүхдийн клиник сувилалд хоол тэжээлийн архаг дуталтай 1-3 насны 123 хүүхдийг сонгон хоол эмчилгээ, чийрэгжүүлэлт, аминдэм эмчилгээг эрчимтэй хийсэн байна. Сувилалын хугацаанд хүүхдүүдийн орчны сонирхол харьцаа сайжирч, хөдөлгөөний идэвхи нэмэгдэж, хоолны ширээнд хамт олноороо зөв сууж, өөрсдөө хооллох чадвартай болсон. Дээрх арга хэмжээний хүрээнд хоол тэжээлийн эмгэгтэй хүүхдүүдийг сувилалын нөхцөлд эрүүлжүүлэх аргачилсан зөвлөмж гаргасан.

2013 онд Азийн хөгжлийн банкны “Бага насны хүүхдийн хоол тэжээлийн архаг дутлыг бууруулах” (JFPR 9131) төслийн хүрээнд хатаасан хүнсний ногоо боловсруулах үйлдвэрлэл, сүүг Д аминдэмээр баяжуулах ГУМ үйлдвэр, Хүнс тех корпорацид малын дэлүүгээр хүүхдийн нэмэгдэл тэжээл бэлдэх зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн. ГовьАлтай, Дундговь аймаг болон нийслэлийн 41 дүгээр яслийг түшиглэн хоол тэжээлийн дуталтай хүүхдүүдийг сувилалд хамруулсан. Дорноговь аймгийн Айраг, Хатанбулаг, Эрдэнэ, Сайхандулаан, Зүүнбаян сумдад гэр сувилал ажиллуулж, 6-59 сартай 137 хүүхдэд үйлчилсэн байна.

Хот суурин газрын ойролцоо эрүүл агаарт нялх, нярай болон тураал, сульдаа, цус багадалттай хүүхдүүдийг хүлээн авч чийрэгжүүлэх, сувилах сувилалын газрууд нээгдэн үйл ажиллагаа явуулж байна.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 12.3. Бага насны хүүхдийн өсөлт, хөгжлийг тогтоосон хугацаанд нь өрхийн эмч нар хэмжих, мэдээлэх, түүний мөрөөр эмчлэн сувилах ажлыг сайжруулж, өсөлт хөгжилтийн үндэсний мэдээллийн сан бүрдүүлэх.

“Эрүүл хүүхэд” аяны нээлт 2012 оны 3 дугаар сарын 19-ний өдөр болж, үзлэгт хамрагдвал зохих 976941 хүүхдээс 816941 хүүхэд буюу 83.6 хувь нь хамрагдаж, мэдээллийн санд 796680 хүүхдийн 97.5 хувь нь бүртгэгдсэн байна. “Эрүүл хүүхэд” аяны

үр дүнд Монгол Улс 0-18 хүртлэх насны бүх хүүхдийн эрүүл мэндийн цахим мэдээллийн сантай болж, мэдээллийн санг Засгийн газарт хүлээлгэн өгөх арга хэмжээг 2012 оны 7 дугаар сарын 25-ны өдөр Эрүүл мэндийн яаман дээр зохион байгуулсан.

Цахим мэдээллийн сангийн программыг боловсруулах, эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн болон программ хангамжийн ажилтнуудыг сургах, дадлагажуулах, маягт боловсруулж бэлтгэх зэрэг ажлыг аяны үзлэгтэй зэрэгцүүлэн эхлүүлсэн. Түүнчлэн эрүүл мэндийн үзлэгийн мэдээллийг тусгай маягт, мэдээллийн урсгалын бүдүүвчийн дагуу аймаг орон нутаг, нийслэлийн дүүргүүдээс өдөр бүр 16.00-17.00 цагт [eruulhuuhed2012 @yahoo.com](mailto:eruulhuuhed2012@yahoo.com) цахим хаягаар хүлээн авч, сар сарын тайланг нэгтгэн мэдээллийн санд оруулж байна.

XIIIY-100%

Үйл ажиллагаа 12.4. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон коллеж, их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дэргэдэх хоолны газарт чанартай, аюулгүй хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлэх үйлдвэр, үйлчилгээний газар, цэгийг шалгаруулж, байнгын хяналт тавьж ажиллах.

Хоол үйлдвэрлэлийн салбарт мөрдөгдөж байгаа стандартуудад үзлэг шалгалт явуулж, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх арга хэмжээ авч ажилласан.

Дор дурдсан стандартуудыг батлан мөрдөж байна. Үүнд:

- Хоолны газрын нийтлэг журам: 2010 он;
- Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Хоолны газрын ангилал, зэрэглэл. Ерөнхий шаардлага Монгол Улсын стандарт. Дугаар: MNS 4946:2005;
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал: Монгол Улсын стандарт. Дугаар: MNS CAC RCP 39: 2009;
- Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг. Техникийн ерөнхий шаардлага: Монгол Улсын стандарт. Дугаар: MNS 6192 : 2010;
- Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал: Монгол Улсын стандарт. Дугаар: MNS CAC RCP 39- 2011;
- Гадна талбайд хоол хүнс бэлтгэх, борлуулах эрүүл ахуйн дадлын дүрэм: Монгол Улсын стандарт. Дугаар: MNS CAC RCP 43 – 2011.

Аймаг орон нутагт ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн “Үдийн цай”-нд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулж ажиллуулсан.

“Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд 2012 онд хийсэн үзлэг шалгалтад хамрагдсан гурилан бүтээгдэхүүний 51 үйлдвэрийн 28 нь буюу 54,9% бага эрсдэлтэй, 20 нь буюу 39,2% нь дунд эрсдэлтэй, 3 нь буюу 5,9% нь их эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан байна. ЕБС-ийн 249 цайны газрын 36,9%-ийг бага, 51,0 %-ийг дунд, 12%-ийг их эрсдэлтэй гэж үзсэн байна. “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмын хэрэгжилт 71,4% байгаа нь 2010-2011 оны хичээлийн жилийнхээс 7,3%-иар дээшилсэн байна. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг 2012 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс 50 хувиар нэмж 1100 төгрөг байсныг 1600 төгрөг болгосон бөгөөд МХЕГ-ын 2013 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд хяналт шалгалтыг хийхэд Ерөнхий боловсролын сургуулиудын үдийн цайнд бүтээгдэхүүн нийлүүлж буй үйлдвэрүүдэд “Хүнсний тухай”, ”Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн хэрэгжилт дунджаар 68.6%-тай, “Ариун цэврийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн хэрэгжилт 73.5 хувь, хүүхэд өсвөр үеийнхний сургалт хүмүүжлийн байгууллагын

үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуйн үлгэрчилсэн дүрмийн хэрэгжилт 57.9 хувь, “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журмын хэрэгжилт 74.5 хувьтай байна. Шалгалтанд хамрагдсан 139 сургуулийг эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудсаар үнэлэхэд 40 хувь нь бага, 51.4 хувь нь дунд, 7.8 хувь нь их эрсдэлтэй үнэлэгдсэн байна. 2013 онд улсын хэмжээнд 760 гаруй ерөнхий боловсролын сургуулийн 1-5 ангийн 270 мянган хүүхэд “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж, хөтөлбөрийн зардалд 18,5 тэрбум төгрөг зарцуулсан.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хоол үйлдвэрлэлийн салбарт мөрдөгдөж байгаа стандартуудад шинжлэх ухаан техникийн үзлэг явуулж, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх арга хэмжээг авч ажилласан.

Нийт 30 стандартаас олон улсын 14, бүс нутгийн 3, гадаад орны 5, үндэсний 8 стандарт байна. Эдгээр стандартыг хөгжүүлж цаашид олон улсын 19, бүс нутгийн 3, гадаад орны 1 стандарт болгох санал боловсруулсан байна. Эдгээр 30 стандартаас хэвээр мөрдөх 11, дахин хянах 15, хүчингүй болгох 4 байгаагийн зэрэгцээ 34 стандартыг шинээр боловсруулах шаардлагатай.

- Аймаг, нийслэлийн 9 дүүргийн нийт 156 ерөнхий боловсролын сургуулийн үдийн цайнд хоол бэлтгэх үйл ажиллагааг шалгалтанд хамруулж, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн 42 дүгнэлт хүргүүлсэн ба мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулсан /37 удаа/.
- Аймаг орон нутагт сургууль, цэцэрлэгийн тогооч, нярав нарын сургалтыг зохион байгуулсан. Тухайлбал: Архангай, Орхон аймгийн сургууль, цэцэрлэгийн тогооч, нярав нар 60 хүн хамрагдсан.

ХШҮ-90%

Үйл ажиллагаа 12.5. Сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийн хүрээнд олгож байгаа хүнсний тэжээллэг чанар, аюулгүй байдлыг сайжруулж 60-аас доошгүй хувьд сүү, цагаан идээ хэрэглэдэг болох.

“Хүүхэд бүрт нэг аяга сүү” аяныг Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Ховд, Орхон, Хөвсгөл аймгууд жил бүр зохион байгуулж хэвшсэн байна. Дархан, Говь-алтай аймагт үдийн цайны 60-аас доошгүй хувьд сүү, цагаан идээ олгодог болсон байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/447 тоот тушаалаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургуулиудын дэргэдэх хоолны газруудад үнэлгээ өгөх ажлын хэсэг байгуулж ажиллуулсан.

Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Хоолны зардлын дундаж норматив батлах тухай 106 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлыг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 600 (зургаан зуун) төгрөгөөр, цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 (нэг мянга зургаан зуун тавин) төгрөгөөр, 24 цагаар ажилладаг цэцэрлэг, сувиллын болон тусгай цэцэрлэгт 2400 (хоёр мянга дөрвөн зуун) төгрөгөөр Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 2315 (хоёр мянга гурван зуун арван таван) төгрөгөөр тус тус тогтоосон.

“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт 2013 оны байдлаар 82.2% -ийн биелэлттэй байна. Улсын хэмжээнд төрийн өмчийн болон хувийн нийт 756 дунд сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдүүдэд долоо хоногийн 2 өдөр халуун хоол(бууз, хуушуур, бантан, каш аарц), 3 өдөр хуурай хүнс(булчик, печень гэх мэт), 150 гр сүү, тараг дагалдуулан өгч байна.

2014 онд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын гал тогооны тоног төхөөрөмжийн хангалт, хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүний татан авалт, хэрэглээний судалгаа авсан. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын хүүхдийн хоол хүнсний хангамж үйлчилгээний судалгаанд 470 ЕБС, 324 дотуур байр, 710 цэцэрлэг хамрагдсан. Судалгаанд хамрагдсан ЕБС, дотуур байр цэцэрлэгүүд сүү сүүн бүтээгдэхүүний 40-50%-ийг кампани, 20-25% нь хувь хүн, мах махан бүтээгдэхүүний 19-23% кампани, 15-25% хувь хүн, 13-29% нь малчин, Гурил, будааны 52-63% кампани, 4-13% нь хүнсний зах, 7-13% нь хоршоолол, Төмс хүнсний ногоог 27-43% нь кампани, 9-26% нь хүнсний зах зэрэг газруудаас долоо хоногт 2-3 удаа татан авалт хийж байна.

ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАГЧДЫН ТОО, САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭ

Хичээлийн жил	Анги	Нэг хүүхдийн хоолны зардал /төгрөгөөр/	Хамрагдсан хүүхдийн тоо	Санхүүжилт /тэрбум төгрөгөөр/
2007-2008	I-IV	400	187863	16.5
2008-2009	I-V	400	252600	18.5
2009-2010	I-V	400	280407	19.1
2010-2011	I-V	400	265700	16.1
2011-2012	I-V	400	256 584	17.5
2012-2013	I-V	400/600	255988	19.4
2013-2014	I-V	600	239289	24
2014-2015	I-V	600	251203	24.1

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 12.6. Шар сүү, жимс, жимсгэнэ, шар буурцаг арвай, хөх тариа, хивэг, дотор мах зэрэг уураг, аминдэм, эрдэс бодисоор баялаг түүхий эдээр тусгай зориулалтын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бичил бодисын дуталд өртөмтгий бүлгийн хүн амыг хангахад төрөөс дэмжлэг үзүүлэх.

Сургууль, цэцэрлэг, эмнэлэг (сувилал), зэвсэгт хүчний хүнсэнд баяжуулсан бүтээгдэхүүн, жимс, ногооны хэрэглээ шаардлага нэмэгдэж байгааг харгалзан “Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын 8 дугаар зүйлд хүүхдийн хоол тэжээл болон органик хүнсний үйлвэрлэлд болон хүний бие махбодийг бүхэлд нь, эсхүл тодорхой эрхтэний үйл ажиллагааг дэмжих шаардлагатай бодис, илчлэгийг нөхөх үйлчилгээ бүхий биологийн идэвхт бодис, баяжуулсан, ашигтай бичил биетэн агуулсан зохицуулах үйлчилгээтэй хүнсний үйлдвэрлэлд төрөөс дэмжлэг, урамшуулал үзүүлэх тухай заалтууд тусгагдсан.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 12.7. Аминдэм, эрдсийн бэлдмэл нийлүүлэгчийг тогтоож, нэн тэргүүнд бага насны хүүхэд, хөхүүл болон жирэмсэн эмэгтэйчүүдийн эрэлт хэрэгцээг тогтвортой хангах арга хэмжээ авах.

Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор "ГУМ" ХХК "Баяжуулсан сүү үйлдвэрлэж, Д амин дэмийн дутлыг бууруулах" төсөл (40,000 ам доллар) хэрэгжүүлж байна.

Улсын төсвийн санхүүжилтээр өндөр тунт А, Д аминдэмийг ханган нийлүүлж, хөхүүл, бага насны хүүхдэд үнэ төлбөргүй олгож байгаагийн зэрэгцээ Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, "Дэлхийн зөн Монголд" ОУБ-тай хамтран ОНБТБ/Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл/-ийг үндэсний хэмжээнд 6-23 сартай хүүхэд, хөхүүл болон жирэмсэн эхчүүдэд түгээж байна.

"Хүнсний аюулгүй байдал", "Сүү", "Чацаргана" хөтөлбөрийн хүрээнд сүү, сүүн бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалагчдыг бодлогоор дэмжиж ажиллав. Аймгуудын Засаг даргын тамгын газартай хамтран үдийн цайнд нийлүүлэх бүтээгдэхүүнийг сонгож гэрээ хийсний үндсэн дээр чацаргана, төрөл бүрийн жимсний шүүс, сүү, халуун аарц, тараг зэрэг бүтээгдэхүүнээр бага ангийн сурагчдад үйлчилсэн.

"Хүүхэд бүрт аяга сүү" аяныг Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Ховд, Орхон, Хөвсгөл зэрэг аймгууд сайн зохион байгуулсан.

Хүнсний тухай хуулийн 5.1 дэх заалтын хүрээнд "Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг тогтоох тухай" Эрүүл мэндийн сайдын 2013 оны 108 тоот тушаал гарган хэрэгжүүлж байна.

2013-2016 онд 6-59 сартай хүүхдэд олгох ОНБТ /олон найрлагат бичил тэжээл/-ийн захиалга, санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөөг болон ОНБТ-ийн зөвлөмж, хэмжээ, зааврыг тус тус боловсруулж батлуулсан.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 369 дугаар тушаалын дагуу 2013-2014 онд бага насны хүүхдэд уулгах өндөр тунт А, Д аминдэм, 6-23 сартай хүүхдэд түгээх ОНБТ-ийн бэлдмэлийг орон нутагт хуваарилсан. Өндөр тунт А, Д аминдэмийн зааврыг шинэчлэн боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2013 оны 470 дугаар тушаалаар батлуулсан.

2013 онд ОНБТ-ийн бэлдмэлтэй холбогдох зардлыг 2014 оны улсын төсөвт суулгах асуудал дэмжигдээгүй.

ЭМС-ын 2014 оны 11 сарын 07-ны өдрийн 382 тоот тушаалаар "Өндөр тунт А, Д аминдэм, олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг түгээх хуваарь" батлуулж, 21аймаг, 9 дүүрэгт түгээсэн.

Эрүүл мэндийн сайдын 470 дугаар тушаалын дагуу бага насны хүүхдийг А, Д аминдэм, олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлээр хангах ажлыг зохион байгуулж, тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн ЭМГ-т нэмэлт заавар бүхий албан тоот хүргүүлсэн.

"Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг түгээх хуваарийг батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2014 оны 111 дугаар тушаалыг боловсруулан батлуулсан.

Өндөр тунт А, Д аминдэмийг ханган нийлүүлэх байгуулагыг тодруулах тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж, сонгон шалгаруулалтыг хийсэн. А, Д аминдэмийг үндэсний түвшинд Эрүүл мэндийн сайдын 2014 оны 382 дугаар тушаалын дагуу түгээсэн болно.

Дэлхийн зөн" ОУБ-ын төслийн хүрээнд 16 аймгийн 6-23 сартай хүүхдүүдэд ОНБТ-ийн бэлдмэлийг түгээж байна. Мөн НҮБ-ын ХС-ийн төслийн хүрээнд Хөвсгөл аймаг, Налайх дүүргийн 6-23 сартай хүүхдүүдэд ОНБТ-ийн бэлдмэлийг түгээж байна.

XIIIY-90%

Үйл ажиллагаа 12.8. *Халдварт бус архаг өвчнөөс сэргийлэх, хянах" II шатны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.*

"Халдварт бус архаг өвчнөөс сэргийлэх, хянах" II шатны хөтөлбөрийн төслийг боловсруулж дуусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.

ХШҮ-50%

Зорилт- 13: Зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх:

Үйл ажиллагаа 13.1. *Баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний талаар баримтлах бодлого боловсруулан хэрэгжүүлж, үйлдвэрлэл, хэрэглээ, үр дүнг хянах, мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах.*

Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулгын 16.2-т заасны дагуу “Баяжуулагч бэлдмэл, нэмэлт, цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах тухай журам”-ын төслийг боловсруулж, түүнд Монгол улсад үйлдвэрлэсэн болон импортолсон органик хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг тусгасан. Баяжуулсан хүнсний хэрэглээг сурталчлахын зэрэгцээ баяжуулсан хүнсний хангамж, хэрэглээнд хяналт тавин ажиллаж байна. Иоджуулсан давс, баяжуулсан гурилын хэрэглээг сурталчлах 10 хоногийн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, энэ үеэр хийгдсэн 10 удаагийн сургалтад нийт 4451 хүнийг хамруулж, 837 ширхэг сурталчилгааны материалыг түгээсэн.

“Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ҮХААЯ-ны ТНБД-ын 2014 оны А/170 дугаар тушаалаар байгуулсан.

ХШҮ-50%

Үйл ажиллагаа 13.2. *Хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулах бичил бодисын импортыг нэмэгдүүлж, баяжуулсан хүнсээр дотоодын зах зээлийг хангаж, хүн амын дунд зохистой дадал төлөвшүүлэх замаар баяжуулсан хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх.*

“Хүнсний тухай” хуулийн 8.1.4-т “хүний бие махбодийг бүхэлд нь, эсхүл тодорхой эрхтэний үйл ажиллагааг дэмжих шаардлагатай бодис, илчлэгийг нөхөх үйлчилгээ бүхий биологийн идэвхт бодис, баяжуулсан, ашигтай бичил биетэн агуулсан зохицуулах үйлчилгээтэй хүнсний үйлдвэрлэлд” төрөөс дэмжлэг, урамшуулал үзүүлэх тухай заалт тусгагдсан.

“Намрын ногоон өдрүүд-2013” үзэсгэлэн худалдааны үеэр баяжуулсан хүнсний ач холбогдлын талаар сурталчилгаа явуулав. Архангай аймагт эх, хүүхдэд шаардлагатай баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийг дэмжих хөдөлгөөн өрнүүлэн жирэмсэн, хөхүүл эх, 0-5 насны хүүхэд бүхий 359 эмзэг бүлгийн өрхөд халгай, сүү, аарц, жимс, өндөгөөр баяжуулсан шинэ хүнсийг бага савлагаатайгаар хүргэж үйлчилсэн. Цэцэрлэгийн багш, тогооч, эмнэлгийн ажилтан, эцэг эх, асран хамгаалагч нарыг өөрсдөө гарын доорх материалыг ашиглан хүүхдийн хоол баяжуулах арга ажиллагаанд сургах арга хэмжээ авч байна.

ХШҮ-50%

Үйл ажиллагаа 13.3. *Хүнсний бүтээгдэхүүнийг А, Д, Е аминдэм, эрдэс бодисоор баяжуулах технологийг нэвтрүүлэхэд аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.*

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр сүүг Д аминдэмээр баяжуулах технологийг ГУМ ХХК- д нэвтрүүлэхээр технологийн туршилт хийсэн. Хүнсний технологийн “Хамаг Монгол” мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв Япон улсын 680 мянган ам долларын санхүүжилт бүхий төсөл хэрэгжүүлж, хүүхдэд зориулсан С аминдэмээр баяжуулсан жимс, ногооны нухаш үйлдвэрлэн, “Үдийн цай” хөтөлбөрт нийлүүлж байна.

“Насанд хүрсэн монгол хүний сийвэн дэх селений дундаж хэмжээ, зарим хавдар, зүрх судасны өвчний харилцан хамаарал судалгаа” сэдэвт шинжлэх ухааны төсөлт ажил Нийгмийн эрүүл мэндийн төвд хийгдэж байна. Мөн “Өндгийг селенээр баяжуулах судалгаа”-ны төсөл хэлэлцүүлгийн шатанд байна.

- ҮХААЯ-наас зохион байгуулсан ”Буудайн гурил үйлдвэрлэх, баяжуулах технологи, хяналт” сэдэвт сургалтанд орон нутгийн 3 үйлдвэрийн 7 мастер, лаборант, мэргэжилтэнг хамруулж, үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах эрхийн үнэмлэх олгосон
- Нийслэлийн захирагчийн ажлын албанаас “Хавдраас сэргийлэх үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүн”, хүний бие махбодь болон тодорхой нэг эрхтэний үйл ажиллагааг дэмжих биологийн идэвхт бодис, ашигтай бичил биетэн агуулсан зохицуулах үйлчилгээтэй хүнсний нийт 11 төрлийн зөвлөмж боловсруулан бэлтгэж ubservice.mn сайтад байршуулан тогтмол булан ажиллуулж байна.

Сүүний сургалтын үндэсний төв “Пропион хүчлийн бактериар баяжуулсан зөөлөн бяслаг үйлдвэрлэх”, “Бифидобактерийн цэвэр өсгөврийн хөрөнгө ашиглан аарц үйлдвэрлэх” инновацийн төсөл хэрэгжүүлж, жижиг үйлдвэрийн нөхцөлд нэвтрүүлсэн.

ХШҮ-70%

Үйл ажиллагаа 13.4. Зохицуулах үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

Аймаг, нийслэлд зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний үйлдвэрлэл 2007 оныхоос 74%-иар нэмэгдсэн байна. “Дорнод гурил” ХХК 2011 онд Швейцарын Buhler брэндийн дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, буудайн чанарыг ширхэгээр нь гэрлийн өнгөөр ялгаж, эрүүл чанартай буудайгаар баяжуулсан гурил, “Онхоодой-Өндөр” ХХК бүхэл үрийн талх, “Бабуб” ХХК хүүхдэд зориулсан зөгийн балтай печень, “БД” ХХК олон төрлийн жимсний найрлагатай жүүс үйлдвэрлэсэн.

Цаашид хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох талх, нарийн боов, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түшиглэн орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, бүтээлч сэтгэлгээг дэмжих замаар эрүүл органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Зохицуулах үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүнийг төрөл бүрийн талх, гурилан бүтээгдэхүүн хэлбэрээр Архангай аймгийн “Гост трейд”, “Баялаг”, Хөвсгөл аймгийн “Алтан жолоо” ХХК-иуд үйлдвэрлэн борлуулж байна.

Uniline, Unimax хоёр урсгал шугам суурилуулж ТАЧИ болон Зохицуулах үйлчилгээтэй органик нарийн боовнуудыг үйлдвэрлэж байна.

ХШҮ-70%

ТАВ. ҮНЭЛГЭЭ

Зорилтын үнэлгээ. Хөтөлбөрт дэвшүүлсэн 13 зорилтыг хангах хүрээнд 86 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр заасан бөгөөд 2014 оны байдлаар зорилтын гүйцэтгэлийн дундаж 80.1 хувьтай байна.

**“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

Зорилт	Үйл ажиллагаа	ХШҮ, %					Дундаж дүн
		100	90	70	50	30	
1.Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг ойрын болон хэтийн хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсронгуй болгох;	11	1	4	6			80.0
2.Эдийн засаг, санхүү, бизнесийн таатай орчин бүрдүүлж дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;	5	1	3	1			88.0
3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын бүтэц, салбар дундын зохицуулалт болон боловсон хүчний чадавхийг сайжруулах;	7		4	3			81.4
4.Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах;	9		7	1	1		83.3
5.Хот, хөдөөгийн болон улирлаас хамаарах хүнсний хүртээмжийн ялгааг багасгах;	4		2	2			80.0
6.Байгалийн гамшиг, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнсний хомсдлын үед хүн ам, ялангуяа эмзэг бүлгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах;	5	1	1	3			80.0
7.Хүнсний үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулж Монгол брэндийн хүнс экспортлох нөхцөлийг бүрдүүлэх;	8		5	2	1		80.0
8.Хүнсний түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүх дамжлагад хөдөө аж ахуй, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлуудыг нэвтрүүлж бүтээгдэхүүний эрүүл ахуйн баталгааг хангах;	11		4	5	2		73.6
9.Хүнсний аюулгүй байдлын хяналт, мэдээллийн сүлжээ, үйл ажиллагааг сайжруулах;	4		3	1			85.0
10.Ундны усны хүртээмж, чанар, эрүүл ахуйг сайжруулах;	6	1	3	2			85.0
11.Монгол хүний зохистой хоололтын зөвлөмжийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, хоол тэжээлийн талаархи хүн амын боловсролыг дээшлүүлэх;	4		3	1			85.0
12.Хоол тэжээлтэй холбоотой өвчин, эмгэгээс сэргийлэх, хяналт тавих;	8	1	4	2	1		81.3
13.Зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх.	4			2	2		60.0
Дүн	86	5	43	31	7	0	80.1

Үр дүнгийн үнэлгээ: Хөтөлбөрийн 2 дах үе шатанд гарах 17 үр дүнг 2016 онд хүрэх түвшинтэй нь төлөвлөсөн. Эдгээр 17 үр дүн нь 43 дэд хэсэгт хуваагдах бөгөөд 2014 онд 32 дэд хэсгийн хүрсэн түвшингээр үр дүнгийн гүйцэтгэлийг тооцсон. Бусад 11 дэд хэсгийн биелэлт тухайн үзүүлэлтийн биелэлтийг хэрхэн тооцох нь тодорхойгүй, улсын нууцын зэрэглэлтэй, судалгаа, мэдээлэл дутуу байгаагаас шалтгаалан үнэлэх боломжгүй байна. Үр дүнгийн гүйцэтгэл дунджаар 50.7 хувийн биелэлттэй байна.

Үр дүн, хүрэх түвшин /2016 он/		Гүйцэтгэл 2014	Биелэлт %
Нэгдүгээр тэргүүлэх чиглэл.			
1.	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, ариун цэврийн хяналт олон улсын нийтлэг жишигт хүрсэн байна.	“Хүнсний тухай” болон “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн хүрээнд 32 журам, аргачлал, дүрэм, зааварчилгааны төсөл боловсруулснаас 19 нь батлагдаад байна.	50.0
2.	Хүнсний аюулгүй байдлын үнэлгээг олон улсад хэрэглэдэг нийтлэг арга, үндэсний стандартад нийцүүлэн хийж, үр дүнг нийтэд мэдээлдэг болсон байна.	ЭМ-ийн сайдын 2014 оны 384 дүгээр тушаалаар “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн жагсаалт”-ыг баталсан. Эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн.	50.0
Хоёрдугаар тэргүүлэх чиглэл.			
3.	Хот орчмын сүүний чиглэлийн фермерийн аж ахуйнуудаас жилд 40.0 мянган тонн сүү нийлүүлнэ. Үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээг 2012 оноос 2 дахин нэмэгдүүлнэ	Сүүний чиглэлийн фермерийн аж ахуйнуудаас 2014 онд 64.6 мянган тонн сүү нийлүүлсэн байна.	90.0
		Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ 2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр 73.1 мянган тоннд хүрсэн нь 2012 оныхоос /53.2 / 1.4 дахин их байна.	100.0
4	Махны экспортыг 38.0 мянган тоннд хүргэж, хот суурингийн хүн амын хэрэгцээт махны 60-аас доошгүй хувийг үйлдвэрийн аргаар боловсруулдаг болсон байна.	2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2.3 мянган тонн мах экспортод гаргасан.	10.0
		Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээ 20.5 мянган тоннд хүрсэн. Нөөцийн махаар Улаанбаатар, Дархан-Уул, Эрдэнэтийн хүн амын хаврын махны хэрэгцээний 16.2 хувийг хангаж байна.	10.0
5	Хүнсний ногоо, өндөгний хэрэгцээг бүрэн, цөцгийн тосны 20, загасны 25, жимсний 15, будааны 5, ургамлын тосны 40-өөс доошгүй хувийг дотооддоо үйлдвэрлэдэг болсон байна. (Энэ заалтад 2011-04-13-ны 114-р тогтоолоор нэмэлт орсон)	Хүнсний ногоо	54.0
		Өндөг	
		Цөцгийн тосны	
		Загасны 0.5 хувийг хангасан.	20.0
		Жимсний 1 хувийг хангасан.	6.66
		Будааг туршилтаар тарьсан.	0.0
6	Гамшгийн үеийн нөөцийн гурилыг 20 хоногийн, цагаан будаа, элсэнчихрийг 15 хоногийн хэрэгцээтэй тэнцэх, стратегийн нөөцийн улаан буудайг нийт хэрэгцээний 50 хувьд хүргэсэн байна.	Ургамлын тосны 1хувийг дотооддоо үйлдвэрлэсэн. /хүчин чадал 33 сая л, 2014 онд 2 сая литрийг үйлдвэрлэсэн/	2.5
		Нөөцийн гурил	Улсын нууцын зэрэглэл тэй тул дүгнэх боломжгүй.
		Цагаан будаа	
		Элсэн чихэр	
Стратегийн нөөцийн улаан буудай нийт хэрэгцээний			


7	Газар тариаланд хэрэглэх бордооны 30 хувийг, ургамал хамгааллын бодисын 20 хувийг дотооддоо үйлдвэрлэж, газар тариалангийн чиргүүл, дүүжин машины 50 хувь, өөрөө явагч техникийн 70 хувийг шинэчилсэн байна	“888” төслийн хүрээнд “Хиру” ХХК бордоо үйлдвэрлэх зорилгоор 8.9 сая төгрөгийн зээл авсан ба азофос, шим бордоо, бактерит бордоо үйлдвэрлэн төмсний тариалалтанд хэрэглэх бордооны 30%-ийг дотоодоосоо үйлдвэрлэж байна.	10.0
		Газар тариалангийн чиргүүл, дүүжин машины 55 хувийг шинэчилсэн.	100.0
		Өөрөө явагч техникийн 65 хувийг шинэчилсэн байна	100.0
		Ургамал хамгааллын бодис дотооддоо үйлдвэрлэдэггүй.	0.0
8	Бүх сумын 60-70 хувь нь бөөний худалдааны сүлжээ, салбартай болсон байна.	Бөөний худалааны төвийг 18 аймагт байгуулж 116 сумыг буюу 35.2 хувийг хамруулсан.	58.6
9	Хот суурингийн орчимд хөдөө аж ахуйн болон боловсруулах үйлдвэрийн 25-аас доошгүй цогцолбор бий болно.	“Гацуурт” махны үхэр-махны үйлдвэр, “Ажигана” ХХК-ийн “Оргю” тахианы аж ахуй-үйлдвэр, “Мон тариамал” ХХК-ийн Баянчандмань дах сүүний ферм-сүү боловсруулах үйлдвэр, Орон нутагт 11 гурилын үйлдвэр-газар тариалангийн цогцолбор.	70.0
10	Тариаланд шаардагдах нийт үрийн 60-80 хувийг I-III зэргийн үрээр тариалдаг болж, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 54.0 мянган га-д хүргэж, нийт ургацын 15-аас доошгүй хувийг усалгаатай талбайгаас авдаг болно. (Энэ заалтыг 2011-04-13-ны 114-р тогтоолоор нэмсэн)	Тариаланд шаардагдах нийт үрийн 70 хувийг I-III зэргийн үрээр тариалдаг болсон.	100.0
		Усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 54.0 мянган га-д хүрсэн	100.0
		Нийт ургацын 31 хувийг усалгаатай талбайгаас авч байна.	100.0
Гуравдугаар тэргүүлэх чиглэл.			
11	Хүнсний үйлдвэрүүдэд дотоод хяналтын тогтолцоо бүрэн нэвтэрч, чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг зах зээлээс буцаан татах журам бий болж мөрдөгдөнө.	“Хүнсний туухий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам” Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 172 дугаар тогтоолоор батлагдсан. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн журмын төсөл боловсруулсан.	90.0
12	Хүнсний үйлдвэрүүдийн 60 хувьд аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР), үйлдвэрийн эрүүл ахуйн зохистой дадал (GHP), үйлдвэрийн зохистой дадал (GMP) нэвтэрсэн байна.	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх аргачлал, зөвлөмжийн төсөл боловсруулсан. НАССР тогтолцоог "Дархан meat фүүдс" ХХК –ийн Мал төхөөрөх, сэврээх, хэсэглэх, ангилах, савлах, хөлдөөх, хадгалах үйл ажиллагаа, “Мах маркет” ХХК-ийн Махны үйлдвэрийн мах шулж, ангилах савлах цех нэвтрүүлээд байна.	10.0
		Эрүүл ахуйн зохистой дадал, Үйлдвэрийн зохистой дадал нэвтрүүлэх хялбаршуулсан зааврын төслийг боловсруулсан.	10.0
		Сүргэлт зохион байгуулсан.	10.0

13	Хөдөө аж ахуйн фермерүүдийн 55-аас доошгүй хувьд нь хөдөө аж ахуйн зохистой дадал (GAP) нэвтэрсэн байна.	Хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх хялбаршуулсан зааврын төсөл боловсруулсан. Сургалт зохион байгуулсан.	10.0
14	Хоол хүнсээр дамжих өвчлөл буурсан байна	2013 онд улсын хэмжээнд 30 төрлийн халдварт өвчний 37320 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 5985 тохиолдлоор буурч өвчлөл 10 000 хүн амд 132.7 байна 2014 онд хоол хүнснээс үүдэлтэй дэгдэлт 10 удаа гарч 766 хүнийг хамарсан.	100.0
Дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл.			
15	Тав хүртэл насны хүүхдийн дундах тураал 3.8 хувь, өсөлт хоцролт 9.8 хувь, туранхай 0.2 хувь, Д аминдэмийн дутал 25 хувь, А аминдэмийн дутал 6 хувь, цус багадалт 10.7 хувь, 7-12 насны хүүхдийн бахлуур өвчний тархалт 3 хувь, хөхүүл эхчүүдийн дундах А аминдэмийн дутал 11.5 хувь, жирэмсэн эмэгтэйчүүдийн цус багадалт 10 хувь хүртэл буурч, Монгол Улсын Мянганы Хөгжлийн зорилт хангагдсан байна.	2013 оны байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хоцролттой 10.8%	90.8
		тураалтай 1.6%	100.0
		туранхай 1.0%	20.0
		Д аминдэмийн дутал	-
		А аминдэмийн дутал 6 хувь	-
		цус багадалт	-
		7-12 насны хүүхдийн бахлуур өвчний тархалт 7.4% /Хүн амын хоол тэжээлийн Үндэсний IV судалгаа-2010/	40.5
		Хөхүүл эхчүүдийн дундах А аминдэмийн дутал	-
16	Хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэж байгаа хүн амын хувь 2012 оныхоос 50 хувь буурсан байна.	Мэдээлэл судалгаа байхгүй.	-
17	Хүн амд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үндэсний тогтолцоог бүрдүүлсэн байна.	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/18 тоот тушаалаар батлагдсан “Улсын хэмжээнд тооцсон амьжиргааны түвшний 5 хувийн шугамаас доогуурт багтсан хүн амын хамгийн бага хэрэглээтэй хэсэг болох нийт 16535 өрхийн 97918 иргэнд хүнсний эрхийн бичиг олголт хийгдэж байна.	70.0
Дундаж үнэлгээ			50.7

Хөндлөнгийн үнэлгээ “Эдийн засгийн хөгжил, сургалт, судалгааны төв” ТББ-аас ХХААЯ-ны үйл ажиллагаанд өгч буй хэрэглэгчийн үнэлгээг хийж, баруун бүсээс Баян-Өлгий, Завхан, хангайн бүсээс Баянхонгор, Булган, төвийн бүсээс Дундговь, Төв, Дорноговь, Говьсүмбэр, зүүн бүсээс Дорнод, Хэнтий, Сүхбаатар зэрэг 11 аймгийн 57 сумыг хамруулсан байна. Нийт 10125 хүнтэй биечлэн уулзаж санал асуулга авснаас хүнс, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын 2025 /20 хувь/ төлөөлөл байгаа бөгөөд судалгаанд хамрагдагсдын 98 хувь нь 10 хүртэл ажилтантай үйлдвэр, үйлчилгээний газрын хүмүүс байна. Хүнс, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэрийн салбарын үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ 2014 онд 3.91 балл буюу 78.2 хувьтай дүгнэгдсэн нь өмнөх оныхоос 6.8 хувиар өссөн байна.

Гэвч хөдөөд хүнсний болон эмийн бөөний худалдааны сүлжээ, найдвартай худалдааны төв байхгүйгээс ганзагын наймаачдын зарж буй эх үүсвэр нь тодорхой бус хүнсний бүтээгдэхүүн болон эм тариаг хэрэглэж байгаа нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгааг судалгаанд дурджээ. Мөн хүнсний аюулгүй байдлын талаарх хөтөлбөр, төслийн талаарх мэдээлэл хангалтгүй байгааг судалгаагаар тогтоосон байна.

Ихэнх аймгийн хэрэглэгчид түүхий эдийн чанарт сэтгэл хангалуун буюу дунджаас өндөр үнэлгээ өгчээ. Түүхий эдээ хаанаас бэлтгэдэг вэ гэсэн нээлттэй асуултанд ихэнх нь дотоодоос буюу өөрсдөө бие даан бэлтгэдэг гэсэн хариулт өгчээ. Өөрсдөө бэлтгэдэг нь хамгийн сайн түүхий эд бэлтгэж, үйлдвэрлэлээ бүтээмжтэй явуулах боломж олгох юм.



ЗУРГАА. ДҮГНЭЛТ

1. Ололт, амжилт

“Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хүнсний үйлдвэрийн салбарт 2014 онд гарсан ололт, үр дүн:

- ❖ Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй бадлыг хангах тухай хуулиудад заасан журам, дүрэм, заавар, аргачлал боловсруулах ажлын явц 70 хувьтай байна.
- ❖ Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, оны үнээр 2014 онд 896599.2 сая төгрөгт хүрсэн нь 2013 оныхтой харьцуулахад 17.1 хувиар нэмэгдсэн бөгөөд мах загас, жимс ногоо өөх тос боловсруулалтын дэд салбараас бусад дэд салбарын үйлдвэрлэл өссөн байна.
- ❖ Зөвхөн аймаг орон нутагт 2014 онд урьдчилсан судалгаагаар хүнсний чиглэлийн 15 үйлдвэр, 114 цех шинээр ашиглалтад орсноос гурилын 7 үйлдвэр 47 цех, сүү, сүүн бүтээгдэхүүний 6 үйлдвэр, 30 цех, төмс, хүнсний ногоо боловсруулах 2 үйлдвэр, 8 цех, мах, махан бүтээгдэхүүний 12 цех, мал нядалгааны 13 цех бусад чиглэлийн 4 цех байна.
- ❖ Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд махны жижиглэн худалдаалах үнийн хэлбэлзэл (жилийн дундаж өсөлтөөр тооцов) өнгөрсөн оныхоос 2.3 дахин бага, хөтөлбөр хэрэгжүүлэхээс өмнөх 3 жилийн дунджаас 5.1 дахин бага байна. Улаанбаатар хотын жилийн инфляцид махны үнийн өсөлтийн тодорхойлох хувь 2013 онд 1.9 байсан бол 2014 оны 12 дугаар сарын байдлаар 0.9 хувьтай байна.
- ❖ Сүү болон махны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрчимжсэн аж ахуйн тоо, тэдгээрийн малын толгой өсч хүнсний түүхий эдийн улирлын хамаарлыг бууруулах боломжийг нэмэгдүүлж байна.
- ❖ “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон зээлийн дэмжлэгийн дүнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний агуулах, зоорийн багтаамж сайжирч, хадгалалтын явц дах түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах нөхцөл сайжирч байна.

- ❖ Төмс 13.2 мянган га талбайд тариалж 161.5 мянган тонн ургац, хүнсний ногоо 8.7 мянган га талбайгаас 104.8 мянган тонн ургац тус тус хураан авсан. Үүний үр дүнд жилийн хэрэгцээт төмсний 100.0 хувь, хүнсний ногооны 54.0 хувийг дотоодын ургацаас хангах боломжийг бүрдүүлэв.

2.Дутагдал, анхаарах асуудал

- ❖ “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг зорилт, үр дүнгийн хүрэх түвшинтэй уялдуулан он оноор баталж хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдах зохицуулах үүрэгтэй хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах талаар хангалтгүй байна.
- ❖ Шаардлагатай санхүүжилтийг тооцон тухайн жилийн төсөвт тусгах талаар орон нутаг, хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд хангалтгүй ажиллаж байна.
- ❖ Хэрэглэгчийн үнэлгээний дүнгээс хөтөлбөрийн талаарх ойлголт, мэдээлэл орон нутагт дутмаг байна.
- ❖ ХАА болон хүнсний үйлдвэрлэлд зохистой дадал, эрүүл ахуйн дадал, бусад олон улсын стандарт, систем нэвтрүүлэх, баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний эрх зүйн орчин бүрдүүлэх, хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой үйл ажиллагааны хэрэгжилт удаашралтай байна.
- ❖ Хөтөлбөрийн үр дүн, хүрэх түвшин болон орон нутаг, хувийн хэвшил бусад эх үүсвэрээс оруулсан санхүүжилтийн талаарх мэдээлэл дутмаг байна.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

1. Хөтөлбөрийн зорилт, үр дүнгийн хүрээнд хэрэгжилтийн түвшин нь доогуур үнэлгээтэй заалтын биелэлтийг эрчимжүүлэх удирдлага, зохион байгуулалтын бодитой арга хэмжээ авах;
2. Хэрэгжүүлэх арга хэмжээний жил бүрийн төлөвлөгөөг шаардлагатай зардлын тооцооны хамт гаргаж санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар анхаарах;
3. Хүнсний салбарын эрх зүйн орчин, орон нутаг дахь харьяа байгууллагын зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан аймаг, нийслэлийн үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын хүнсний үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг салбарын менежментийг сайжруулах, судалгаа, тооцооны шинэ арга зүй эзэмшүүлэх чиглэлээр нэгдсэн сургалтад хамруулах;
4. Хүнсний үйлдвэр, нийтийн хоолны газар, тэдгээрийн хүчин чадал, ашиглалт, зээл тусламжид хамрагдсан байдал, түүхий эдийн хангамж, хүний нөөц, борлуулалтын сүлжээ зэрэг хүнс үйлдвэрлэлийн бүх шатанд шаардлагатай мэдээллийн бааз бүрдүүлэх судалгааны хэрэгцээг тодорхойлж, эрэмбэлэн судалгаа явуулах;
- 5.“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан аймгийн “Хүнсний аюулгүй байдал” дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шаардлагатай санхүүжилт бусад асуудлыг шийдвэрлэж, хэрэгжилтийг эрчимжүүлэх;
6. Аймаг бүр өөрийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгон баталгаажуулахад анхаарч, хүнсний брэнд бүтээгдэхүүний найрлага, стандартыг баталгаажуулах, сав, баглаа боодол, шошгоны стандартыг мөрдөж, брэнд бүтээгдэхүүний технологийг улам боловсронгуй болгон нийтийн хэрэгцээнд нийлүүлэх болон экспортлох боломжийг бүрдүүлэх, бүтээгдэхүүний сурталчилгааг сайжруулах;

7. Гарал үүслийн баталгаажуулалт олгох талаарх чадавх бүрдүүлэх, гэрчилгээжүүлэх ажлыг эрчимжүүлэх;
8. Хүнсний үйлдвэр цехийн үйл ажиллагаа, өрхийн тариалан эрхлэлтийг дэмжиж, хүн амын хүнсний хэрэглээнд чухал ач холбогдол бүхий органик гаралтай шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
9. “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийн хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах асуудлаар Статистикийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Стандартын хэлтэс, Эрүүл мэндийн газар зэрэг аймгийн Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах;
10. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд ХШҮ хийж өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу хийсэн ажлын биелэлтийг хөтөлбөрийн тайланд хавсарган 2016 оны 1 дүгээр сарын 10-ны дотор ХХААЯ-ны ХШҮДАГ-т ирүүлэх.